



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 373

Улаанбаатар хот


“Даатгалын компанийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”,
“Даатгалын компанид мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны үлгэрчилсэн заавар”-уудыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2, Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын 1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Даатгалын компанид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ыг нэгдүгээр, “Санхүүгийн тайлангийн А маягт”-ыг хоёрдугаар, “Санхүүгийн тайлангийн Б маягт”-ыг гуравдугаар хавсралтаар, “Даатгалын компанид мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны үлгэрчилсэн заавар”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү зааврыг 2013 оны 01дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. Бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн тохируулгыг НББОУС-8 “Нягтлан бодох бүртгэлийн бодлого, тооцоололтын өөрчлөлт ба алдаа”-д заасны дагуу 2013 оны нэгдүгээр улирлын тайланд тусгахыг даатгалын компанийн удирдлагад үүрэг болгосугай.
4. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Х.Бум-Эрдэнэ)-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



**ДААТГАЛЫН КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТОДРУУЛГЫГ БЭЛТГЭХ ЗААВАР**

Нэгдүгээр бүлэг: НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1. Даатгалын компани нь нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхэд энэ зааврыг мөрдөнө. Харин даатгалын мэргэжлийн оролцогч болох Хохирол үнэлэгч болон зуучлагч нь Сангийн сайдын 2012 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 77 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ыг мөрдөнө.
2. Даатгалын компани нь жилийн санхүүгийн тайланг “А” маягтаар, улирлын санхүүгийн тайланг “Б” маягтаар гаргана.¹
3. Санхүүгийн тайлан, тодруулгын үзүүлэлтийг төгрөг, мөнгөөр илэрхийлнэ.
4. Санхүүгийн тайлан, тодруулгын хасагдах утгатай дүнг хасах тэмдэгтэйгээр харуулна.
5. Даатгалын компани нь тодруулбал зохих мэдээллийг заавал тодруулна. Тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамаарч зарим нэг тодруулгыг заавал тодруулахгүй байж болно.

Санхүүгийн тайлангийн зорилт

1. Санхүүгийн тайлан нь гадны болон дотоодын хэрэглэгчдийг эдийн засгийн шийдвэр гаргахад нь шаардагдах тухайн байгууллагын санхүүгийн байдал (хөрөнгө, эздийн өмч, өр төлбөр), санхүүгийн үр дүн (орлого, үр дүн), санхүүгийн байдалд гарсан өөрчлөлт (мөнгөн гүйлгээний) - ийн талаарх мэдээллээр хангана.
2. Санхүүгийн тайланг хугацаанд нь үнэн зөв гаргах үүрэг, хариуцлагыг Даатгалын компанийн удирдлага хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэх

Даатгалын компани нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ дараах ерөнхий зарчмыг баримтална. Үүнд:

1. Санхүүгийн тайланг энэ заавар болон СТОУС² - ын бүх шаардлагад нийцүүлэн гаргахын тулд аж ахуйн нэгжийн удирдлага нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулан мөрдөх;
2. Аж ахуйн нэгжийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчмаар гаргах;

¹Улирлын тайланг жилийн эхнээс өссөн дүнгээр гаргана.

²Энэ зааварт Санхүүгийн Тайлагнапын Олон Улсын Стандарт (СТОУС) гэж дурьдсаныг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартен Зөвлөл (НББОУС - ын Зөвлөл) - өөс баталсан стандарт болон тайлбарыг хамаатуулж ойлгоно.

3. Аж ахуйн нэгж нь мөнгөн гүйлгээний мэдээллээс бусад санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар³ бэлтгэх;
4. Санхүүгийн тайлан дахь толилуулга ба ангиллыг нэг үеэс дараагийн үед тогтвортой хадгалах;
5. Даатгалын компанийн санхүүгийн тайлан нь өмнөх үеийн болон бусад байгууллагын санхүүгийн тайлантай зэрэгцүүлэх боломжтой байх;
6. Санхүүгийн тайланд материаллаг зүйлсийг тусад нь толилуулна. Материаллаг бус дүнтэй зүйлсийг шинж чанар буюу үүргийнх нь дагуу ижил зүйлсийн дүнтэй нэгтгэн толилуулах;
7. Энэ заавар болон Санхүүгийн тайлагналын олон улсын холбогдох стандартаар цэвэр дүнг гаргахыг шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд аж ахуйн нэгж хөрөнгө, өр төлбөр эсвэл орлого, зардлыг цэвэр дүнгээр гаргахгүй байх.

Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн

Иж бүрэн санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайлан;
2. Орлогын дэлгэрэнгүй тайлан;
3. Өмчийн өөрчлөлтийн тайлан;
4. Мөнгөн гүйлгээний тайлан;
5. Санхүүгийн тайлангийн тодруулга орно.

Санхүүгийн тайлангийн толилуулга

Даатгалын компани нь дараах мэдээллийг толилуулна. Үүнд:

1. Тайлагнагч аж ахуйн нэгжийн нэр, өмнөх тайлант үеийн эцсийн мэдээлэл дэх аливаа өөрчлөлт;
2. Санхүүгийн тайлан нь тусдаа санхүүгийн тайлан⁴ болох тухай;
3. Тайлант үеийн эцсийн өдөр, санхүүгийн тайлан эсхүл тодруулгын хамрах хугацаа;
4. Толилуулгын валют⁵.

Хоёрдугаар бүлэг: САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Санхүүгийн байдлын тайлангийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч гэж ангилна. Даатгалын компани бүр өөрийн үндсэн үйл ажиллагааны шинж чанарт

³ Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь гэж мөнгө хүлээн авсан эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон уед, зардлыг гарсан уед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ.

⁴Тусдаа санхүүгийн тайлан гэж охин компанийн хөрөнгө оруулагч болох *тогтой компанийн*, хамтарсан хяналттай аж ахуйн нэгжид хөрөнгө оруулалттай буюу мэдэгдэхүйц нөлөөтэй, хөрөнгө оруулалтаа өртгийн аргаар аль эсхүл СТОУС 9 *Санхүүгийн хэрэгүүр*-ийн дагуу бүртгэдэг хөрөнгө оруулагчийн толилуулж буй санхүүгийн тайланг хэлнэ.

⁵ Толилуулгын валют гэж санхүүгийн тайланг толилуулахад ашиглаж буй валютыг хэлнэ.

үндэслэн хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд ангилан, тодорхой хугацаагаар (улирал, жил) тасалбар болгон толилуулна.

Хөрөнгө

Хөрөнгийг⁶ эргэлтийн, эргэлтийн бус гэж ангилна.

Эргэлтийн хөрөнгө

Дараах хөрөнгийг эргэлтийн хөрөнгөнд хамааруулан ойлгоно. Үүнд:

- а) Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны циклийн хэвийн нөхцөлд ашиглахаар хүлээгдэж байгаа, эсхүл худалдан борлуулахаар эзэмшиж байгаа;
- б) Нэн түрүүнд борлуулах зорилгоор эзэмшиж байгаа;
- в) Тайлант өдрөөс хойш 12 сарын дотор хэрэгжихээр хүлээгдэж байгаа;
- г) Хөрөнгийн солилцоог хязгаарласнаас бусад тохиолдолд, тайлант өдрөөс хойш 12 сарын дотор өр төлбөрийг барагдуулахад ашиглах мөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгө.

Эргэлтийн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд дараах байдлаар ангилан толилуулна. Үүнд:

1. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Касс болон банкны харилцах дансанд байгаа мөнгө, хугацаагүй хадгаламж, 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарласан тусгай зориулалт бүхий мөнгөн сан, үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацаатай хөрөнгө оруулалт хамаарна. Эдгээр хөрөнгийг нэрлэсэн нээр нь бүртгэнэ.

2. Дансны авлага

Даатгалын компанийн үндсэн үйл ажиллагааны явцад үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө даатгуулагч болон давхар даатгагчаас авах даатгалын хураамжийн авлага, давхар даатгалын нөхөн төлбөрийн авлагын дүн орно. Дансны авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд харуулна.

3. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), бусад татвар, төлбөр, хураамжийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцсээрх илүү төлөгдсөн дүн орно. Улирал ба жилийн эцэс дэх татвар,

⁶ Хөрөнгө гэж аж ахуйн нэгжийн өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болсон, ирээдүйн эдийн засгийн үр өгөөж өгөхөөр хүлээгдэж буй нөөцийг хэлнэ.

нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын дүн нь татвар, нийгмийн даатгалын байгууллагын баталгаажуулсан дүнтэй тэнцүү байна.

4. Бусад авлага

Бусад байгууллага, хувь хүн, холбоотой талд өгсөн нэг хүртэлх жилийн хугацаатай буюу үйл ажиллагааны нэг циклийн дотор эргэн төлөгдөх зээл, үндсэн үйл ажиллагаатай холбогдолгүй үүссэн бусад авлага хамаарна.

5. Бусад санхүүгийн хөрөнгө

Үүнд 3 сараас нэг жилийн хугацаатай хадгаламж, богино хугацаат өрийн болон өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт хамаарна. Санхүүгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгахад *СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга*, *СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр*, *НББОУС 32 Санхүүгийн хэрэглүүр: Толлуулга* - ийг дагаж мөрдөнө.

6. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсэг

СЗХ-ноос баталсан журмын дагуу орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийг тодорхойлж санхүүгийн байдлын тайлангийн энэ хэсэгт харуулна.

7. Даатгалын нөөцийн давхар даатгагчид ноогдох хэсэг

СЗХ-ноос баталсан журмын дагуу даатгалын нөөцийн давхар даатгагчид ноогдох хэсгийг тодорхойлж санхүүгийн байдлын тайлангийн энэ хэсэгт харуулна.

8. Бараа материал

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө, үйлдвэрлэлийн дамжлагад байгаа зүйлс болон үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэх материал, хангамжийн зүйлс хамаарна.

НББОУС 2 *Бараа материал* - д заасны дагуу бараа материалыг өртөг⁷ болон цэвэр боломжит үнийн аль багаар нь үнэлнэ. Бараа материалын цэвэр боломжит үнийг тайлант үе бүрийн эцэст тооцно.

Санхүүгийн байдлын тайланд бараа материалыг дансны цэвэр дүнгээр нь толилуулж, санхүүгийн тайланд дараах байдлаар тодруулна. Үүнд:

- (а) Түүхий эд материал: үндсэн түүхий эд, туслах материал;
- (б) Дуусаагүй үйлдвэрлэл: үйлдвэрлэж дуусаагүй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртөг;
- (в) Бараа, бэлэн бүтээгдэхүүн: борлуулах зориулалттай үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, борлуулах зорилгоор бусдаас худалдан авсан бараа;

⁷ Бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбоотой гарсан зардлууд орно. Үйлчилгээний байгууллагын хувьд бараа материалын өртгийг үйлдвэрлэлийн өртгөөр хэмжих бөгөөд өртөгт нь үйлчилгээ зүүлэхэд шууд оролцож буй ажилчдын хөдөлмөрийн болон бусад нэмэлт зардлуудыг хамруулна.

(г) Хангамжийн материал: аж ахуйн үйл ажиллагаанд ашиглагдах, цаашдаа зардал болгох хангамжийн материал, шууд зарцуулагдах багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, шатах тослох материал, бусад хангамжийн шинжтэй зүйлс хамаарна.

9. Урьдчилж төлсөн зардал/тооцоо

Тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зарлагыг (даатгалын төлөөлөгч, зуучлагчийн шимтгэл, түрээс г.м) санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн зүйл ангид хамааруулж, урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ. Ийм төрлийн зарлагыг дараагийн тайлант үеийн холбогдох зардалд нь шингээнэ.

Бараа материал, бусад зүйлсийг худалдан авахаар төлсөн урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоонд хамааруулна.

10. Бусад эргэлтийн хөрөнгө

Дээр тусгайлан толилуулснаас бусад эргэлтийн хөрөнгө (тухайлбал, эргэлтийн биологийн хөрөнгө) хамаарна.

11. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)

Эргэлтийн бус хөрөнгө (эсвэл борлуулах бүлэг хөрөнгө) - ийн дансны үнийг үргэлжлүүлэн ашиглах замаар биш борлуулах замаар нөхөн олж авах бол уг хөрөнгө (эсвэл борлуулах бүлэг хөрөнгө) - ийг “Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө” гэж ангилна. Энэхүү хөрөнгө (эсвэл борлуулах бүлэг хөрөнгө) - ийг *СТОУС 5 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа* - д заасны дагуу бүртгэнэ.

Эргэлтийн бус хөрөнгө

Санхүүгийн байдлын тайланд эргэлтийн бус хөрөнгийг дараах байдлаар ангилан толилуулна. Үүнд:

1. Үндсэн хөрөнгө

Нэгээс дээш тайлант хугацаанд үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, бусдад түрээслүүлэх эсхүл захиргааны зориулалтаар ашиглаж байгаа биет хөрөнгө үндсэн хөрөнгөнд хамаарна.

Үндсэн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дансны цэвэр дүнгээр нь толилуулна.

Үндсэн хөрөнгийн ангилал

Үндсэн хөрөнгийг шинж чанар, үйл ажиллагаанд ашиглагдах байдлаар нь ангилна. Үүнд:

- (а) Газрын сайжруулалт: Нийтийн эзэмшлийн газар дээр хийгдсэн явган хүний зам, ногоон байгууламж болон бусад газрын сайжруулалтууд;
- (б) Барилга байгууламж: Бүх торлийн барилга, түүний бүрэлдэхүүнд хамаарах халаалт, ус, агааржуулалт, цахилгааны систем, зам, гүүр, янз бүрийн талбай зэрэг

дэд бүтцийн шинжтэй зүйлс;

- (в) Машин, тоног төхөөрөмж: Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай бүх төрлийн машин механизмаас гадна дамжуулах төхөөрөмж, нэмэгдэл төхөөрөмжүүд;
- (г) Тээврийн хэрэгсэл : Бүх төрлийн тээврийн хэрэгслүүд;
- (д) Тавилга, эд хогшил: Нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах тавилга, аж ахуйн эд хогшил, багаж хэрэгслүүд;
- (е) Компьютер, бусад хэрэгсэл: Компьютер, хэвлэх, хувилах төхөөрөмж болон бусад хэрэгслүүд;
- (ж) Бусад үндсэн хөрөнгө: Дээрх ангилалд ороогүй бусад үндсэн хөрөнгө хамаарна.

НББОУС 16 *Үндсэн хөрөнгө* - д заасны дагуу үндсэн хөрөнгийг анхны удаа өртгөөр нь, дараагийн тайлант үед өртгийн загвар эсхүл дахин үнэлгээний загварын аль нэгийг ашиглан бүртгэнэ.

Өртгийн загварын дагуу үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан өртгөөр нь бүртгэнэ.

НББОУС 16 *Үндсэн хөрөнгө* - д заасны дагуу үндсэн хөрөнгийг дахин үнэлэх үед тухайн хөрөнгийн харъяалагдаж байгаа үндсэн хөрөнгийн ангийг бүхэлд нь дахин үнэлнэ. Хөрөнгийн дахин үнэлсэн дүн нь дараа үеийн хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байна.

Дахин үнэлгээний үр дүнд үндсэн хөрөнгийн дансны үнэ нэмэгдэх, буурах тохиолдолд дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү (бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн дүн) - г орлогын дэлгэрэнгүй тайлангийн бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт, дахин үнэлгээний өлз, гарз (ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн дүн) - ыг орлогын дэлгэрэнгүй тайлангийн бусад ашиг (алдагдал) - ийн хэсэгт тус тус харуулна.

Бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн *дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүүг* эздийн өмчийн хэсэгт “Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл” дансанд хуримтлуулан бүртгэнэ. Үндсэн хөрөнгийг данснаас хасах үед “Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл” дансанд хуримтлагдсан тухайн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнг хуримтлагдсан ашигт шилжүүлнэ.

Үндсэн хөрөнгийн элэгдэл

Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс буюу түүнийг захиргааны зорилгоор ашиглах нөхцөл хангагдсан үеэс эхлэн элэгдэл тооцно. Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын арга, үлдэгдлийг бууруулах арга, бүтээгдэхүүний нэгжийн аргуудаас хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн өгөөжид үндэслэн сонгоно; сонгосон аргыг тайлант үе

бүрт тогтвортой мөрдөнө.

Тайлант үе бүрийн элэгдлийн зардлыг (түүнийг бусад хөрөнгийн дансны үнэд хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд) ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн дүнг санхүүгийн тайланд тодруулна.

2. Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгө гэж биет шинж чанаргүй, тодорхойлж болохуйц, мөнгөн бус хөрөнгийг хэлнэ. Санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдол, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дансны цэвэр дүнгээр нь толилуулна.

Биет бус хөрөнгийн ангилал

Биет бус хөрөнгийг дараах байдлаар ангилна. Үүнд:

(а) Зохиогчийн эрх;

(б) Компьютерийн програм хангамж: Програм хангамж, мэдээллийн сан;

(в) Патент;

(г) Барааны тэмдэг;

(д) Тусгай зөвшөөрөл: Тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл;

(е) Газар эзэмших эрх;

(ж) Бусад биет бус хөрөнгө: Барилгын зураг, төсвийн ажил, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын зардал, хөгжүүлэлтийн зардал⁸.

Биет бус хөрөнгийг анхны удаа өртгөөр нь, дараагийн тайлант үед өртгийн загвар эсхүл дахин үнэлгээний загварын аль нэгийг нь ашиглан бүртгэнэ.

НББОУС 38 *Биет бус хөрөнгө* - д заасны дагуу биет бус хөрөнгийн дахин үнэлсэн дүн нь дараагийн тайлант үеийн хуримтлагдсан хорогдол ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байна.

Дахин үнэлгээний үр дүнд биет бус хөрөнгийн дансны үнэ нэмэгдэх, буурах тохиолдолд дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү (бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн дүн) - г орлогын дэлгэрэнгүй тайлангийн бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт, дахин үнэлгээний олз, гарз (ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн дүн) - ыг орлогын дэлгэрэнгүй тайлангийн бусад ашиг (алдагдал) - ын хэсэгт тус тус харуулна.

Биет бус хөрөнгийн бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн *дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүүг* эздийн өмчийн хэсэгт “Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл” дансанд хуримтлуулан бүртгэнэ. Биет бус хөрөнгийг данснаас хасах үед “Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл” дансанд хуримтлагдсан тухайн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнг хуримтлагдсан ашигт шилжүүлнэ.

⁸ НББОУС 38 *Биет бус хөрөнгө* -д заасны дагуу биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөгдөх хөгжүүлэлтийн зардал хамаарна.

Биет бус хөрөнгийн хорогдол

Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийн хувьд тухайн хөрөнгөөс хүлээгдэж буй эдийн засгийн үр өгөөжид үндэслэн шулуун шугамын арга, үлдэгдлийг бууруулах арга эсхүл бүтээгдэхүүний нэгжид ногдуулах аргуудаас аль нэгийг нь сонгон хэрэглэнэ.

Сонгосон хорогдуулалтын арга нь аж ахуйн нэгжийн хөрөнгөөс хүртэх эдийн засгийн үр өгөөжийг тодорхойлж чадахгүй байвал аж ахуйн нэгж нь шулуун шугамын аргыг хэрэглэнэ. Тодорхой ашиглалтын хугацаагүй биет бус хөрөнгийг хорогдуулахгүй. Биет бус хөрөнгийн хуримтлагдсан хорогдлын дүнг санхүүгийн тайланд тодруулна.

3. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтыг НББОУС 28 *Хараат компани дахь хөрөнгө оруулалт*, НББОУС 31 *Хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоо*, НББОУС 32 *Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга*, НББОУС 39 *Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*, СТОУС 7 *Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга*, СТОУС 9 *Санхүүгийн хэрэглүүр - ийн дагуу бүртгэж, тусдаа санхүүгийн тайланд НББОУС 27 Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан - ийн дагуу толилуулна.*⁹

4. Хойшлогдсон татварын хөрөнгө

Хойшлогдсон татварын хөрөнгөнд хасагдах түр зөрүү болон ашиглагдаагүй татварын алдагдлыг дараагийн үе рүү шилжүүлэхтэй холбоотойгоор ирээдүйн тайлант үед нөхөгдөх орлогын албан татварын дүн хамаарна. Хойшлогдсон татварын хөрөнгийг НББОУС 12 *Орлогын албан татвар* - ын дагуу тооцож бүртгэнэ.

Аж ахуйн нэгж нь хасагдах түр зөрүүг ашиглаж болохуйц хэмжээний татвар ногдох ашиг олох магадлалтай байгаа үед л хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Аж ахуйн нэгж нь тайлангийн өдөр бүрээр хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийг дахин авч үзнэ. Аж ахуйн нэгж нь хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийг нөхөх боломж олгохуйц татвар ногдох ашиг ирээдүйн тайлант үед олох нь тодорхой байгаа үед өмнөх хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Эрв хойшлогдсон татварын хөрөнгийн бүх эсвэл зарим өгөөжийг ашиглах хангалттай хэмжээний татвар ногдуулах орлого олох магадлалгүй бол тэр хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулна. Энэхүү бууралтыг хангалттай хэмжээний татвар ногдуулах орлого олох магадлалтай болсон үед буцаана.

5. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Хөрөнгийн үнийг өсгөх, түрээсийн орлого олох эсхүл аль алиных нь зорилгоор эзэмшиж буй хөрөнгийг хамруулна.

НББОУС 40 *Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө* - д заасны дагуу уг хөрөнгийг анхны удаа өртгөөр нь, дараагийн тайлант үед бодит үнэ цэнэ эсхүл өртгөөр нь бүртгэнэ. Сонгосон загвараа хөрөнгө оруулалтын зориулалттай бүх үл хөдлөх хөрөнгө (үйл ажиллагааны түрээсийн хөрөнгөөс бусад) - нд хэрэглэнэ.

Бодит үнэ цэнийн загварын дагуу хөрөнгийг анхны хэмжилтээс хойш бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Өртгийн загварын дагуу хөрөнгийг анхны хэмжилтийн дараа элэгдүүлсэн өртөг (хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн)-өөр бүртгэнэ. Санхүүгийн байдлын тайланд уг хөрөнгийг дансны цэвэр дүнгээр нь харуулна.

6. Бусад эргэлтийн бус хөрөнгө

Энэ хэсэгт дээр тусгайлан толилуулснаас бусад эргэлтийн бус хөрөнгийг хамруулна. Тухайлбал, аж ахуйн нэгжийн урт хугацаат зээлийн авлага болон бусад нэг жилээс дээш хугацаанд цуглуулах урт хугацаат авлагыг энэ хэсэгт толилуулна.

Өр төлбөр

Өр төлбөрийг богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөр гэж ангилна.

Богино хугацаат өр төлбөр

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны циклийн хэвийн нөхцөлд төлбөр нь төлөгдөхөөр хүлээгдэж байгаа эсхүл тайлангийн өдрөөс хойш 12 сарын дотор төлбөр нь төлөгдөх өр төлбөрийг богино хугацаат өр төлбөр гэнэ. Богино хугацаат өр төлбөрийг төлөгдөх дүнгээр нь бүртгэж санхүүгийн байдлын тайланд дараах байдлаар ангилан харуулна.

Үнд:

1. Дансны өглөг

Үүнд бизнесийн үндсэн үйл ажиллагааны явцад бэлтгэн нийлүүлэгчдээс худалдан авсан бараа, хангамжийн зүйлс, үйлчилгээний үнийн төлөгдөөгүй үлдэгдэл хамаарна.

2. Цалингийн өглөг

Ажилчдад өгөх цалин, бусад хэлбэрийн хөдөлмөрийн хөлсний өр төлбөрийн дүн хамаарна.

3. Татварын өр

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), нэмэгдсэн өртгийн албан татвар (ӨАТ), хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ), онцгой албан татвар (ОАТ)-ын өр, бусад татвар, төлбөр, хураамжийн тайлант хугацааны эцэст төлөгдөөгүй үлдэгдэл хамаарна. Улирал ба жилийн эцэс дэх төлөгдөөгүй татварын үлдэгдэл нь татварын байгууллагаас баталгаажуулсан үлдэгдэлтэй тэнцүү байна.

4. Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг

Цалингаас суутгасан болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн

тайлант хугацааны эцэст төлөгдөөгүй үлдэгдлийг тооцон энэ хэсэгт тусгана.

5. Богино хугацаат зээл

Нэг хүртэлх жилийн хугацаатай авсан зээл хамаарна.

6. Хүүний өглөг

Богино болон урт хугацаат зээл, өрийн үнэт цаастай холбоотой үүссэн, төлөгдөөгүй байгаа хүүний төлбөрийн дүнг энд тусгана.

7. Ногдол ашгийн өглөг

Тухайн аж ахуйн нэгжийн удирдах эрх бүхий байгууллагын шийдвэрээр хувьцаа эзэмшигч (хувь нийлүүлэгч)-д төлөхөөр зарласан ногдол ашгийг энэ дансанд бүртгэнэ. Зөвхөн мөнгөн хэлбэрийн ногдол ашгийн тайлант хугацааны эцэс дэх төлөгдөөгүй үлдэгдлийг богино хугацаат өр гэж үзнэ.

8. Урьдчилж орсон орлого

Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ үзүүлэхээс өмнө тэдгээрийн үнийг худалдан авагч эсхүл захиалагчаас урьдчилан хүлээн авсан тохиолдолд хүлээн авсан мөнгөний хэмжээгээр богино хугацаат өр үүсгэж “Урьдчилж орсон орлого” дансанд бүртгэнэ. Энэ дансыг бараа, үйлчилгээ үзүүлсэн буюу орлого хэрэгжсэн үед дебитлэж, холбогдох борлуулалтын орлогын дансыг кредитлэдэг.

9. Нөөц (өр төлбөр)

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн үүрэг хариуцлагыг төлөх магадлалтай, төлбөрийн дүнг тооцоолох боломжтой болсон үед нь нөөц гэж хүлээн зөвшөөрнө.

Даатгалын компани нь Орлогод тооцоогүй хураамжийн нөөц, Нэхэмжилсэн хохирлын нөөц, Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц, Учирч болзошгүй хохирлын нөөцүүдийг хорооноос баталсан журмын дагуу тооцон сайн дурын болон албан журмын даатгалын төрлөөр ангилан энэ хэсэгт тусгана. *Нөөцийн бүртгэлд НББОУС 37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө - г мөрдөнө.*

10. Бусад богино хугацаат өр төлбөр

Бизнесийн үндсэн үйл ажиллагаанаас өөр чиглэлээр үүссэн өр, бизнесийн үйл ажиллагааны явцад үүссэн төрөл бүрийн суутгалууд, зардалд шингээж тооцсон төлөгдөөгүй өр, урт хугацаат өр төлбөрийн тайлант хугацаанд хамаарах хэсэг, худалдан авагчид болон ажиллагчдаас авсан буцаан төлөх мөнгөн барьцаа, холбоотой талаас авсан богино хугацаат зээл болон дээр тусгайлан толилуулснаас бусад богино хугацаат өрийг энэ хэсэгт толилуулна.

11. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр

СТОУС 5 *Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа* - д заасны борлуулах зорилгоор эзэмшиж буй *эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)* - нд

хамаарах өр төлбөрийн дүнг толилуулна.

Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд дараах байдлаар ангилна. Үүнд:

1. Урт хугацаат зээл

Нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын эх үүсвэр, холбоотой талаас авсан зээлийн дүнг энэ хэсэгт толилуулна.

2. Нөөц (өр төлбөр)

Даатгалын компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор байгуулсан нөөцийн урт хугацааны дүн хамаарна.

3. Хойшлогдсон татварын өр

Хойшлогдсон татварын өр гэж татвар ногдох түр зөрүүтэй холбоотойгоор ирээдүйн тайлант үед төлөх орлогын албан татварын өрийн дүнг хэлнэ. Хойшлогдсон татварын өрийг НББОУС 12 *Орлогын албан татвар*-ын дагуу тооцож бүртгэлд тусгана.

4. Бусад урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат бонд, өрийн бичиг болон бусад урт хугацаат өр төлбөрийн дүнг энэ хэсэгт толилуулна.

Эздийн өмч

Аж ахуйн нэгжийн өр төлбөрөө төлсний дараагаар үлдэх цэвэр хөрөнгийн хэмжээг эздийн өмч гэж үзнэ. Санхүүгийн байдлын тайланд эздийн өмчийг дараах байдлаар ангилна. Үүнд:

1. Өмч

Аж ахуйн нэгжийн төрлөөс хамаарч *өмчийг* хувьцаат капитал, гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, хоршоологчдын хувь нийлүүлсэн хөрөнгө гэж нэрлэнэ. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн хувьд өмчийг төрийн болон хувийн өмч гэж ангилж толилуулна.

2. Халаасны хувьцаа

Компаниуд гүйлгээнд гаргасан хувьцаагаа зах зээлээс эргүүлэн худалдан авах үед худалдан авсан халаасны хувьцааны дүнгээр өмчийн буюу хувьцаат капиталын дүнг бууруулна. Халаасны хувьцаа нь гаргасан хувьцааны тоонд орж тооцогдох боловч эргэлтэнд байгаа хувьцааны тоонд орохгүй. Аж ахуйн нэгж нь гүйлгээнд гаргасан хувьцаагаа зах зээлээс эргүүлэн худалдан авах, борлуулах, гаргах, хүчингүй болгох үед үүссэн олз (гарз)-ыг ашиг (алдагдал)-аар хүлээн зөвшөөрөхгүй.

Нэмж төлөгдсөн капитал

Компанийн гаргасан энгийн хувьцаа болон давуу эрхтэй хувьцааны зах зээлийн үнэ нэрлэсэн үнээс нь илүү байвал зөрүүг нэмж төлөгдсөн капитал дансанд хуримтлуулан бүртгэнэ.

Хувьцааны нэрлэсэн үнэ зах зээлийн үнээс өндөр байгаа үед нэмж төлөгдсөн капитал данс

нь сөрөг тохируулах данс болно.

3. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

Аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны үнэ дахин үнэлгээний үр дүнд өссөн бол бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн өсөлтийн дүнг энэ дансанд хуримтлуулан бүртгэнэ. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансыг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү - өсөлт, үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтын дүнгээр нэмэгдүүлнэ.¹¹ Харин бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү - бууралт, үнэ цэнийн бууралтын гарз, хэрэгжсэн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнгээр энэ дансыг бууруулна.

4. Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц

Аж ахуйн нэгжийн гадаад үйл ажиллагааг хөрвүүлснээс болон аж ахуйн нэгжийн бүртгэлийн валют толилуулгын валютаас ялгаатай байх үед санхүүгийн тайланг толилуулгын валют руу хөрвүүлснээс¹² үүссэн ханшийн зөрүүний хуримтлагдсан дүнг “гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц” гэж эздийн өмчийн хэсэгт толилуулна. Аж ахуйн нэгжийн гадаад үйл ажиллагааг болон санхүүгийн тайланг толилуулгын валют руу хэрхэн хөрвүүлэх, үүсэх ханшийн зөрүүг бүртгэхэд НББОУС 21 *Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө* - ийг мөрдөнө.

5. Эздийн өмчийн бусад хэсэг

Энэ хэсэгт бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч өмчийн хэсэгт хуримтлуулан бүртгэсэн бусад олз, гарзын¹³ дүнг толилуулна.

6. Хуримтлагдсан ашиг

Компанийн үүсэн байгуулагдсанаас хойшхи хугацаанд компанид хуримтлагдан үлдсэн ашиг, алдагдлын нийлбэрийг хуримтлагдсан ашиг дансанд бүртгэнэ.

Гуравдугаар бүлэг: ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Орлогын дэлгэрэнгүй тайлан нь аж ахуйн нэгжийн тодорхой хугацааны үйл ажиллагааны үр дүнг хэмжинэ.

Орлогын дэлгэрэнгүй тайланд орлогыг хүлээн авсан эсхүл авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ. Орлоготой холбогдож гарсан нөхөн төлбөр болон бусад зардлыг жинхэнэ гарсан хэмжээгээр нь тусгана. Энэхүү тайланд зардлыг чиг үүргээр нь ангилж үр дүнг тооцно.

Орлогын дэлгэрэнгүй тайланг бэлтгэх

(а) Орлогын дэлгэрэнгүй тайланг бэлтгэхдээ тухайн тайлант үед хамрагдах орлого, зардлын ажил гүйлгээг аккруэл зарчмаар бүртгэнэ;

¹¹ НББОУС 16 *Үндсэн хөрөнгө*, НББОУС 36 *Хөрөнгийн нэгж цэнийн бууралт*, НББОУС 38 *Биет бус хөрөнгө* - д заасны дагуу бүртгэнэ.

¹² Хэрэв аж ахуйн нэгжийн толилуулгын валют бүртгэлийн валютаас өөр байвал тэрээр үр дүн, санхүүгийн байдлаа толилуулгын валют уруу хөрвүүлэх ба үүссэн ханшийн зөрүүг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрнө.

¹³ НББОУС 1 *Санхүүгийн тайлангийн толилуулга* - д заасны дагуу Ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн тогтоосон төлөвлөгөөнөөс үүссэн актаар олз, гарз, Санхүүгийн хэрэглүүрийн бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарз, Мөнгөн гүйлгээний хейдж дэх хейджийн хэрэглүүрээс үүссэн олз, гарз үүнд хамарна.

- (б) Орлого ба зардлыг тэдгээрийн үүсэн гарч буй шалтгаанаар нь ангилна. Орлогын зүйл анги тус бүрт зардлын зүйл ангийг зохицуулах зарчмыг баримтлан бүртгэнэ;
- (в) Бизнесийн тодорхой чиглэлүүдээр зардлын зүйл ангийн дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж, мэдээлэх ажлыг өртгийн бүртгэлийн хүрээнд зохион байгуулна;
- (г) Хураамжийн орлого, нөхөн төлбөрийг бизнесийн үндсэн чиглэл тус бүрээр үзүүлнэ.

Дараах дүн бүхий зүйлүүдийг орлогын дэлгэрэнгүй тайланд тусгана. Үүнд:

1. Нийт хураамжийн орлого

Даатгалын компанийн тайлант хугацаанд хийсэн даатгалын гэрээний дагуу даатгуулагчаас төлсөн нийт хураамжийн орлогын дүнгээс буцаасан хураамжийг хассан цэвэр дүнгээр орлогын дэлгэрэнгүй тайланд тусгана.

2. Давхар даатгалын хураамж

Даатгагч нь даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дахин даатгаж төлж байгаа болон төлөхөөр тооцсон төлбөр хамаарна.

3. Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт

Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн дансны тайлант үеийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хасч Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлтийг тодорхойлно.

4. Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт

Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг дансны тайлант үеийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хасч орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлтийг тодорхойлно.

5. Орлогод тооцсон хураамжийн цэвэр орлого

Нийт хураамжийн орлогын цэвэр дүнгээс давхар даатгалын хураамж, орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн өөрчлөлт болон орлогод тооцоогүй хураамжийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлтийг хасч орлогод тооцсон хураамжийн цэвэр орлогыг тодорхойлно.

6. Нийт нөхөн төлбөр

Энэ хэсэгт тайлант хугацаанд олгосон нийт нөхөн төлбөрийн дүнг харуулна

7. Давхар даатгагчийн нөхөн төлбөр

Даатгалын тохиолдол болсон нөхцөлд гэрээнд заасны дагуу давхар даатгагчаас даатгагчид төлсөн болон төлөхөөр тооцсон нөхөн төлбөр хамаарна.

8. Даатгалын нөөцийн өөрчлөлт, нийт дүнгээр(+,-)

Нэхэмжилсэн хохирлын нөөц, Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц, Учирч болзошгүй хохирлын нөөцүүдийн тайлант үеийн өөрчлөлт хамаарна. Дээрхи нөөцүүдийн тайлант үеийн үлдэгдлээс тайлант үеийн эхний үлдэгдлийг хасч нөөцүүдийн өөрчлөлтийг тодорхойлно.

9. Даатгалын нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт(+,-)

Даатгалын нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийн тайлант үеийн өөрчлөлт хамаарна. Даатгалын нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийн тайлант үеийн үлдэгдлээс тайлант үеийн эхний үлдэгдлийг хасч энэхүү өөрчлөлтийг тодорхойлно.

10. Цэвэр нөхөн төлбөр

Нийт нөхөн төлбөрийн дүнгээс давхар даатгагчийн төлсөн нөхөн төлбөрийн дүн болон нөөцүүдийн өөрчлөлтийг хасч цэвэр нөхөн төлбөрийг тодорхойлно.

11. Даатгалын гэрээний цэвэр зардал

Даатгалын төлөөлөгчийн шимтгэл, даатгалын зуучлагчийн төлбөрийн тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөгдөх хэсэг хамаарна.

Даатгалын төлөөлөгчийн шимтгэл, даатгалын зуучлагчийн төлбөрийг төлсөн үед урьдчилж төлсөн зардлаар хүлээн зөвшөөрч, холбогдох хураамжийг орлогоор хүлээн зөвшөөрсөн хувь хэмжээгээр зардлаар хүлээн зөвшөөрнө.

12. Давхар даатгалын комиссын орлого

Давхар даатгагчаас давхар даатгалын борлуулалтын шимтгэл хэлбэрээр даатгагчид буцаан төлсөн төлбөрийн тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрөгдөх хэсэг хамаарна.

Давхар даатгалын комиссын орлого орж ирсэн үед нь урьдчилж орсон орлогоор хүлээн зөвшөөрч давхар даатгалын хураамжийн хүлээн зөвшөөрөлттэй уялдуулан тайлант үеийн орлогоор хүлээн зөвшөөрнө.

13. Буруутай этгээдээр төлүүлсэн орлого

Даатгуулагчид учирсан хохирлын нөхөн төлбөрийг буруутай этгээдээр төлүүлсэн болон төлөхөөр тохирсон дүнгээр орлого болгоно.

14. Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)

Орлогод тооцсон хураамжийн цэвэр орлогоос цэвэр нөхөн төлбөр, даатгалын гэрээний цэвэр зардлын дүнг хасч давхар даатгалын комиссын орлого, буруутай этгээдээр төлүүлсэн орлогыг нэмж даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)-ыг тодорхойлно.

15. Түрээсийн орлого

Түрээслүүлэгчээс түрээслэгчид хөрөнгийг тодорхой хугацаанд, тодорхой төлбөртэйгээр ашиглуулах эрхийг шилжүүлэх тухай гэрээний дагуу түрээслүүлэгчийн хүлээн авах мөнгөн болон мөнгөн бус дүнг түрээсийн орлогод хамруулна. Түрээсийн орлогыг НББОУС 17 Түрээс-ийн дагуу бүртгэнэ.

16. Хүүний орлого

Аж ахуйн нэгжийн бүх төрлийн хүүний орлого хамаарна. Хүүний орлогыг татвар

суутгаагүй нийт дүнгээр нь толилуулна

17. Ногдол ашгийн орлого

Бусад аж ауйн нэгжээс хүлээн авах ногдол ашгийг хүлээн авах эрх үүссэн үед нь хүлээн зөвшөөрнө. Ногдол ашгийн орлогыг НББОУС 18 *Орлого* - ын дагуу бүртгэж, татвар суутгаагүй нийт дүнгээр нь толилуулна.

18. Эрхийн шимтгэлийн орлого

Аж ахуйн нэгжийн барааны тэмдэг, зохиогчийн эрх, патент, компьютерийн програм хангамж болон бусад урт хугацаат хөрөнгө ашиглуулсны төлөө бусдаас авах төлбөр хамаарна. Эрхийн шимтгэлийн орлогыг НББОУС 18 *Орлого* - ын дагуу бүртгэж, татвар суутгаагүй нийт дүнгээр нь толилуулна.

19. Бусад орлого

Дээр тусгайлан толилуулснаас бусад орлогыг холбогдох СТОУС - ын дагуу бүртгэж энэ хэсэгт харуулна.

20. Борлуулалт маркетингийн зардал

Борлуулалт маркетингийн зардлыг нийт дүнгээр нь толилуулна. Тус зардлыг цалингийн, нийгмийн даатгал

шимтгэлийн, зар сурталчилгааны, тээврийн, томилолтын, даатгалын, бичиг хэргийн, шуудан холбооны, элэгдэл хорогдлын зардлууд болон бусад гэж дэлгэрэнгүй тодруулна.

21. Ерөнхий ба удирдлагын зардал

Ерөнхий ба удирдлагын зардлыг нийт дүнгээр нь толилуулна. Ерөнхий ба удирдлагын зардлыг ажиллагчдын цалингийн, нийгмийн даатгал шимтгэлийн, албан татвар, төлбөр, хураамжийн, томилолтын, бичиг хэргийн, шуудан холбооны, мэргэжлийн үйлчилгээний, сургалтын, сонин сэтгүүл захиалгын, даатгалын, цахилгаан, ус, дулаан зэрэг ашиглалтын, засварын, элэгдэл хорогдлын, түрээсийн, харуул хамгааллын, цэвэрлэгээ үйлчилгээний, тээврийн, шатахууны, хүлээн авалтын зардлууд, биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөөгүй судалгааны¹⁴ болон хөгжүүлэлтийн¹⁵ зардал болон бусад гэж тодруулна.

22. Санхүүгийн зардал

Үүнд бүх төрлийн хүүний зардал, зээлийн шимтгэл, зээлтэй холбоотой үүссэн бусад зардал (тухайлбал, бичиг хэргийн) хамаарна.

23. Бусад зардал

Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардлын ангилалд ороогүй бусад зардлууд тухайлбал, хандивийн зардал, алданги, торгуулийн зардал, найдваргүй авлагын зардал орно.

24. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)

Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр, авлага, төлөгдөөгүй зээл, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд хийгдсэн ханшийн тэгшитгэлийн олз (гарз), зарим мөнгөн бус зүйлсийн валютын ханшийн зөрүүний ашиг (алдагдал)-аар хүлээн зөвшөөрсөн олз (гарз)-ыг хамруулна. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)-ыг НББОУС 21 *Гадаад валютын*

17

ханийн өөрчлөлтийн үр нөлөө - ийн дагуу бургэнэ.

25. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)

Үндсэн хөрөнгийг түүнийг борлуулах, хандивлах эсхүл түүний ашиглалтаас ирээдүйн эдийн засгийн үр өгөөж хүртэхгүй болсон үед данснаас хасна. Үндсэн хөрөнгийн дансны үнэ болон хасалтаас олсон орлогын зөрүүгээр олз (гарз)-ыг тодорхойлно.

26. Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)

Биет бус хөрөнгийг актлах, борлуулах, хандивлах болон бусад хэлбэрээр данснаас хасах үед дансны үнэ болон хасалтаас олсон орлогын зөрүүгээр олз (гарз)-ыг тодорхойлно.

27. Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)

Бүх торлийн хөрөнгө оруулалт борлуулсны олз, гарз хамаарна.

28. Бусад ашиг (алдагдал)

Дээр тусгайлан толилуулснаас бусад ашиг (алдагдал) үүнд хамаарна. Тухайлбал, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс аль эсхүл данснаас хасахад үүссэн олз (гарз), дахин үнэлсэн хөрөнгийн ашиг (алдагдал)-аар хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарз (гарзын буцаалт), ашиг (алдагдал)-аар хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний олз (гарз), бусад олз (гарз) - ыг толилуулна.

29. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)

Даатгалын үйл ажиллагааны ашгийн дүн дээр түрээсийн орлого, хүүний орлого, ногдол ашгийн орлого, эрхийн шимтгэлийн орлого, бусад орлогыг нэмж, түүнээс борлуулалт маркетингийн зардал, ерөнхий ба удирдлагын зардал, санхүүгийн зардал, бусад зардлыг хасч, гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз), үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз), биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз), хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз), бусад ашиг (алдагдал)-ийг нэмж (хасч) татвар төлөхийн өмнөх ашгийг тодорхойлно.

30. Орлогын татварын зардал

Орлогын татварын зардал (орлого) нь тайлант үеийн татварын зардал болон хойшлогдсон татварын зардал (орлого) - аас бүрдэнэ. Тайлант үеийн татварын зардал гэдэгт нийтлэг болон тусгай хувь хэмжээгээр ногдуулсан ААНОАТ-ын нийт дүн орно.

31. Татварын дараах ашиг (алдагдал)

Татварын дараах ашиг (алдагдал) - ийг татвар төлөхийн өмнөх ашгаас орлогын татварын зардлыг хасч тодорхойлно.

¹⁴ НББОУС 38 *Биет бус хөрөнгө*-д заасны дагуу судалгааны зардлыг гарсан үед нь зардлаар хүлээн зөвшөөрнө. Судалгааны зардалд шинэ мэдлэг эзэмших зорилготой үйл ажиллагаа, судалгааны үр дүнг үнэлэх, нжил торлийн аль эсхүл сайжруулсан материал, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн, үйл ажиллагааны эрэл хайгуул хийх, үнэлэх, томъёолох, бүтээн байгуулахтай холбоотой зардлууд хамаарна.

¹⁵ Хөгжүүлэлтийн зардалд үйлдвэрлэлийн өмнөх загварыг төлөвлөх, зохион бүтээх, туршиж, шинэ технологийг багтаасан тоног төхөөрөмж зохион бүтээх, шинэ эсхүл сайжруулсан материал, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн процесс төлөвлөх, зохион бүтээх, туршижтай холбоотой зардлууд хамаарах бөгөөд НББОУС 38 *Биет бус хөрөнгө*-д заасан шалгуур хангагдахгүй тохиолдолд биет бус хөрөнгөөр бус тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө.

32. Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)

СТОУС 5 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа - д заасны дагуу зогсоосон үйл ажиллагаа гэдэгт аж ахуйн нэгжийн борлуулах гэж буй тусдаа томоохон үйл ажиллагааны чиглэл эсвэл үйл ажиллагаа явуулах газар зүйн бүс нутгийн төлөөлөл, дахин борлуулах зорилгоор худалдан авч эзэмшсэн охин компани хамаарна.

Орлогын дэлгэрэнгүй тайланд зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал), зогсоож буй үйл ажиллагааг илэрхийлэх хөрөнгө (аль эсвэл бүлэг хөрөнгө) - ийн борлуулалтаас хүлээн зөвшөөрсөн татварын дараах олз (гарз) - ын нийлбэр дүнг Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) гэж толилуулна.

33. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)

Татварын дараах ашиг (алдагдал) болон зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) - ийн нийлбэр дүнгээр тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) - ийг тооцно.

34. Бусад дэлгэрэнгүй орлого

Бусад дэлгэрэнгүй орлогод ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөөгүй дараах олз (гарз)-ыг хамруулна. Үүнд:

- (а) Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү: үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөөгүй дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү (өсөлт буюу бууралт), дахин үнэлсэн үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөөгүй үнэ цэнийн бууралтын гарз, гарзын буцаалт;
- (б) Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү: аж ахуйн нэгжийн гадаад үйл ажиллагааг болон аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг толилуулгын валют руу хөрвүүлснээс үүссэн ханшийн зөрүү;
- (в) Бусад олз, гарз: санхүүгийн хэрэглүүрийн бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн олз (гарз), мөнгөн гүйлгээний хейдж дэх хейджийн хэрэглүүрээс үүссэн бодит үнэ цэнийн олз (гарз), ажилчдын тэтгэвэр тэтгэмжийн актуар олз, гарз, дахин ангиллын тохируулга¹⁶ үүнд хамаарна.

35. Орлогын нийт дүн

Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) болон бусад дэлгэрэнгүй орлогын нийлбэр дүнгээр орлогын нийт дүнг тооцно.

36. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) Орлогын нийт дүн

Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) болон бусад дэлгэрэнгүй орлогын нийлбэр дүнгээр орлогын нийт дүнг тооцно.

¹⁶ НББОУС 1 Санхүүгийн тайлангийн тохируулга - д заасны дагуу өмнө нь бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн зарим олз, гарзыг тухайн тайлант үед ашиг, алдагдалд ангилсан бол тэр дахин ангилсан дүнг дахин ангиллын тохируулга гэж нэрлэж бусад дэлгэрэнгүй орлогоос хасна.

37. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)

Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашиг, алдагдлын хувьд нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцно. Толгой компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашиг, алдагдлыг тайлант хугацааны туршид эргэлтэнд байгаа энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд хуваах замаар нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тодорхойлно. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)-ийг бүртгэхэд НББОУС 33

Нэгж хувьцаанд ногдох ашиг - ыг мөрдөнө.

Дөрөвдүгээр бүлэг: ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Өмчийн өөрчлөлтийн тайланд эздийн өмчид гарсан аливаа өөрчлөлтийн хэмжээг дараах байдлаар хоёр жилээр толилуулна. Үүнд:

1. Эздийн өмчийн бүрэлдэхүүн тус бүрийн хувьд тайлант үеийн эхний болон эцсийн үлдэгдэл нь тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал), бусад дэлгэрэнгүй орлого, өмчид гарсан өөрчлөлт, хувьцаа эзэмшигч (хувь нийлүүлэгч)-дэд хуваарилсан ногдол ашиг, хэрэгжсэн дахин үнэлгээний нэмэгдэл зэрэг эздийн өмчид гарсан аливаа өөрчлөлтийг тусгасан байна;
2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулгыг хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдлийг залруулж тусгана;
3. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)-ийн дүнг хуримтлагдсан ашиг (алдагдал)-ийн залруулсан үлдэгдлийн дүн дээр нэмнэ;
4. Бусад дэлгэрэнгүй орлогын дүнг бүрэлдэхүүн тус бүрээр задлан хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл, гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц, эздийн өмчийн бусад хэсгийн өмнөх тайлант үеийн үлдэгдэл тус бүр дээр нэмнэ;
5. Өмчид гарсан өөрчлөлт гэдэг нь тухайн тайлант үед нэмж гаргасан хувьцаа, буцаан худалдан авсан хувьцаа, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгөнд гарсан өөрчлөлт байна. Өмчид гарсан өөрчлөлтийн дүнг дараах байдлаар тусгана:
 - (а) Нэмж гаргасан хувьцаа, нэмж оруулсан хөрөнгө, хүчингүй болсон хувьцаа, буцаан татан авсан хөрөнгийн дүнг өмнөх тайлант үеийн өмчийн үлдэгдэл дээр (үлдэгдлээс) нэмж (хасч) харуулна;
 - (б) Буцаан худалдан авсан хувьцааны дүнгээр халаасны хувьцааны дүнг нэмэгдүүлнэ;
 - (в) Нэмж хувьцаа гаргах, хувьцаа буцаан худалдан авах, хувьцаа хүчингүй болгоход үүссэн нэмж төлөгдсөн капитал дансны өсөх (буурах) өөрчлөлтийн дүнг өмнөх тайлант үеийн нэмж төлөгдсөн капитал дансны үлдэгдэл дээр (үлдэгдлээс) нэмнэ (хасна);
 - (г) Нэмж хувьцаа гаргах зардал болон хувьцаа буцаан худалдан авах, хүчингүй болгох ажил гүйлгээнээс үүсэх хуримтлагдсан ашиг дансны буурах өөрчлөлтийг хуримтлагдсан ашиг дансны залруулсан үлдэгдлээс хасна.

6. Зарласан ногдол ашгийн дүнг хуримтлагдсан ашиг дансны залруулсан үлдэгдлээс хасна;
7. Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийг данснаас хасах үед тухайн хөрөнгийн дахин үнэлгээний хуримтлагдсан нэмэгдлийн дүнг дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дун гэсэн мөрөнд хуримтлагдсан ашгаас хасч тусгана;
8. Хуримтлагдсан ашиг (алдагдал) - ийн залруулсан үлдэгдэл дээр тайлант үеийн цэвэр ашиг, өмчид гарсан нэмэгдэх өөрчлөлт, дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүнг нэмж, тайлант үеийн цэвэр алдагдал, өмчид гарсан хасагдах өөрчлөлт болон зарласан ногдол ашгийг хасч тайлант үеийн хуримтлагдсан ашиг (алдагдал) -ийн эцсийн үлдэгдлийг тодорхойлно;
9. Нийт эздийн өмчийн эхний үлдэгдэл дээр нийт нэмэгдсэн өөрчлөлтийг нэмж, нийт хасагдсан өөрчлөлтийг хасч, эздийн өмчийн эцсийн үлдэгдлийг тодорхойлно.

Тавдугаар бүлэг: МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Мөнгөн гүйлгээний тайлан нь үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ, бүх цэвэр мөнгөн гүйлгээ гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг мөнгөн гүйлгээний тайланд хоёр жилээр зэрэгцүүлэн дараах байдлаар харуулна. Үүнд:

- (а) Мөнгөн хөрөнгийг бүрдүүлсэн эх үүсвэрийг мөнгөн орлого, мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг мөнгөн зарлага гэсэн хэсэгт үзүүлнэ;
- (б) Үндсэн үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний нийлбэрээр нийт цэвэр мөнгөн гүйлгээг тодорхойлно;
- (в) Тайлант хугацааны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс эцсийн үлдэгдлийг хасч тодорхойлсон мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт нь мөнгөн гүйлгээний тайлангийн “Бүх цэвэр мөнгөн гүйлгээ” гэсэн дүнтэй тэнцүү байна;
- (г) Мөнгөн гүйлгээний тайланг бэлтгэхэд шууд аргыг хэрэглэнэ.

1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

(а) Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогод:

- Хураамжийн орлого;
- Давхар даатгалын нөхөн төлбөр;
- Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого;
- Буцаан авсан албан татвар ;
- Улсаас авсан татаас, санхүүжилт;
- Бусад мөнгөн орлого орно.

(б) Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлагад:

- Ажиллагчдад төлсөн;
- Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн;

- Бараа материал худалдан авахад төлсөн;
- Ашиглалтын зардалд төлсөн;
- Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж;
- Нөхөн төлбөрт төлсөн;
- Даатгалын төлөөлөгчийн шимтгэл;
- Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр;
- Даатгалын хохирол үнэлэгчид төлсөн төлбөр;
- Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн;
- Хүүний төлбөрт төлсөн¹⁷;
- Татварын байгууллагад төлсөн;
- Бусад мөнгөн зарлага орно.

(в) Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого болон мөнгөн зарлагын зөрүүгээр үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг тодорхойлно.

2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

(а) Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ нь хөрөнг оруулалт, урт хугацаат хөрнг олж эзэмших, борлуулах, бусдад зээл болон мөнгөн урьдчилгаа олгох, тэдгээрийн буцаан төлөлтөөс бий болсон мөнгөн гүйлгээг харуулна.

(б) Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлогод:

- Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад урт хугацаат хөрөнгө (тухайлбал ХОЗҮХХ, бусад санхүүгийн хөрөнгө) борлуулснаас;
- Урт болон богино хугацаат хөрөнгө оруулалт борлуулснаас;
- Бусад талуудад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлтөөс (санхүүгийн байгууллагын хувьд олгосон зээл, мөнгөн урьдчилгаа нь үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнд хамаарна);
- Мөнгөөр хүлээн авсан хүү;
- Мөнгөөр хүлээн авсан ногдол ашиг;
- Бусад мөнгөн орлого орно.

(в) Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлагад:

- Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө болон бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө;
- Урт болон богино хугацаат хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө;
- Бусад талуудад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа;
- Бусад мөнгөн зарлага орно.

¹⁷ Тухайн аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагааны төрлөөс хамаарч төлсөн болон хүлээн авсан хүү, ногдол ашгийг үндсэн, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны аль нэгээр ангилж, энэхүү ангиллыг нэг тайлант үеэс нөгөө тайлант үед тууштай мөрдөнө.

(г) Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого болон мөнгөн зарлагын зөрүүгээр тодорхойлно.

3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ

(а) Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ нь аж ахуйн нэгжид санхүүжилт олгосон этгээд ирээдүйд хэдий хэмжээний төлбөр нэхэмжлэх вэ гэдгийг урьдчилан тооцох боломжийг илэрхийлдэг.

(б) Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлогод:

-Банкнаас авсан урт болон богино хугацааны зээл, бүх төрлийн өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө

-Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан мөнгө;

-Бусад мөнгөн орлого орно.

(в) Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлагад:

-Зээл, өрийн бичгийн төлбөрт төлсөн мөнгө, урт хугацаат өрийн тайлангийн хугацааны төлөлт;

-Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн ;

-Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн;

-Мөнгөөр төлсөн ногдол ашиг;

-Бусад мөнгөн зарлага орно.

(г) Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого болон мөнгөн зарлагын зөрүүгээр тодорхойлно.

4. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн тайлант оны эхний, эцсийн үлдэгдэл нь санхүүгийн байдлын тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө дансны эхний, эцсийн үлдэгдлийн дүнтэй тэнцүү байна.

Зургадугаар бүлэг: САНХҮҮГИЙН ТАЛАНГИЙН ТОДРУУЛГА

Аж ахуйн нэгж нь санхүүгийн тайлангийн тодруулгад үндсэн болон туслах үйл ажиллагааны чиглэл, салбар болон төлөөлөгчийн газрын нэр, байршил, санхүүгийн тайлангийн огноо, хамарсан тайлант хугацааг тодруулахаас гадна дараах мэдээллийг системтэй арга хэлбэрээр харуулна. Үүнд:

1. Тайлан бэлтгэх үндэслэл

Санхүүгийн тайлан нь СТОУС-д нийцсэн тухай мэдэгдэл, санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчмаар бэлтгэсэн эсэх, санхүүгийн тайлангийн суурь, толилуулгын валют, тайлант хугацаанд мөрдсөн НББОУС болон СТОУС-ыг товч тодорхойлж бичнэ.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт

Энэ хэсэгт нягтлан бодох бүртгэлийн бодлогын¹⁸ өөрчлөлт, алдаа болон тооцооллын

¹⁸ Нягтлан бодох бүртгэлийн бодлого гэдэг нь санхүүгийн тайланг бэлтгэх болон толилуулахад мөрдлөг болгодог, тухайн аж ахуйн нэгжийн зүгээс боловсруулан гаргасан тусгай зарчим, суурь, дүрэм, журам, заавар, аргачлал ба практик уйл ажиллагаа юм.

өөрчлөлтийн талаар НББОУС 8 *Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа* - д заасны дагуу тодруулна.

(а) Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт¹⁹

Хэрэв аж ахуйн нэгж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогоо өөрчилсөн²⁰ бол өөрчлөх болсон шалтгаан, өөрчлөлтийн мөн чанар, шилжилтийн нөхцлийн тодорхойлолт, тайлбар, нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг найдвартай ба илүү хамааралтай мэдээллээр хангана гэж үзсэн шалтгаан, санхүүгийн тайланд үзүүлсэн нөлөө зэргийг тодруулна.

(б) Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт

Аж ахуйн нэгж нь НББОУС 8 *Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа* - д заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтийг гүйцээн мөрдөх горимын дагуу хүлээн зөвшөөрч түүний мөн чанар, тайлант үед үзүүлсэн нөлөө, ирээдүйн тайлант үед үзүүлэх нөлөө зэргийг тооцоолох практик боломжгүй байхаас бусад тохиолдолд тодруулна.

(в) Нягтлан бодох бүртгэлийн алдаа

Аж ахуйн нэгжийн өмнөх тайлант үеийн материаллаг алдааг тухайн алдааг илрүүлсэн тайлант үеийн санхүүгийн тайланд буцаан мөрдөх горимын дагуу залруулна. НББОУС 8 *Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа* - д заасны дагуу тодруулна.

3. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Касс, банкны харилцах дансанд байгаа мөнгө, мөнгөтэй адилтгах хөрөнгийн эхний болон эцсийн үлдэгдлийг тодруулна.

4. Дансны болон бусад авлага

Энэ хэсэгт дансны, татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн болон бусад авлагыг тодруулна.

4.1 Дансны авлага

Дансны авлага, найдваргүй авлагын хасагдуулга дансдын эхний болон эцсийн үлдэгдэл, тухайн тайлант хугацаанд нэмэгдсэн болон хасагдсан (төлөгдсөн, найдваргүй болж хасагдсан) авлагын дүн, санхүүгийн байдлын тайланд толилуулсан дансны авлагын дансны цэвэр дүнг тодруулна. Дансны авлагын төлөгдөх хугацаандаа байгаа, хугацаа хэтэрсэн, найдваргүй гэж ангилсан дүн, найдваргүй авлагын хасагдуулга байгуулсан аргыг тэмдэглэл хэсэгт тодруулна.

¹⁹ Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг буцаан мөрдөх горимын дагуу өмнөх үе рүү буцаан мөрдвөл нягтлан бодох бүртгэлийн шинэ бодлогыг анхнаас нь хэрэглэж байсан мэтээр хамгийн эхний өмнөх тайлант үед толилуулсан өмчийн дансны бүрэлдэхүүн бүрийн эхний үлдэгдэл ба өмнөх тайлант үе бүрт тодруулсан бусад зэрэгцүүлэгдэх дүнг тохируулна.¹⁹

²⁰ Тухайлбал, бараа материалын өртөг тооцох аргыг өөрчлөх нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт юм.

4.2 Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

Аж ахуйн нэгжийн бүх төрлийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын дүнг дэлгэрэнгүй тодруулна. Албан татварын авлагыг ААНОАТ-ын, НӨАТ-ын болон бусад татвар, төлбөр, хураамжийн төрлөөр харуулна.

4.3 Бусад авлага

Санхүүгийн байдлын тайлангийн *Бусад авлага* - д хамаарах дүнг холбоотой талаас авах авлага (эргэлтийн хөрөнгөнд хамаарах дүн), ажиллагчдаас авах авлага, ногдол ашиг, хүү, богино хугацаат авлагын бичгийн авлага, бусад байгууллага, хувь хүнээс авах авлага гэж нэр төрлөөр нь тодруулна.

5. Бусад санхүүгийн хөрөнгө

Эргэлтийн хөрөнгийн хэсэг дэх бусад санхүүгийн хөрөнгийн бүрэлдэхүүн тус бүрийн эхний болон эцсийн үлдэгдлийг СТОУС 7 *Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга* -ийн дагуу тодруулна.

6. Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг

Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэгийг даатгалын төрөл хэлбэрээр эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацааны өөрчлөлтийн дүнг тодруулна.

7. Даатгалын нөөцийн давхар даатгагчид ноогдох хэсэг

Даатгалын нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэгийг даатгалын төрөл хэлбэрээр эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацааны өөрчлөлтийн дүнг тодруулна.

8. Бараа материал

Бараа материалыг түхий эд материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, хангамжийн материал болон бусад гэж ангилан, эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацаанд нэмэгдсэн (худалдан авсан, үйлдвэрлэсэн), хасагдсан (борлуулсан, ашигласан) дүн, үнийн бууралт, бууралтын буцаалтын дүнг тус тус тодруулна.

Бараа материалын өртгийг тодорхойлоход хэрэглэсэн (жинлэсэн дундаж өртгийн, эхэлж авснаа эхэлж зарлагдах, тусгай тэмдэглэгээний) арга, бараа материалын бүртгэлийн систем, өртөг болон цэвэр боломжит үнийн аль багыг сонгох арга зэргийг тэмдэглэл хэсэгт тодруулна.

Үнийн бууралт нь бараа материалын хуучрал, гэмтэл, иж бүрдлийн болон борлуулалтын өртгийн өсөлт, борлуулалтын үнийн бууралт болон бусад шалтгаанаар үүснэ. Аж ахуйн нэгж нь бараа материалын үнийн бууралтыг тооцох аргачлалыг боловсруулж тайлант үе бүрт тууштай мөрдөнө.

НББОУС 2 *Бараа материал* - д заасны дагуу бараа материалын цэвэр боломжит үнийг тайлант үе бүрт шинэчлэн тогтооно. Бараа материалын өртгийг цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл бууруулсан дүн болон бусад гарзыг тухайн тайлант үед зардлаар хүлээн

зөвшөөрнө. Цэвэр боломжит үнэ цэнийн өсөлтөөс үүсэх үнийн бууралтын буцаалтыг тухайн буцаах бичилт гарсан тайлант үе дэх зардлаар хүлээн зөвшөөрсөн бараа материалын дүнгийн бууралт гэж бүртгэнэ.

9. Урьдчилж төлсөн зардал/тооцоо

Урьдчилгаа төлбөрүүдийг төрөл тус бүрээр нь тодруулна. Тухайлбал, урьдчилж төлсөн даатгалын гэрээний зардал, урьдчилж төлсөн түрээс, даатгал, бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа болон бусад урьдчилгаа төлбөрийн эхний болон эцсийн үлдэгдлийн дүнг харуулна.

10. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (эсвэл борлуулах бүлэг хөрөнгө) болон өр төлбөр

СТОУС 5 *Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа* - д заасны дагуу тодруулна.

11. Үндсэн хөрөнгө

НББОУС 16 *Үндсэн хөрөнгө* - д заасны дагуу үндсэн хөрөнгийн анги тус бүрийн эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацаанд нэмэгдсэн, хасагдсан дүн, хуримтлагдсан элэгдэл дансны эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацааны өөрчлөлтийг тодруулна. Үндсэн хөрөнгийн зүйлийг дахин ангилсан бол тодруулна. Үндсэн хөрөнгийн дансны цэвэр дүнг хөрөнгө тус бүрээр харуулна. Тэмдэглэл хэсэгт дансны үнийг тодорхойлоход ашигласан суурь, элэгдэл тооцсон арга, дахин үнэлгээний талаарх мэдээллийг тодруулна.

12. Биет бус хөрөнгө

НББОУС 38 *Биет бус хөрөнгө* - д заасны дагуу биет бус хөрөнгийн анги тус бүрийн эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацаанд нэмэгдсэн, хасагдсан дүн, хуримтлагдсан хорогдол дансны эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацааны өөрчлөлтийг тодруулна. Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа (хэрэв ашиглалтын тодорхой хугацаагүй бол энэ талаар тодруулна), хорогдуулгын хувь, хорогдол тооцсон арга, дахин үнэлгээний талаарх болон бусад мэдээллийг тодруулна.

13. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын төрөл, дүн, бий болсон олз, гарзын дүнг тодруулна. Охин компани, хамтын хяналттай аж ахуйн нэгж, хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтыг НББОУС 27 *Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан* - ийн дагуу тодруулна.

14. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө²¹

НББОУС 40 *Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө* - д заасны дагуу тодруулна.

15. Бусад эргэлтийн бус хөрөнгө

Санхүүгийн байдлын тайлангийн *Бусад эргэлтийн бус хөрөнгө* - ийн бүрэлдэхүүн тус бүрийн эхний болон эцсийн үлдэгдлийг тодруулж, тайлбар, тэмдэглэл хийнэ.

²¹ Аж ахуйн нэгж нь НББОУС 17 *Түрээс* болон НББОУС 40 *Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө* - д заасан тодруулгуудыг бэлтгэнэ.

1. ӨР ТӨЛБӨР

1.1 Дансны өглөг

Дансны өглөгийн төлөгдөх хугацаандаа байгаа, хугацаа хэтэрсэн гэж ангилсан дүнг тодруулна.

1.2 Татварын өр

ААНОАТ-ын, НӨАТ-ын, ХХОАТ-ын, ОАТ-ын болон бусад татвар, төлбөр, хураамжийн өрийг тодруулна.

1.3 Богино хугацаат зээл

Төгрөгөөр болон гадаад валютаар авсан богино хугацаат зээлийн эхний болон эцсийн үлдэгдлийг зээлийн ангилал, үзүүлэлт тус бүрээр тодруулна.

1.4 Богино хугацаат нөөц

НББОУС 37 *Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө*-ийн дагуу богино хугацаат нөөцийн ангилал, даатгалын төрөл хэлбэрээр эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацааны нөөцийн өсөлт, тайлант үед ашигласан нөөцийн дүн, тайлант үед ашиглаагүй буцаан бичсэн нөөцийн дүнг тодруулна. Тэмдэглэл хэсэгт урт хугацаат нөөцийн дүнг тодруулж бусад тайлбарыг хийнэ.

1.5 Бусад богино хугацаат өр төлбөр

Санхүүгийн байдлын тайлангийн *Бусад богино хугацаат өр төлбөр* - ийн бүрэлдэхүүн тус бүрийн эхний болон эцсийн үлдэгдэл, гадаад валютаар илэрхийлэгдсэн дүнг тодруулна.

1.6 Урт хугацаат зээл ба бусад урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат зээлийг дотоодын эх үүсвэрээс авсан, гадаадын эх үүсвэрээс шууд болон дамжуулан зээлдсэн, гадаад болон дотоодын зах зээлд гаргасан урт хугацаат бонд, өрийн бичгийн дүн, хэрэв нэгээс дээш төрлийн дотоодын болон гадаадын зээл авсан бол тус бүрийг нь тодруулна.

17 Эздийн өмч

17.1 Өмч

НББОУС 1 *Санхүүгийн тайлангийн томиулга* - д заасны дагуу компаниудын хувьд энгийн болон давуу эрхтэй хувьцааны тоо ширхэг, эхний болон эцсийн үлдэгдэл, өмч (хувьцаат капитал буюу хувь нийлүүлэгчдийн хөрөнгө) - ийн дүнд тайлант хугацаанд гарсан өөрчлөлтийг тодруулна.

17.2 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацаанд гарсан өөрчлөлтийн дүнг тодруулна.

17.3 Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц

Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц дансны эхний болон эцсийн үлдэгдэл, тайлант хугацаанд гадаад үйл ажиллагааны хөрвүүлэлтээс, бүртгэлийн валютыг толилуулгын валют руу хөрвүүлснээс үүссэн валютын хөрвүүлэлтийн зөрүүг тодруулна.

17.4 Эздийн өмчийн бусад хэсэг

“Эздийн өмчийн бусад хэсэг” - ийн бүрэлдэхүүн тус бүр (тухайлбал, ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн тогтоосон төлөвлөгөөнөөс үүссэн актуар олз, гарз, санхүүгийн хэрэглүүрийн бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарз, мөнгөн гүйлгээний хейдж дэх хейджийн хэрэглүүрээс үүссэн олз, гарз) - ийн дүнг тодруулна.

18. Хураамжийн орлого болон нөхөн төлбөр

Даатгалын компанийн хураамжийн орлого даатгалын хохирол нөхөн төлбөрийг даатгалын төрөл, хэлбэрээр ангилан тодруулна. Мөн хураамжийн орлогын буцаалт, хөнгөлөлт, давхар даатгалын хураамжийн дүнг тодруулна.

19. Бусад орлого, олз (гарз), ашиг (алдагдал)

19.1 Бусад орлого

Орлогын дэлгэрэнгүй тайлангийн *Бусад орлого* - ын дүнг тодруулна.

19.2 Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)

Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) - ыг гадаад валютаарх мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд хийсэн ханшийн тэгшитгэл, эргэлтийн авлага, өр төлбөр, эргэлтийн бус авлага, өр төлбөртэй холбоотой үүссэн, валютын арилжаанаас үүссэн ханшийн зөрүүний олз, гарз гэж тодруулна.

19.3 Бусад ашиг (алдагдал)

Орлогын дэлгэрэнгүй тайлангийн *Бусад ашиг (алдагдал)* - ын дүнг тодруулна. Тухайлбал, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс эсхүл данснаас хасахад үүссэн олз (гарз), хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз (ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн дүн), хөрөнгийн дахин үнэлгээний олз (гарз) болон бусад гэж дэлгэрэнгүй харуулна.

20. Зардал

20.1 Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардал

Ажиллагчдын цалингийн, нийгмийн даатгал шимтгэлийн, албан татвар, төлбөр, хураамжийн, томилолтын, бичиг хэргийн, шуудан холбооны, мэргэжлийн үйлчилгээний, сургалтын, сонин сэтгүүл захиалгын, даатгалын, цахилгаан, ус, дулаан зэрэг ашиглалтын, засварын, элэгдэл хорогдлын, түрээсийн, харуул хамгааллын, цэвэрлэгээ үйлчилгээний,

тээврийн, шатахууны, хүлээн авалтын, зар сурталчилгааны зардлуудыг борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын гэж ангилж тайлант оны болон өмнөх оны дүнг тодруулна.

20.2 Бусад зардал

Орлогын дэлгэрэнгүй тайлангийн *Бусад зардал* - ын дүнг тодруулна. Тухайлбал, алданги, торгууль, найдваргүй авлагын зардал, хандивийн болон бусад зардлыг харуулна.

20.3 Цалингийн зардал

Цалингийн зардал болон ажиллагчдын дундаж тоог үйлдвэрлэл, үйлчилгээний, борлуулалт маркетингийн, ерөнхий ба удирдлагын гэж ангилж тайлант оны болон өмнөх оны дүнг тодруулна.

21 Орлогын татварын зардал

Орлогын татварын зардал (орлого) - ын тайлант үеийн татварын зардал болон хойшлогдсон татварын зардал (орлого) - ын дүнг тодруулна.

22 Холбоотой талуудын тодруулга

НББОУС 24 *Холбоотой талуудын тодруулга* - д заасны дагуу толгой компанийн нэр, хэрэв хамгийн дээд хяналт тавигч тал нь ялгаатай бол тэрхүү хяналт тавигч компани, хувь хүний нэрийг, тэргүүлэх удирдлагын бүрэлдэхүүнд²² олгосон урт болон богино хугацааны тэтгэмж, ажил эрхлэлтийн дараах тэтгэмж, ажлаас халагдсаны тэтгэмж, хувьцаанд суурилсан төлбөр, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээг тодруулна.

23. Болзошгүй хөрөнгө ба өр төлбөр

НББОУС 37 *Нөөц, Болзошгүй өр төлбөр ба Болзошгүй хөрөнгө* - ийн дагуу аж ахуйн нэгж нь тайлангийн өдрийн байдлаарх хэрэгжих магадлалтай болзошгүй хөрөнгө ба болзошгүй өр төлбөрийн мөн чанар, хэрэв практик боломжтой бол тэдгээрийн санхүүгийн нөлөөний тооцооллыг тодруулна.

23. Тайлагналын үеийн дараах үйл явдал

НББОУС 10 *Тайлагналын үеийн дараах үйл явдал* - ын дагуу тайлагналын өдрийн дараах үл залруулагдах үйл явдлын материаллаг ангилал тус бүрийн хувьд мөн чанар, санхүүгийн нөлөөллийн тооцооллыг тодруулна. Хэрэв санхүүгийн нөлөөллийн тооцоолол хийх боломжгүй бол тайлбар, тэмдэглэл хийнэ.

24. Хөрөнгө оруулалт

Аж ахуйн нэгж нь тайлант хугацаанд хийсэн хөрөнгө оруулалтыг энэ хүснэгтийн дагуу заавал тодруулна.

Хөрөнгө оруулалт гэж аж ахуйн нэгжийн хуримтлалыг шинээр бий болгох, түүний техникийн зэвсэглэмжийг дээшлүүлэн өргөтгөх, сайжруулахад зориулж, тайлант хугацаанд зарцуулсан хөрөнгө, хайгуул, зураг төсвийн ажлын зардлыг хэлнэ.

Аж ахуйн нэгж нь тайлант хугацаанд бий болсон, худалдаж авсан биет болон биет бус

хөрөнгө, хайгуул, үнэлгээний хөрөнгийг эх үүсвэр бүр (өөрийн хөрөнгө өр, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр, банкны зээлээр, гадаадын шууд хөрөнгө оруулалт, зээл, буцалтгүй тусламжаар, төсөл, хөтөлбөр, хандивын хүрээнд болон бусад эх үүсвэр) - ээр тодруулна.

Биет хөрөнгө гэдэгт аж ахуйн нэгжийн санхүүгийн байдлын тайланд тусгасан үндсэн хөрөнгөнд хамаарах хөрөнгө, эргэлтийн бус биологийн хөрөнгө болон бусад биет хөрөнгийг (тухайлбал, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө) хамруулна. Барилга, байгууламжийн²³ дунд багтсан орон сууцны барилга²⁴, авто замын²⁵ дүнг тусад нь тодруулна. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дүнг тусад нь тодруулна.

Биет бус хөрөнгө гэдэгт санхүүгийн байдлын тайланд тусгасан биет бус хөрөнгөнд хамаарах хөрөнгө орно.

Компютерийн програм хангамжийг дотор нь програм хангамж, мэдээллийн сан гэж ангилна.

Бусад биет бус хөрөнгөнд хамаарах барилгын зураг, төсвийн ажил, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын зардлыг тусад нь тодруулна.

²²Тэргүүлэх удирдлагын бүрэлдэхүүн гэж аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг шууд болон шууд бусаар төлөвлөх, удирдах, хянах эрх, үүрэг бүхий хүмүүс болон аж ахуйн нэгжийн гүйцэтгэх болон бусад захирлуудыг хэлнэ.

²³ Үйлдвэрлэл, худалдаа, нийтийн үзвэр, үйлчилгээний барилга, зочид буудал, зоогийн газар, боловсрол, эрүүл мэндийн байгууллагын барилга гэх мэт бүх төрлийн барилга болон авто зам, гудамж, онгоцны нислэгийн зам, гүүр, өргөгдсөн зам, туннель, газар доорх зам, усан зам, усан зогсоол, далан, хол зайд тавигдсан хоолой, холбооны болон эрчим хүчний шугам, кабель болон бусад шугам, олборлох, боловсруулах үйлдвэрийн байгууламж; спорт, амралтын байгууламж хамаарна.

²⁴ Хүн суурин амьдардаг орон сууцны зориулалттай барилга, оршин суугчдад зориулж суурилуулсан байгууламж, гараж зэргийг хамруулна.

²⁵ Авто замд авто зам, гудамж, онгоцны нислэгийн зам, өргөгдсөн зам, туннель зэрэг орно.

Санхүүгийн зохицуулах хорооны
2012 оны 12 дугаар сарын 26-ны
өдрийн 373 дугаар тогтоолын
дөрөвдүгээр хавсралт

ДААТГАЛЫН КОМПАНИД МӨРДӨХ НЯГТЛАН
БОДОХ БҮРТГЭЛИЙН ДАНСНЫ
ҮЛГЭРЧИЛСЭН ЗААВАР

УХА0410 5043239

А-1 Нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа даатгалын компани нь энэхүү дансны үлгэрчилсэн зааврыг үндэслэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэнэ.

1.2 Энэхүү үлгэрчилсэн заавар нь Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид СТОУС гэх), Монгол улсад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмууд дээр үндэслэсэн болно.

1.3 Энэхүү үлгэрчилсэн зааварт тулгуурлан даатгалын байгууллагууд дотооддоо СТОУС болон Монгол улсад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмуудад бүрэн нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам, дансны дэлгэрэнгүй жагсаалтыг боловсруулж мөрдөх шаардлагатай

1.4 Даатгалын байгууллагууд нь нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлж, ажил гүйлгээг давхар бичилтийн хэлбэрээр бүртгэнэ.

1.5 Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтийн нэгж нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөг, мөнгөөр илэрхийлэгдсэн байна.

1.6 Байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулж, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан бусад мэдээ баримтыг үнэн зөв гаргаж энэ талаар холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

А-2 Дансны нэгдсэн жагсаалт, дансдыг кодчилох нэгдсэн аргачлал

Дансны нэгдсэн жагсаалт нь даатгалын байгууллагын үйл ажиллагааны онцлогийг бүрэн тусгасан, нягтлан бодох бүртгэлээр дамжуулан хүлээн авах мэдээллийн хэрэгцээг бүрэн

хангахуйц бүртгэлийн үйл ажиллагааг СТОУС-ийн жишгийн дагуу ангилсан дансны нэр болон дугаараас бүрдсэн системчилсэн жагсаалт байна.

Дансны дугаар хэдэн оронтой байх нь тухайн байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, онцлог, удирдлагын мэдээллийн хэрэгцээнээс хамаарна.

Дансыг кодчилах аргачлал нь улсын хэмжээнд нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн нэгдсэн систем бүрлүүлэх зорилгод нийцсэн байна.

Дансны жагсаалт нь балансын болон орлого зардлын тайлангийн дансдуудаас бүрдэнэ.

Балансын дансад хөрөнгө, өр төлбөр, хөрөнгийн эх үүсвэрийн дансдууд хамаарах бөгөөд эдгээр данс тайлангийн үеийн эцэст үлдэгдэлтэй байна.

Орлого, зардлын дансдууд нь тайлангийн үеийн эцэст орлого, зарлагын нэгдсэн дансанд хаагдана.

Дансны дугаар нь үйл ажиллагааны онцлог, бүртгэлийн ажиллагааг компьютерээр болон гар аргаар боловсруулж байгаагаас хамааран дөрөв, зургаа, найман оронтой байж болно.

Улсын хэмжээнд дансны дугаарын эхний хоёр орон нэг ижил кодтой байна.

Энэхүү үлгэрчилсэн зааварт нийцүүлэн үндсэн дансыг туслах дансанд хэрхэн ангилахыг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээр тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг удирдлагаар батлуулж мөрдөнө.

А. БАЛАНСЫН ДАНС

ДД	Дансы бүлэг , нэр	Дансны үндсэн код	Дэд ангилал	Дансны дэд ангилалд код өгөх чиглэл
1	Нэг. Хөрөнгө <i>Мөнгөн хөрөнгө</i> Кассад байгаа бэлэн мөнгө	10	01	Төгрөгийн болон валютын түүнчлэн кассын няравын нэрээр, мөнгөний зориулалтаар ангилна.
2	Банкинд байгаа мөнгө	11	01	Данс нээсэн банк тус бүрээр төгрөгийн, валютын гэж ангилна.
3	<i>Богино хугацаат хөрөнгө</i> <i>Оруулалт</i>	13	01	Хадгаламж, түргэн борлогдох үнэт цаасаар хийсэн хөрөнгө оруулалт зэрэг хөрөнгө оруулалтын төрлөөр ангилна.
4	<i>Авлагын данс</i> Дансны авлага	12	01	Гадаад, дотоодын худалдан авагчид, ажилчин албан хаагчдаас авах авлага,

	Бусад авлага			банкны хадгаламжийн хүүгийн авлага, найдваргүй авлагын хасагдуулга, ажилчин албан хаагчдад дараа тайлангаар олгосон урьдчилгаа гэх мэт авлагын төрлөөр ангилна
	<i>Бараа материал</i>			
5	Түүхий эд, материал	14	01	Түүхий эд, материалыг эд хариуцагч, нярав тус бүрээр ангилна.
6	Дуусаагүй үйлдвэрлэл	14	01	Бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн нэр төрлөөр буюу шат дамжлага бүрээр ангилна.
7	Бэлэн бүтээгдэхүүн, бараа	15	01	Бэлэн бүтээгдэхүүн, барааны эд хариуцагч, нярав бүрээр ангилна.
8	Материал, сав баглаа, боодол	15		Эд хариуцагч тус бүрээр ангилна.
9	Түлш шатахуун	15		Хатуу, шингэн түлш болон эд хариуцагч бүрээр ангилна.
10	Сэлбэг хэрэгсэл	15		Сэлбэгийн төрөл, эд хариуцагч бүрээр ангилна.
11	Биологийн хөрөнгө	15		Мал, амьтад, ургамлын төрөлөөр болон арчлан хамгаалагч бүрээр ангилна.
12	Ажлын хувцас, бусад	15		Материалын төрөл, эд хариуцагч бүрээр ангилна.
13	<i>Урьдчилж төлсөн зардал</i> Урьдчилж төлсөн зардал/тооцоо	18	01...	Урьдчилж төлсөн зардал, тооцоо болон тэдгээрийн төрлөөр ангилна.
14	<i>Үндсэн хөрөнгө, түүний элэгдэл</i> Үндсэн хөрөнгө	20	01...	Үндсэн хөрөнгийг газар, үйлдвэрлэлийн болон барилга тоног төхөөрөмж, тавилга багаж хэрэгслэл, тээврийн хэрэгсэл гэх мэтээр ангилна.
15	Үндсэн хөрөнгийн элэгдэл	20	01...	Үндсэн хөрөнгийн ангилал тус бүрээр элэгдэл байгуулна.
16	Биет бус хөрөнгө	21	01...	Биет бус хөрөнгийн төрлөөр ангилна.
17	Хөрөнгө оруулалт	22	01...	Хөрөнгө оруулалтын төрлөөр ангилна.
	Хоёр. Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч			

<i>Өр төлбөрүүд</i>				
18	Дансны өглөг Бусад өглөг	31	01...	Бэлтгэн нийлүүлэгч байгууллага, нийгмийн даатгалын шимтгэл, цалингийн өглөг, төсөвт төлөх татварын өглөг гэх мэт өглөгийн төрлөөр ангилна.
19	Нөөц сангууд			Нөөц сангийн төрөл болон даатгалын хэлбэрээр ангилна
20	Урьдчилан төлөгдсөн орлого/Хураамжийн орлого/	32	01...	Даатгуулагчаас төлсөн хураамжийн орлогыг даатгалын хэлбэрээр ангилна.
21	Эзэмшигчдийн өмч	41	01...	Өөрийн хөрөнгийг энгийн болон давуу эрхтэй хувьцаа, нэмж төлөгдсөн капитал, хуримтлагдсан ашиг, тайлангийн үеийн ашиг, хандивласан болон дахин үнэлгээний данс гэх мэтээр ангилна

Б. ОРЛОГО, ЗАРДЛЫН ДАНС

Нэг. Борлуулалтын орлого				
22	Орлогод тооцсон хураамжийн орлого	51	01...	Даатгалын хэлбэрээр ангилна.
23	Борлуулалтын хөнгөлөлт	52	01...	Борлуулалтын буцаалт, борлуулалтын хөнгөлөлт гэх мэт төрлөөр ангилна.
Хоёр. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг				
24	Даатгалын нөхөн төлбөр	61	01...	Даатгалын нөхөн төлбөрийг даатгалын хэлбэрээр ангилна.
25	Удирдлагын зардал	70	01...	Удирдлагын ажиллагсдын цалин хөлс, шагнал ба хөнгөлөлтүүд, тэтгэвэр тусламж, томилолтын зардал, холбоо, ус гэрэл, халаалт, элэгдэл зэрэг зардлын зүйл тус бүрээр ангилна.

26	Борлуулалтын зардал	71	01...	Борлуулалтын ажиллагсдын цалин хөлс, шагнал ба хөнгөлөлтүүд, тэтгэвэр тусламж, томилолтын зардал, холбоо, ус гэрэл, халаалт, элэгдэл, маркетингийн зэрэг зардлын зүйл тус бүрээр ангилна.
27	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (олз)	84	01...	Хүү ба хөнгөлөлтийн орлого, ногдол ашиг, валютын ханшийн зөрүүгийн ашиг, үндсэн хөрөнгө, бараа материал худалдан борлуулсны ашиг, орон сууц, гуанз сувилалын орлого зэрэг эх үүсвэр бүрээр ангилна.
28	Үндсэн бус үйл ажиллагааны алдагдал (гарз)	87	01...	Хүү ба хөнгөлөлтийн зардал, валютын ханшийн зөрүүгийн алдагдал, үндсэн хөрөнгө, бараа материал худалдан борлуулсны алдагдал, орон сууц, гуанз сувиллын алдагдал зэрэг эх үүсвэр бүрээр ангилна.
29	Орлогын албан татварын зардал	91	01...	Төлбөл зохих орлогын албан татварыг бүртгэнэ.
30	Орлого, зарлагын нэгдсэн данс	92		

БАЛАНСЫН ДАНСДУУД

Б.ХӨРӨНГӨ

1. Тодорхойлолт

Хөрөнгө гэж аж ахуйн нэгжийн өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болсон, ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөхөөр хүлээгдэж буй нөөцийг хэлнэ.

Хөрөнгийг эргэлтийн, эргэлтийн бус гэж ангилна.

Б.1.1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

Дараах хөрөнгийг эргэлтийн хөрөнгөнд хамааруулан ойлгоно. Үүнд:

- (а) Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны циклийн хэвийн нөхцөлд ашиглахаар хүлээгдэж байгаа, эсхүл худалдан борлуулахаар эзэмшиж байгаа;
- (б) Нэн түрүүнд борлуулах зорилгоор эзэмшиж байгаа;
- (в) Тайлант өдрөөс хойш 12 сарын дотор хэрэгжихээр хүлээгдэж байгаа;

(г) Хөрөнгийн солилцоог хязгаарласнаас бусад тохиолдолд, тайлант өдрөөс хойш 12 сарын дотор өр төлбөрийг барагдуулахад ашиглах мөнгө болон мөнгөтэй адилтгах хөрөнгө.

Эргэлтийн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд дараах байдлаар ангилан толилуулна. Үүнд:

1. Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс
2. Дансны авлага
3. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага
4. Бусад авлага
5. Бусад санхүүгийн хөрөнгө
6. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсэг
7. Бараа материал
8. Урьдчилж төлсөн зардал/тооцоо
9. Бусад эргэлтийн хөрөнгө
10. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)

Б.1.1.1. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

1.Хамрах хүрээ

Касс болон банкны харилцах дансанд байгаа мөнгө, хугацаагүй хадгаламж, 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарласан тусгай зориулалт бүхий мөнгөн сан, үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацаатай хөрөнгө оруулалт хамаарна.

2. Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

Эдгээр хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэнэ. Гадаад валютыг нэр төрөл тус бүрээр нэрийн данс нээж Монголбанкнаас зарласан тухайн үеийн ханшаар тооцон төгрөгт хөрвүүлэн төгрөг, валютаар давхар бүртгэнэ. Гадаад валютын үлдэгдлийг Монголбанкнаас зарласан ханшаар тухай бүр тэгшитгэн тооцоо хийж гарсан зөрүүг тайлант хугацааны орлого, зарлагад хүлээн зөвшөөрнө.

3.Бүртгэл

Мөнгөн хөрөнгө нь гол төлөв аж ахуйн нэгж, байгууллагын бизнесийн үйл ажиллагаа (бараа бүтээгдэхүүний борлуулалт ба ажил үйлчилгээ) - наас орох орлого, төлбөрөөс бүрдэнэ. Үүнийг :

Дт Мөнгөн хөрөнгө

Кт Борлуулалт (Авлага, Даатгалын хураамжийн орлого)

Банкнаас зээл авах болон бусад үйл ажиллагаанаас мөнгөн орлого орсон тохиолдолд :

Дт Мөнгөн хөрөнгө

Кт Холбогдох дансад

Мөнгөн зарлагын үндсэн хэлбэр нь бараа, материал худалдан авсан болон бусад байгууллага, хүмүүсээс авсан төрөл бүрийн үйлчилгээний төлбөр байна. Үүнийг :

Дт Хөрөнгө/ (Зардал)/ Дансны өглөг

Кт Мөнгөн хөрөнгө

Татвар цалин гэх мэт бусад мөнгөн зарлага гарсан тохиолдолд:

Дт Татварын өглөг/ Цалингийн өглөг/ бусад холбогдох дансад

Кт Мөнгөн хөрөнгө

Жижиг мөнгөн сан нь тухайн байгууллагын бага хэмжээний урсгал зардлын төлбөрийн гүйлгээг хийхэд зориулан нярав болон нягтлан бодогчоос өөр ажилтанд хариуцуулан байршуулсан бага хэмжээний мөнгө юм. Жижиг мөнгөн сангийн зориулалт болон доод хэмжээг тогтоох, байгуулах, зарцуулах, хянах ажиллагааг тухайн байгууллагын дотоод журмаар зохицуулна. Жижиг мөнгөн санг бэлэн мөнгөний дансдад нэрийн дансаар бүртгэнэ. Анх байгуулсан сангийн хэмжээг өөрчлөх үед дараах журналын бичилт хийнэ:

Нөхөн дүүргэх жижиг мөнгөн санг байгуулахад:

Дт Жижиг мөнгөн сан

Кт Мөнгө

Уг санг нөхөн дүүргэх үед (зарлагын баримтуудыг үндэслэн чек бичсэн дүнгээр) :

Дт Холбогдох зардлын данс

Кт Мөнгө

Жижиг мөнгөн сан дах мөнгөний хэмжээ илүүдэлтэй /дутагдалтай байна/ гэж үзвэл дараах тохируулгын бичилтийг хийнэ:

Дт Мөнгө

Кт Жижиг мөнгөн сан

Жижиг мөнгөн сангаас зарлагын гүйлгээ гарах үед ямар нэгэн бичилт хийгдэхгүй. Жижиг мөнгөн санг нөхөн дүүргэхийн өмнө уг сангийн хяналтыг хариуцсан ажилтан сангийн зарцуулалтын тайланг анхаар шатны баримттай тулгаж, зарцуулалт батлагдсан төсөв, журмын дагуу байгаа эсэхийг шалган баталгаажуулж, жижиг мөнгөн санд дүүргэлт хийх зөвшөөрөл олгоно.

Үүний дагуу жижиг мөнгөн сан хариуцсан ажилтан зарлагын баримтаа кассын няравт хүлээлгэн өгч, зарцуулсан хэмжээний мөнгийг кассаас авна.

Жижиг мөнгөн санг дүүргэж, касснаас зарлага гаргахад:

Дт Холбогдох зардал

Б.1.1.2 Дансны авлага**1.Хамрах хүрээ**

Аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах авлагын дүн орно. Салбар хоорондын тооцоогоор үүссэн өглөг, авлагыг салбар нэгж бүр дээр нэрийн данс нээж бүртгэнэ.

2. Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

Дансны авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд харуулна Өөрөөр хэлбэл, түүний нэрлэсэн үнээс найдваргүй авлагад байгуулсан хасагдуулга ба бусад заасан тохируулгыг хассан дүнгээр илэрхийлнэ.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн авлагыг балансын өдрийн Монгол банкны албан ханшаар хөрвүүлнэ.

3.Бүртгэл

а) Даатгалын хураамжийг хэсэгчлэн төлөхөөр гэрээ хийсэн тохиолдолд эхний төлбөр орж ирсэн үед үлдэх хэсгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Дт Даатгалын хураамжийн авлага

Кт Холбогдох даатгалын хураамжийн орлогын данс

б) Давхар даатгалын хураамжийн орлого орж ирэхээс өмнө давхар даатгагчид хураамжийн орлогыг урьдчилан шилжүүлбэл:

Дт Давхар даатгалын хураамжийн авлага

Кт Мөнгөн хөрөнгө

в) Авлага төлөгдөхөд :

Дт Мөнгөн хөрөнгө

Кт Давхар даатгалын хураамжийн авлага

г) “Борлуулалтын хөнгөлөлт“, “Борлуулалтын буцаалт“, “Үнийн бууралт“ зэрэг нь Борлуулалтын дансны сөрөг тохируулах дансууд юм. Шүүхийн шийдвэрээр нэхэмжлэн авах боломжгүй болсон авлагын дүнгээр:

Дт Найдваргүй авлагын хасагдуулга

Кт Дансны авлага

д) Урьдчилан тооцоолсон найдваргүй авлагын хасагдуулгыг борлуулалтын орлогын, эсвэл нийт авлагын дүнгийн тодорхой хувиар бодож тооцоолох бөгөөд энэ хэмжээгээр:

Дт Найдваргүй авлагын зардал

Кт Найдваргүй авлагын хасагдуулга

е) Найдваргүй гэж урьдчилан тооцсон авлагаас бүрэн буюу хэсэгчлэн хүлээн авах боломжтой болсон үед тайлант үеийн эцэст найдваргүй авлагын хасагдуулгийн дансанд дараах залруулах бичилт хийнэ :

Дт Найдваргүй авлагын хасагдуулга
Кт Найдваргүй авлагын зардал

ё) Найдваргүй болсон авлагыг данснаас хасахдаа :

Дт Найдваргүй авлагын хасагдуулга
Кт Дансны авлага

ж) Найдваргүй авлагыг данснаас шууд хасвал :

Дт Найдваргүй авлагын зардал
Кт Дансны авлага

з) Гадаад валютаар үүссэн авлагыг гүйлгээ гарсан өдөр мөрдөж буй Монгол банкны (цаашид албан гэх) ханшаар төгрөгт хөрвүүлэн бүртгэлд тусгана. Төлбөр хүлээн авсан өдрийн валютын албан ханш нь гүйлгээ гарсан өдрийн ханшаас хэлбэлзсэн хэмжээгээр ханшийн зөрүү бий болно. Ханшийн зөрүү нь ашигтай буюу алдагдалтай гарна. Ханшийн зөрүүг :

Ашигтай бол :

Дт Авлага
Кт Гадаад валютын ханшийн зөрүүгийн ашиг

Алдагдалтай бол :

Дт Гадаад валютын ханшийн зөрүүгийн алдагдал
Кт Авлага

Мөн гадаад валютаар гарсан авлагын үлдэгдлийг санхүүгийн тайланд тайлан гарах үеийн албан ханшаар шилжүүлэх бөгөөд гарсан ашиг алдагдлыг бүртгэлд дээрхийн адилаар тусгана.

Б.1.1.3. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

1. Хамрах хүрээ

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), бусад татвар, төлбөр, хураамжийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцсээрх илүү төлөгдсөн дүн орно.

2. Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

Улирал ба жилийн эцэс дэх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын дүн нь татвар, нийгмийн даатгалын байгууллагын баталгаажуулсан дүнтэй тэнцүү байна.

4. Бүртгэл

Илүү төлсөн татварыг хөрөнгөөр хүлээн зөвшөөрч

Дт Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага
Кт Татвар, нийгмийн даатгалын өр

Б.1.1.4. Бусад авлага

1. Хамрах хүрээ

Бусад байгууллага, хувь хүн, холбоотой талд өгсөн нэг хүртэлх жилийн хугацаатай буюу үйл ажиллагааны нэг циклийн дотор эргэн төлөгдөх зээл, үндсэн үйл ажиллагаатай холбогдолгүй үүссэн бусад авлага хамаарна.

2. Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

Дансны авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд харуулна

3. Бүртгэл

Авлага үүссэн үед нь:

Дт Бусад авлага

Кт Мөнгөн хөрөнгө, бусад холбогдох данс

Авлага төлөгдсөн үед

Дт Мөнгөн хөрөнгө, бусад холбогдох данс

Кт Бусад авлага

Б.1.1.5. Бусад санхүүгийн хөрөнгө

1. Хамрах хүрээ

3 сараас нэг жилийн хугацаатай хадгаламж, богино хугацаат өрийн болон өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт хамаарна.

Хөрөнгө оруулалт гэж тайлант үед хийх төлбөрийн хэмжээнээс давсан буюу түр зуур чөлөөтэй байгаа мөнгөн хөрөнгийг ашиг олох зорилгоор зарцуулж буй үйл ажиллагааг хэлнэ.

Зах зээлийн үнэлгээний зөрүү болон хүүнээс ашиг олох зорилгоор худалдан авсан түргэн борлогдох үнэт цаасыг Үнэт цаасаарх богино хугацаат хөрөнгө оруулалт гэнэ.

2. Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгахад СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга, СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр, НББОУС 32 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга - ийг дагаж мөрдөнө.

3. Бүртгэл

1. Хадгаламж хэлбэрийн хөрөнгө оруулалтын бүртгэл:

Дт Хадгаламж

Кт Мөнгөн хөрөнгө

Хүүгийн орлого:

Дт Мөнгөн хөрөнгө

Кт Хүүгийн орлого (Бусад ашиг)

2.Худалдан авсан түргэн борлогдох үнэт цаасыг өртгөөр нь:

Дт Түргэн борлогдох үнэт цаас (Үнэт цаасны төрлөөр)

Кт Мөнгөн хөрөнгө

Ногдол ашиг, эсвэл хүүгийн орлогын дүнгээр:

Дт Мөнгөн хөрөнгө

Кт Ногдол ашиг, хүүгийн орлого (Бусад ашиг)

3.Түргэн борлогдох үнэт цаасыг худалдан борлуулснаас үүссэн ашиг /алдагдал/-ийн дүнгээр:

Дт Мөнгө

Кт Түргэн борлогдох үнэт цаас

Түргэн борлогдох үнэт цаасыг худалдан борлуулсны ашиг

Б-1.1.6. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсэг

1. Хамрах хүрээ

СЗХ-ноос баталсан журмын дагуу орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийг тодорхойлж санхүүгийн байдлын тайлангийн энэ хэсэгт харуулна.

2. Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

Журмын дагуу тооцоолсон дүнгээр хэмжинэ.

3. Бүртгэл

Эцсийн үлдэглээс эхний үлдэгдэлийг хассан зөрүү нь нэмэх тэмдэгтэй бол

Дт Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсэг

Кт Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт (+)

Эцсийн үлдэглээс эхний үлдэгдэлийг хассан зөрүү нь хасах тэмдэгтэй бол

Дт Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт (-)

Кт Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсэг

Б-1.1.7. Даатгалын нөөцийн давхар даатгагчид ноогдох хэсэг

1. Хамрах хүрээ

СЗХ-ноос баталсан журмын дагуу Даатгалын нөөцийн давхар даатгагчид ноогдох хэсгийг тодорхойлж санхүүгийн байдлын тайлангийн энэ хэсэгт харуулна.

2. Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

Журмын дагуу тооцоолсон дүнгээр хэмжинэ.

3. Бүртгэл

Даатгалын нөөцийн давхар даатгагчид ноогдох хэсгийн тайлангийн өдрөөр тооцоологдсон байвал зохих нөөцийн дүнгээс эхний үлдэгдэлийг хассан зөрүү нь нэмэх тэмдэгтэй бол

Дт Даатгалын нөөцийн давхар даатгагчид ноогдох хэсэг

Кт Даатгалын нөөцийн өөрчлөлтийн давхар даатгагчид ноогдох хэсгийн өөрчлөлт
Даатгалын нөөцийн давхар даатгагчид ноогдох хэсгийн тайлангийн өдрөөр тооцоологдсон байвал зохих нөөцийн дүнгээс эхний үлдэгдэлийг хассан зөрүү нь хасах тэмдэгтэй бол

Дт Даатгалын нөөцийн өөрчлөлтийн давхар даатгагчид ноогдох хэсгийн өөрчлөлт

Кт Даатгалын нөөцийн давхар даатгагчид ноогдох хэсэг

Б-1.1.8. Бараа материал

1.Хамрах хүрээ

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө, үйлдвэрлэлийн дамжлагад байгаа зүйлс болон үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэх материал, хангамжийн зүйлс хамаарна.

2.Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

НББОУС 2 Бараа материал - д заасны дагуу бараа материалыг ортог⁷ болон цэвэр боломжит үнийн аль багаар нь үнэлнэ. Бараа материалын цэвэр боломжит үнийг тайлант үе бүрийн эцэст тооцно.

3.Бүртгэл

Бараа материалыг орлого болгосон өртгөөр :

Дт Бараа материал (Материалын холбогдох дансны дебетэд)

Кт Дансны өглөг/ Мөнгөн хөрөнгө

Бараа материалыг зарлага болгож буй хэмжээгээр :

Дт Үйлдвэрлэл Үйлчилгээний зардал

(Үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж тус бүрийн дансны дебетэд)

Кт Бараа материал

(Материалын холбогдох дансдын кредитээс)

Хэрэв бараа материалыг худалдах болон бусад зориулалтаар зарцуулбал :

Дт Мөнгөн хөрөнгө/ Авлага

Кт Бараа материал

Кт Бараа материал худалдан борлуулсны ашиг

Мөн Дт Бусад алдагдал

Кт Бараа материал

Б-1.1.9. Урьдчилж төлсөн зардал /тооцоо

1.Хамрах хүрээ

Тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зарлагыг (даатгалын төлөөлөгч, зуучлагчийн шимтгэл, түрээс г.м) санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн зүйл ангид хамааруулж, урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ. Ийм төрлийн зарлагыг дараагийн тайлант үеийн холбогдох зардалд нь шингээнэ.

Бараа материал, бусад зүйлсийг худалдан авахаар төлсөн урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоонд хамааруулна.

2.Хэмжилт хүлээн зөвшөөрөл

Төлөгдсөн хэмжээгээр урьдчилж төлсөн зардал тооцоо илэрхийлэгдэнэ.

3.Бүртгэл

Зуучлагч, төлөөлөгчид төлсөн урьдчилгаа ба урьдчилан гарсан зардлыг :

Дт Урьдчилж төлсөн даатгалын гэрээний зардал, төлбөрүүд
Кт Мөнгөн хөрөнгө

Зуучлагч, төлөөлөгчид төлсөн урьдчилгаа ба урьдчилж гарсан зардлын тухайн

тайлангийн үед ногдох хэмжээгээр :

Дт Бараа материал / Үйлдвэрлэлийн ба ерөнхий зардал
Кт Урьдчилж төлсөн даатгалын гэрээний зардал, төлбөрүүд

Б-1.1.10. Бусад эргэлтийн хөрөнгө

1. Хамрах хүрээ

Дээр тусгайлан толилуулснаас бусад эргэлтийн хөрөнгө (тухайлбал, эргэлтийн биологийн хөрөнгө) хамаарна.

2. Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

Өртгөөр нь хүлээн зөвшөөрнө

3. Бүртгэл

Хөрөнгө худалдан авбал:

Дт Бусад эргэлтийн хөрөнгө
Кт Мөнгө/Өглөг

Бусад эргэлтийн хөрөнгийг зарцуулах, худалдах үед

Дт Мөнгө/Авлага/ үйлдвэрлэлийн ба ерөнхий зардал
Кт Бусад эргэлтийн хөрөнгө

Б-1.1.11. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)

1.Хамрах хүрээ

Эргэлтийн бус хөрөнгө (эсвэл борлуулах бүлэг хөрөнгө) - ийн дансны үнийг үргэлжлүүлэн ашиглах замаар биш борлуулах замаар нөхөн олж авах бол уг хөрөнгө (эсвэл борлуулах бүлэг хөрөнгө) - ийг “Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө” гэж ангилна. Энэхүү хөрөнгө (эсвэл борлуулах бүлэг хөрөнгө) - ийг СТОУС 5 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа - д заасны дагуу бүртгэнэ.

2.Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-ийг бүртгэлийн дүн ба борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнэ хоёрын аль багаар нь бүртгэнэ. Энэ бүлэгт багтсан хөрөнгийг элэгдүүлэхгүй.

3.Бүртгэл

1. Эргэлтийн бус хөрөнгийн ангилал өөрчлөгдөн БЗЭБЭБХ-ийн ангилалд шилжсэн үед
Дт БЗЭБЭБХ

Кт Эргэлтийн бус хөрөнгө

2. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-ийн дүнг бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн хүртэл бууруулсан бол

Дт Борлуулалтын зардал

Кт БЗЭБЭБХ

2.Хөрөнгийн бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн дараагийн тайлант хугацаанд өссөн бол олзоор хүлээн зөвшөөрнө

Дт БЗЭБЭБХ

Кт Үнэ цэнийн бууралтын нөхөлт

Б-2.ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ

Санхүүгийн байдлын тайланд эргэлтийн бус хөрөнгийг дараах байдлаар ангилан толилуулна.

Үүнд:

1.Үндсэн хөрөнгө

2.Биет бус хөрөнгө

4.Урт хугацаат хөрөнгө оруулалт

6.Хойшлогдсон татварын хөрөнгө

7.Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

8.Бусад эргэлтийн бус хөрөнгө

Б-2.1. Үндсэн хөрөнгө

1.Хамрах хүрээ

Нэгээс дээш тайлант хугацаанд үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, бусдад түрээслүүлэх эсхүл захиргааны зориулалтаар ашиглаж байгаа биет хөрөнгө үндсэн хөрөнгөнд хамаарна.

2.Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

Үндсэн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дансны цэвэр дүнгээр нь толилуулна.

НББОУС 16 Үндсэн хөрөнгө - д заасны дагуу үндсэн хөрөнгийг анхны удаа өртгөөр нь, дараагийн тайлант үед өртгийн загвар эсхүл дахин үнэлгээний загварын аль нэгийг ашиглан бүртгэнэ.

3.Бүртгэл

А. Худалдан авсан үндсэн хөрөнгийг бүртгэх

Үндсэн хөрөнгийг мөнгөөр буюу дараа тооцоогоор худалдан авах үед :

Дт Үндсэн хөрөнгө

Кт Мөнгөн хөрөнгө/ Дансны өглөг

Бүтээн босгох ажлыг санхүүжүүлэх зорилгоор авсан зээлийн тухайн ажил эхлэхээс дуусах хүртэл хугацаанд гарсан хүүгийн зардлыг капиталжуулж уг хөрөнгийн өртөгт оруулж тооцно.

Б. Үндсэн хөрөнгийн солилцоог бүртгэх

Үндсэн хөрөнгийг хооронд нь солилцох гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа өгч байгаа болон авч байгаа хөрөнгийн аль тодорхой байгаа зах зээлийн үнэ дээр үндэслэдэг. Өөр төрлийн хөрөнгийг солилцож буй үед олз, гарзын аль алинийг нь хүлээн зөвшөөрнө. Харин ижил төрлийн хөрөнгө солилцож буй үед зөвхөн гарзыг хүлээн зөвшөөрч бүртгэх ба олзыг бүртгэхгүй.

Өөр төрлийн хөрөнгийг солилцох

Дт Үндсэн хөрөнгө/шинэ/

Дт Үндсэн хөрөнгө/хуучин/ийн хуримтлагдсан элэгдэл

Кт Үндсэн хөрөнгө/хуучин/

Кт Мөнгө

Кт Үндсэн хөрөнгө солилцсоны олз

Ижил төрлийн хөрөнгийг солилцохдоо олзыг бус гарзыг бүртгэдэг.

Дт Үндсэн хөрөнгө-шинэ

Дт Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл

Дт Үндсэн хөрөнгө солилцсоны гарз

Кт Үндсэн хөрөнгө-хуучин

Харин ижил төрлийн хөрөнгийг солилцохдоо олзыг хүлээн зөвшөөрдөггүй боловч солилцоонд бэлэн мөнгө оролцсон үед олзын тодорхой хэсгийг зөвшөөрч бүртгэдэг.

Дт Үндсэн хөрөнгө - шинэ

- Дт Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл
- Кт Үндсэн хөрөнгө - хуучин
- Кт Үндсэн хөрөнгө солилцсоны олз

В. Үндсэн хөрөнгийн элэгдлийн бүртгэл

- Дт Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал
- Кт Хуримтлагдсан элэгдэл

Г. Үндсэн хөрөнгө ашиглалтаас хасах

Үндсэн хөрөнгийг гадагш худалдах, шилжүүлэх, актлаж устгах үед түүний өртгийг үндсэн хөрөнгийн данснаас хасах ба хуримтлагдсан элэгдлийн данс хаагдсан байна.

Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн дансны бичилт нь :

- Дт Хуримтлагдсан элэгдэл
- Кт Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг худалдсан үнэ нь түүний дансны үнээс (дансны үнэ=анхны өртөг-хуримтлагдсан элэгдэл) их байвал үндсэн хөрөнгө худалдсаны олз, бага байвал гарзыг хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үндсэн хөрөнгийг дансны үлдэгдэл өртгөөс нь илүү үнээр борлуулсан бол:

- Дт Мөнгөн хөрөнгө
- Дт Хуримтлагдсан элэгдэл
- Кт Үндсэн хөрөнгө
- Кт Үндсэн хөрөнгө борлуулсны ашиг (олз)

Үндсэн хөрөнгийг дансны үлдэгдэл өртгөөс нь доогуур үнээр борлуулсан бол:

- Дт Мөнгөн хөрөнгө
- Дт Хуримтлагдсан элэгдэл
- Дт Үндсэн хөрөнгө борлуулсны алдагдал (гарз)
- Кт Үндсэн хөрөнгө

Харин бүрэн элэгдэхээс нь өмнө данснаас хасвал үндсэн хөрөнгийг данснаас хассаны гарзыг бүртгэх шаардлагатай.

- Дт Хуримтлагдсан элэгдэл
- Дт Үндсэн хөрөнгийг данснаас хассаны гарз
- Кт Үндсэн хөрөнгө

Д. Бэлэг, хандиваар олж бэлтгэх, бусдад бэлэглэх, хандивлах

Бэлэг, хандивын хөрөнгийг бүртгэхдээ хөрөнгийн зах зээлийн үнийг ашигладаг. Хандиваар авсан хөрөнгийг зах зээлийн үнээр нь Хандивласан капитал (Нэмж төлөгдсөн капиталын данс) дансанд бүртгэнэ.

- Дт Үндсэн хөрөнгө
- Кт Хандивласан капитал

Мөнгөн бус хөрөнгийг бусдад хандивласан бол уг хөрөнгийн зах зээлийн үнээр бүртгэнэ. Хөрөнгийн зах зээлийн ба дансны үнэ зөрүүтэй бол олз, гарзыг хүлээн зөвшөөрнө.

- Дт Хандивын зардал
- Кт Үндсэн хөрөнгө
- Кт Үндсэн хөрөнгийг данснаас хассаны олз

Эсвэл

- Дт Хандивын зардал
- Дт Үндсэн хөрөнгийг данснаас хассаны гарз
- Кт Үндсэн хөрөнгө

Хандивын зардлыг орлогын тайлангийн бусад орлого, зардал хэсэгт тусгана

Е. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ

Үндсэн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсний дараа дахин үнэлгээ хийсэн бол түүнийг дахин үнэлсэн дүнгээр тайлагнана.

1. Үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн үед түүний хуримтлагдсан элэгдлийг дараах аргуудын аль нэгээр нь тооцно .

а) Хуримтлагдсан элэгдлийг дансны үнийн өөрчлөлттэй хувь тэнцүүлж дахин тооцох бөгөөд балансад хөрөнгийг тайлагнах нийт дүн нь дахин үнэлсэн дүнтэй тэнцүү байна.

- Дт Үндсэн хөрөнгө
- Кт Хуримтлагдсан элэгдэл
- Кт Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

б) Нийт дансны үнээс хуримтлагдсан элэгдлийг хассан цэвэр дүнг дахин үнэлэгдсэн дүн хүртэл дахин тайлагнана.

- Дт Үндсэн хөрөнгө
- Кт Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

2. Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ өссөн бол уг өсөлтийг бусад орлогоор хүлээн зөвшөөрч эздийн өмчийн дор дахин үнэлгээний нэмэгдэл дансанд хуримтлуулан бүртгэнэ. Хэрэв өмнөх тайлант хугацаанд ижил хөрөнгийн хувьд дахин үнэлгээний бууралт гарсныг гарзаар бүртгэсэн бол тухайн тайлант хугацааны үнэ цэнийн өсөлтийг тайлант хугацааны олзоор хүлээн зөвшөөрнө.

Өмнөх тайлант үеийн үнэ цэнийн бууралт:

- Дт Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний гарз
- Кт Үндсэн хөрөнгө

Тухайн тайлант үеийн үнэ цэнийн өсөлт:

- Дт Үндсэн хөрөнгө
- Кт Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний олз
- Кт Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

3. Дахин үнэлэгдсэн хөрөнгийг данснаас хасах, устгах, элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн үед Дахин үнэлгээний нэмэгдлийг Хуримтлагдсан ашиг руу шилжүүлнэ.

Дт Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

Кт Хуримтлагдсан ашиг

Б-2.2.Биет бус хөрөнгө

1.Хамрах хүрээ

Биет бус хөрөнгө гэж биет шинж чанаргүй, тодорхойлж болохуйц, мөнгөн бус хөрөнгийг хэлнэ. Биет бус хөрөнгийг дараах байдлаар ангилна. Үүнд:

(а) Зохиогчийн эрх;

(б) Компьютерийн програм хангамж: Програм хангамж, мэдээллийн сан;

(в) Патент;

(г) Барааны тэмдэг;

(д) Тусгай зөвшөөрөл: Тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ, ашигт малтмалын хайгуулын

болон ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл;

(е) Газар эзэмших эрх;

(ж) Бусад биет бус хөрөнгө: Барилгын зураг, төсвийн ажил, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын зардал, хөгжүүлэлтийн зардал.

2.Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдол, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дансны цэвэр дүнгээр нь толилуулна.

Биет бус хөрөнгийг анхны удаа өртгөөр нь, дараагийн тайлант үед өртгийн загвар эсхүл дахин үнэлгээний загварын аль нэгийг нь ашиглан бүртгэнэ.

НББОУС 38 Биет бус хөрөнгө - д заасны дагуу биет бус хөрөнгийн дахин үнэлсэн дүн нь дараагийн тайлант үеийн хуримтлагдсан хорогдол ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байна.

3.Бүртгэл

Биет бус хөрөнгийг орлого болгох үед анхны өртгөөр нь :

Дт Биет бус хөрөнгө нэр төрлөөр нь

Кт Мөнгөн хөрөнгө / Дансны өглөг

Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг түүний ашиглалтын хугацаанд хорогдуулна. Биет бус хөрөнгөнөөс аж ахуйн нэгж хэдий хугацаанд өгөөж хүртэх нь тодорхойгүй байх үед ашиглалтын хугацаа тодорхойгүй биет бус хөрөнгө гэж үзнэ. Тодорхойгүй ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг хорогдуулахгүй. Харин жил бүрийн

эцэст түүний үнэ цэнэ буурсан эсэхийг шалгаж НББОУС 36 Хөрөнгийн үнэ цэнийн бууралтад нийцүүлэн бүртгэнэ.

Биет бус хөрөнгийн тайлангийн үед ногдох элэгдлийн зардлын дүнгээр :

Дт Элэгдлийн зардал

Кт Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг:

Дт Биет бус хөрөнгө нэр төрлөөр нь

Кт Дахин үнэлгээний нэмэгдэл

Биет бус хөрөнгийг хасах үед:

Дт Мөнгөн хөрөнгө / Дансны авлага

Кт Биет бус хөрөнгө нэр төрлөөр нь

Дт Дахин үнэлгээний нэмэгдэл :

Кт Хуримтлагдсан ашиг

Биет бус хөрөнгийг хасах үеийн ашиг алдагдлыг хүлээн зөвшөөрнө

Б-2.3 Урт хугацаат хөрөнгө оруулалт

1.Хамрах хүрээ

Урт хугацаат хөрөнгө оруулалтыг НББОУС 28 Хараат компани дахь хөрөнгө оруулалт, НББОУС 31 Хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоо, НББОУС 32 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга, СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр - ийн дагуу бүртгэж, тусдаа санхүүгийн тайланд НББОУС 27 Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлан - ийн дагуу толилуулна.

2.Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

Урт хугацаат хөрөнгө оруулалтыг ихэвчлэн олж бэлтгэсэн өртгөөр нь дансанд бүртгэдэг. Урт хугацаат хөрөнгө оруулалтын зах зээлийн үнэ цэнэ буурч байгаа тохиолдолд үнийн бууралтыг хөрөнгө оруулалт тус бүрээр тодорхойлж, балансад хүлээн зөвшөөрч тусгадаг. Урт хугацаат хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулалт бүрээр нь тооцохыг шаарддаг.

1.Хувьцаагаар хийсэн хөрөнгө оруулалтыг :

а. *Нэгтгэх арга (50-аас дээш хувийн эзэмшил)*- Санхүүжүүлж байгаа компанийхаа саналын эрхтэй хувьцааны 50- иас дээш хувийг эзэмшсэнээр санхүүжүүлэгч нь санхүүжигчийг хяналтандаа авч байгаа тул нэгтгэх аргыг хэрэглэнэ.

б. *Капиталын арга (20-50 хүртэлх хувийн эзэмшил)*- Санхүүжүүлж байгаа компанийхаа саналын эрхтэй хувьцааны 20-50 хүртэлх хувийг эзэмшвэл санхүүжүүлэгч нь хяналт тавих боломжгүй боловч санхүүжигчийнхаа санхүүгийн болон үйл ажиллагааны үндсэн бодлогод мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх тул өмчийн буюу капиталын аргыг хэрэглэнэ.

в. *Өртгийн арга (20 хүртэлх хувийн эзэмшил)*- Санхүүжүүлж байгаа компанийхаа саналын эрхтэй хувьцааны 20 хүртэлх хувийг эзэмшвэл санхүүжүүлэгч нь санхүүжигчийнхаа болон үйл ажиллагааны үндсэн бодлогод мэдэгдэхүйц нөлөө үзүүлж чадахгүй бөгөөд энэ үед хөрөнгө оруулалтыг өртгийн болон бодит үнэ цэнийн гэсэн аргуудаас сонгон бүртгэнэ.

2.Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг:

Өрийн үнэт цаасаарх урт хугацаат хөрөнгө оруулалтыг хөнгөлөлт буюу урамшууллын хорогдуулгаар тохируулсан өртгөөр тайлагнана.

3.Тодорхой зорилтыг хэрэгжүүлэхийн тулд мөнгө ба бусад хөрөнгийг нөөцөлснөөр бий болгосон урт хугацаат санг:

Тодорхой зорилтыг хэрэгжүүлэхийн тулд мөнгө ба бусад хөрөнгийг нөөцөлснөөр бий болгосон урт хугацаат санг мөнгөний дүн дээр сан дахь үнэт цаас ба бусад хөрөнгийн өртгийг нэмсэнээр бүртгэнэ.

4.Үл хөдлөх хөрөнгө ба бусад орлого бий болгох хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтыг:

Үл хөдлөх хөрөнгө ба бусад орлого бий болгох хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтыг өртөг ба бусад хөрөнгийн адил зохист байдлаар элэгдүүлсэн дүнгээр бүртгэдэг. Нөхөрлөл ба хамтарсан үйлдвэр дэх оролцоо, итгэмжлэл ба хөрөнгийн хувь оролцоог капиталаар бүртгэнэ.

3.Бүртгэл

1.Хувьцаагаар хийсэн хөрөнгө оруулалтын бүртгэл:

а.Өртгийн арга

Худалдан авсан өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг худалдан авсан үнээр нь :

Дт Хувьцаагаарх хөрөнгө оруулалт

Кт Мөнгө

Санхүүжүүлэгчээс мөнгөн ногдол ашиг хүлээн авсан үед :

Дт Мөнгө

Кт Хувьцаагаарх хөрөнгө оруулалт

б.Капиталын арга

Энэ нь хөрөнгө оруулалтын дансны үнэ нь санхүүжүүлэгчийн эзэмшиж буй хувьцааны хэмжээтэй шууд хамааралтайгаар санхүүжигчийн ашгийн хэмжээгээр өсөх бөгөөд санхүүжигчээс санхүүжүүлэгч нь хүлээн авсан ногдол ашгийн хэмжээгээр хөрөнгө оруулалтаа багасгадаг арга юм. Санхүүжигч компани ашигтай ажиллавал цэвэр хөрөнгө

нэмэгдэх бөгөөд зарласан ногдол ашиг болон алдагдлын дүнгээр цэвэр хөрөнгө нь хорогдоно. Иймээс энэхүү өөрчлөлтийг санхүүжүүлэгч нь өөрийн хөрөнгө оруулалтын дансандаа тусгана.

Санхүүжигч компанийн цэвэр ашигт эзлэх хувийн жингийн дүнгээр :

Дт Хөрөнгө оруулалт
Кт Хөрөнгө оруулалтын орлого

Санхүүжигч компанийн цэвэр алдагдалд эзлэх хувийн жингийн дүнгээр :

Дт Хөрөнгө оруулалтын алдагдал
Кт Хөрөнгө оруулалт

Санхүүжигч компаниас хүлээн авсан ногдол ашгийн дүнгээр :

Дт Мөнгө/ Ногдол ашгийн авлага
Кт Хөрөнгө оруулалт

Үнэт цаасыг худалдахад:

Дт Мөнгөн хөрөнгийн холбогдох данс
Кт Үнэт цаас борлуулсан орлого

Борлуулсан үнэт цаасны өртгийг:

Дт Борлуулсан үнэт цаасны өртөг/ орлого зарлагын нэгдсэн данс/
Кт Хувьцаагаарх хөрөнгө оруулалт

Тайлант хугацааны эцэст үнэт цаасны үлдэгдлээ бодит үнэ цэнээр үнэлж өртөг бодит үнэ цэнийн зөрүүгээр хэрэгжээгүй олз гарзыг тодорхойлон тохируулга бичилт хийнэ

Бодит үнэ цэнийн аргаар бүртгэвэл:

Бодит үнэ цэнэ өртгөөс бага бол:

Дт Үнэлгээний хэрэгжээгүй гарз
Кт Үнэт цаасны бодит үнэ цэнийн тохируулга

Бодит үнэ цэнэ өртгөөс их бол:

Дт Үнэт цаасны бодит үнэ цэнийн тохируулга
Кт Үнэлгээний хэрэгжээгүй олз

Дансны үнээс илүү гарсан санхүүжигчийн алдагдал.

Санхүүжүүлэгчийн хувьцааны эзэмшилд ногдох санхүүжигчийн алдагдал нь хөрөнгө оруулалтын бүртгэлийн үнээс их болбол :

1. Санхүүжүүлэгч нь капиталын аргыг ашиглахаа больж, нэмэлт алдагдлыг хүлээн зөвшөөрөхгүй байж болно.

2. Алдагдал нь хөрөнгө оруулалтын дүнгээр хязгаарлагдаагүй (ирээдүйд санхүүгийн дэмжлэг үзүүлэх баталгаатай бол) бөгөөд цаашид нэн удахгүй санхүүжигчийн үйл ажиллагаа ашигтай байхаар бол нэмэлт алдагдлыг санхүүжүүлэгч нь хүлээн зөвшөөрч болно.

2. Бондоор хийсэн хөрөнгө оруулалтын бүртгэл

Худалдан авсан бондын хөрөнгө оруулалтыг худалдан авсан үнээр нь :

Дт Бондоорх хөрөнгө оруулалт

Кт Мөнгө

Эсвэл бондын хөнгөлөлт (урамшуулал)-ыг тусад нь тооцсон бол бондын нэрлэсэн үнээр :

Дт Бондоорх хөрөнгө оруулалт

Кт Мөнгө

Кт Бондын хөнгөлөлт

Эсвэл

Дт Бондоорх хөрөнгө оруулалт

Дт Бондын урамшуулал

Кт Мөнгө

Хүү төлөгдөх хугацааны дундуур худалдан авсан бондын хуримтлагдсан хүүг нэмж төлөхөөр тооцсон бол:

Дт Бондоорх хөрөнгө оруулалт

Дт Хүүгийн авлага

Кт Мөнгө

Эсвэл

Дт Бондоорх хөрөнгө оруулалт

Дт Хүүгийн авлага

Кт Мөнгө

Кт Бондоорх хөрөнгө оруулалтын хөнгөлөлт

Бондын урамшуулал болон хөнгөлөлтийг элэгдүүлсэн (хуваарилсан) дүнгээр:

Дт Мөнгө

Дт Бондоорх хөрөнгө оруулалтын хөнгөлөлт

Кт Хүүгийн орлого

Эсвэл

Дт Мөнгө

Дт Бондоорх хөрөнгө оруулалт

Кт Хүүгийн орлого

Б.2-5.Хойшлогдсон татварын хөрөнгө

Хойшлогдсон татварын хөрөнгөнд хасагдах түр зөрүү болон ашиглагдаагүй татварын алдагдлыг дараагийн үе рүү шилжүүлэхтэй холбоотойгоор ирээдүйн тайлант үед нөхөгдөх орлогын албан татварын дүн хамаарна.

2.Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

Хойшлогдсон татварын хөрөнгийг НББОУС 12 Орлогын албан татвар - ын дагуу тооцож бүртгэнэ.

3.Бүртгэл

1.Хасагдах түр зөрүү үүссэн үед:

Дт Орлогын албан татварын зардал

Дт Хойшлогдсон татварын хөрөнгө

Кт Орлогын албан татварын өглөг

2.Хойшлогдсон татварын хөрөнгийг буцаах үед

Дт Орлогын албан татварын зардал

Кт Хойшлогдсон татварын хөрөнгө

3.Алдагдлыг шилжүүлэх бүртгэл

Алдагдлыг шилжүүлэх бүртгэл нь татварын нөлөөллөөрөө хойшлогдсон татварын хөрөнгийг үүсгэнэ.

Дт Хойшлогдсон татварын хөрөнгө

Кт Шилжүүлэгдэх орлогын албан татвар

4.Шилжүүлэгдэх алдагдлыг бүртгэх

Дт Орлогын албан татварын өглөг

Дт Шилжүүлэгдэх орлогын албан татвар

Кт Хойшлогдсон татварын хөрөнгө

Кт Мөнгөн хөрөнгө

5.Шилжигдээгүй орлогын албан татварыг хаах

Дт Шилжигдээгүй орлогын албан татвар

Кт Хойшлогдсон татварын хөрөнгө

Б-2.6. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

1.Хамрах хүрээ

Хөрөнгийн үнийг өсгөх, түрээсийн орлого олох эсхүл аль алиных нь зорилгоор эзэмшиж буй хөрөнгийг хамруулна.

2.Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

НББОУС 40 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө - д заасны дагуу уг хөрөнгийг анхны удаа өртгөөр нь, дараагийн тайлант үед бодит үнэ цэнэ эсхүл өртгөөр нь бүртгэнэ.

3.Бүртгэл

ХОЗҮХХ-ийн анхны удаагийн хүлээн зөвшөөрөлт

Дт ХОЗҮХХ

Кт Мөнгөн хөрөнгө

ХОЗҮХХ-ийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз гарзыг үүссэн цаг хугацаанд нь олз гарзаар хүлээн зөвшөөрнө.

Дт ХОЗҮХХ

Кт ХОЗҮХХ-ийн үнэлгээний олз

Дт ХОЗҮХХ-ийн үнэлгээний гарз

Кт ХОЗҮХХ

Б.2.7.Бусад эрэгэлтийн бус хөрөнгө

Энэ хэсэгт дээр тусгайлан толилуулснаас бусад эргэлтийн бус хөрөнгийг хамруулна. Тухайлбал, аж ахуйн нэгжийн урт хугацаат зээлийн авлага болон бусад нэг жилээс дээш хугацаанд цуглуулах урт хугацаат авлагыг энэ хэсэгт толилуулна.

В.ӨР ТӨЛБӨР, ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

В.1.ӨР ТӨЛБӨР

1.Хамрах хүрээ

Өр төлбөр гэж компанийн үйл ажиллагаагаар бий болсон бусдын өмнө хүлээсэн эдийн засгийн үүрэг, хариуцлага юм.

Өр төлбөрийг үүссэн хугацаагаар нь богино хугацаат, урт хугацаат өр төлбөр гэж ангилна.

2.Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

Санхүүгийн бусад эх үүсвэрийн өглөгийг компани эргүүлж төлөх дүнгээр санхүүгийн тайланд бүртгэнэ. Холбогдох хөрөнгө, зардал буюу алдагдлыг хүлээн зөвшөөрсөн үед өр төлбөрийг бүртгэдэг.

В.1.1.БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

1. Хамрах хүрээ

Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны циклийн хэвийн нөхцөлд төлбөр нь төлөгдөхөөр хүлээгдэж байгаа эсхүл тайлангийн өдрөөс хойш 12 сарын дотор төлбөр нь төлөгдөх өр төлбөрийг богино хугацаат өр төлбөр гэнэ.

2.Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

Богино хугацаат өр төлбөрийг төлөгдөх дүнгээр нь бүртгэж санхүүгийн байдлын тайланд дараах байдлаар ангилан харуулна.

Үүнд:

- 1. Дансны өглог

2. Цалингийн өглөг
3. Татварын өр
4. Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг
5. Богино хугацаат зээл
6. Хүүний өглөг
7. Ногдол ашгийн өглөг
8. Урьдчилж орсон орлого
9. Нөөц (өр төлбөр)
10. Бусад богино хугацаат өр төлбөр
11. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хоронгө) - нд хамаарах өр төлбөр

3.Бүртгэл

1. Дансны өглөг

Үүнд бизнесийн үндсэн үйл ажиллагааны явцад бэлтгэн нийлүүлэгчдээс худалдан авсан бараа, хангамжийн зүйлс, үйлчилгээний үнийн төлөгдөөгүй үлдэгдэл хамаарна.

1.Худалдан авсан бараа, материал, үзүүлсэн ажил үйлчилгээний үнийг дараа төлөхөөр тооцоо үүсгэсэн бол:

Дт Бараа материал
Кт Дансны өглөг

Өглөгийг төлсөн үед

Дт Дансны өглөг
Кт Мөнгөн хөрөнгө

2. Цалингийн өглөг

Ажилчдад өгөх цалин, бусад хэлбэрийн хөдөлмөрийн хөлсний өр төлбөрийн дүн хамаарна.

Ажилчин албан хаагчдын цалин хөлсний өглөгийг:

Дт Цалингийн зардал
Кт Цалингийн өглөг

Цалинг олгосон үед:

Дт Цалингийн өглөг
Кт Мөнгөн хөрөнгө

Цалингаас суутгасан суутгалууд

Дт Цалингийн өглөг
Кт ХАОАТ, НДШ, Өр төлбөр

3. Татварын өр

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ), онцгой албан татвар (ОАТ)-ын өр, бусад татвар, төлбөр, хураамжийн тайлант хугацааны эцэст төлөгдөөгүй үлдэгдэл хамаарна. Улирал ба жилийн эцэс дэх төлөгдөөгүй татварын үлдэгдэл нь татварын байгууллагаас баталгаажуулсан үлдэгдэлтэй тэнцүү байна.

Тайлант жилд төлөх орлогын татварын өглөг нь санхүүгийн тайланд тусгасан орлогын татварын зардлын дүнгээс зөрүүтэй байж болно.

Орлогын татварын зардал нь тайлант татварын зардал (тухайн хугацааны орлогын татварын өглөгийн дүнтэй тэнцүү) ба хойшлуулсан татварын зардал гэсэн 2 бүрэлдэхүүн хэсэгтэй.

Хойшлуулсан татварын өглөг нь тайлант жилийн эцэс дэх татвар ногдох түр зөрүүгийн үр дүнд ирээдүйд гарах татварын өглөгийн өсөлтийг илэрхийлнэ.

Хойшлуулсан татварын зардал нь тайлант хугацааны эхнээс эцэс хүртэлх хойшлуулсан татварын өглөг дансны үлдэгдлээр тодорхойлогдоно.

Аж ахуйн нэгж байгууллагын орлогын татварын зардлын хэмжээгээр:

Дт Орлогын татварын зардал
Кт Орлогын татварын өглөг
Кт Хойшлуулсан татварын өглөг

Хойшлуулсан татварын хөрөнгө нь тайлант жилийн эцэс дэх хасагдах түр зөрүүгийн үр дүнд ирээдүйн жилүүдийн буцаан олгогдох татварын өсөлтийг илэрхийлнэ.

Дт Орлогын татварын зардал
Дт Хойшлуулсан татварын хөрөнгө
Кт Орлогын татварын өглөг гэж бүртгэнэ.

Төлсөн татварын дүнгээр:

Дт Орлогын татварын өглөг
Кт Мөнгөн хөрөнгө

"Татварын зардал" дансыг Орлого, зарлагын нэгдсэн дансанд хаана.

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэгдсэн аж ахуйн нэгж, байгууллага гаднаас авсан бараа материалд ногдох НӨАТ-ын дүнгээр:

Дт НӨАТатварын авлага
Кт Мөнгөн хөрөнгө/Дансны өглөг гэж бичнэ.

Гадагш худалдсан бараа материал, үзүүлсэн ажил үйлчилгээнд ногдох нэмэгдсэн өртгийн албан татварын хэмжээгээр:

Дт Мөнгөн хөрөнгө/Дансны авлага
Кт НӨАТатварын өглөг

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэгдээгүй аж ахуйн нэгж, байгууллага импортоор болон бусад байгууллагаас авсан бараа, ажил үйлчилгээнд ногдох нэмэгдсэн өртгийн татварыг уг бараа, ажил үйлчилгээний өртөгт оруулан:

Дт Бараа материал

Кт Мөнгөн хөрөнгө/Өглөг гэж бичнэ.

Үл хөдлөх хөрөнгийн албан татварыг бүртгэх:

Үл хөдлөх хөрөнгийн дүнгээс төлөхөөр тооцсон дүнгээр:

Дт Хөрөнгийн татварын зардал

Кт Хөрөнгийн татварын өглөг

Үл хөдлөх хөрөнгийн татварыг төлсөн дүнгээр:

Дт Хөрөнгийн татварын өглөг

Кт Мөнгө

Газар, байгалийн нөөц ашигласны төлбөр, тээврийн болон өөрөө явагч хэрэгслээс хураах татварыг үйлдвэрлэл, үйлчилгээний зардалд шингээж:

Дт Зардлын дансууд

Кт Газар, байгалийн нөөц ашигласны өглөг гэж бүртгэнэ.

Борлуулсан бараанд ногдох онцгой татварыг бүртгэхдээ:

Дт Борлуулсан бүтээгдэхүүний өртөг

Кт Онцгой татварын өглөг

Төлөхөөр тооцоолсон хүн амын орлогын татварыг:

Дт Цалингийн өглөг

Кт Хүн амын орлогын татварын өглөг

4. Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг

Цалингаас суутгасан болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцэст төлөгдөөгүй үлдэгдлийг тооцон энэ хэсэгт тусгана.

Нийгмийн даатгалын байгууллагад өгөх даатгалын өглөгийг:

Дт Зардлын холбогдох дансад

Кт Холбогдох даатгалын өглөг

5. Богино хугацаат зээл

Нэг хүртэлх жилийн хугацаатай авсан зээл хамаарна.

Бараа материал худалдаж авахад зориулж банкнаас богино хугацаатай зээл авсан бол:

Дт Мөнгөн хөрөнгө

Кт Банкны богино хугацаатай зээл

Бэлтгэн нийлүүлэгчид төлөх өрийг богино хугацаатай зээлээр төлсөн үед:

Дт Дансны өглөг

Кт Банкны богино хугацаатай зээл

Худалдан авсан бараа материалын үнийг төлөх тухайгаа баталж, хүүтэй вексель гаргасан бол бараа материалын дансанд векселийн нэрлэсэн үнээр бүртгэнэ.

- Дт Бараа материал
- Дт Хүүгийн зардал
- Кт Векселийн өглөг

Хүү тооцдоггүй векселийг бүртгэхдээ хөнгөлөлт тооцох ба Өрийн бичгийн эсрэг "Өрийн бичгийн хөнгөлөлт" гэсэн тохируулах дансыг ашиглана. Векселийн өглөг дансны кредитээс Бараа материал дансны дебетэд төлбөл зохих өглөгийн дүнгээр бүртгэнэ:

- Дт Бараа материал
- Дт Хүүгийн зардал
- Кт Векселийн өглөг
- Кт Векселийн өглөгийн хөнгөлөлт

6. Хүүний өглөг

Богино болон урт хугацаат зээл, өрийн үнэт цаастай холбоотой үүссэн, төлөгдөөгүй байгаа хүүний төлбөрийн дүнг энд тусгана.

Зээлийн хүүг тооцсон тохиолдолд

- Дт Хүүгийн зардал
- Кт Хүүний өглөг

Хүүг төлөх үед:

- Дт Хүүний өглөг
- Кт Мөнгөн хөрөнгө

7. Ногдол ашгийн өглөг

Тухайн аж ахуйн нэгжийн удирдах эрх бүхий байгууллагын шийдвэрээр хувьцаа эзэмшигч (хувь нийлүүлэгч)-д төлөхөөр зарласан ногдол ашгийг энэ дансанд бүртгэнэ. Зөвхөн мөнгөн хэлбэрийн ногдол ашгийн тайлант хугацааны эцэс дэх төлөгдөөгүй үлдэгдлийг богино хугацаат өр гэж үзнэ.

Ногдол ашгийн бүртгэл

Ногдол ашгийн төрлүүд:

1. Мөнгөн ногдол ашиг
2. Хорооноор олгох ногдол ашиг-Мөнгөнөөс бусад тухайлбал, бараа, үл хөдлөх хөрөнгө, хөрөнгө оруулалт зэрэг хөрөнгөөр төлөх ногдол ашгийг хэлнэ. Энэ төрлийн ногдол ашгийг бүртгэхдээ шилжүүлэн өгсөн хөрөнгийн зах зээлийн үнээр бүртгэх ба хөрөнгийн данснаас хасалтын аливаа олз буюу гарзыг хүлээн зөвшөөрдөг.

3. Векселийн өглөгөөрх ногдол ашиг-Компани одоо ногдол ашиг төлөхийн оронд ногдол ашгийн төлбөрийг тодорхой хугацаагаар хойшлуулсан гэсэн үг. Өөрөөр хэлбэл, энэ нь тусгай хэлбэрийн өрийн бичиг юм.
4. Татан буулгалтын ногдол ашиг-Зарим үед компанийн капиталд төлсөн зүйлсийг ногдол ашиг олгоход ашигладаг. Өөрөөр хэлбэл, ашигт үндэслээгүй аливаа ногдол ашиг нь компанийн капиталд төлсөн зүйлсийн бууралт байх бөгөөд энэ хэмжээгээр татан буулгалтын ногдол ашиг бий болно.
5. Хувьцаагаар олгох ногдол ашиг-Энэ тохиолдолд хөрөнгө хуваарилахгүй бөгөөд хувьцаагаар ногдол ашиг зарласны дараа хувьцаа эзэмшигч бүр компанид ногдол ашиг зарлахын өмнөхтэй яг адил хувь оролцоотой байна. Ногдол ашгийг зарлах үед хувьцаагаар олгох ногдол ашиг нь эргэлтэнд байгаа энгийн хувьцааны 20-25 хувиас бага тохиолдолд гаргах хувьцааны зах зээлийн үнээр хуримтлагдсан ашгаас шилжүүлдэг.

Мөнгөн ногдол ашгийг зарласан өдөр:

Дт Хуримтлагдсан ашиг
Кт Ногдол ашгийн өглөг

Мөнгөн ногдол ашиг олгосон өдөр:

Дт Ногдол ашгийн өглөг
Кт Мөнгө

Хөрөнгөөр ногдол ашиг олгохоор зарласан өдөр:

Дт Холбогдох хөрөнгийн данс
Кт Холбогдох хөрөнгийн дансны үнэлгээний олз

(Тухайн хөрөнгийн өртөг нь зах зээлийн үнээс бага байсан бол)

Дт Хуримтлагдсан ашиг
Кт Хөрөнгөөр олгох ногдол ашгийн өглөг

(Хуваарилах хөрөнгийн зах зээлийн үнэтэй тэнцүү дүнгээр)

Хөрөнгөөр ногдол ашиг олгосон өдөр:

Дт Хорооноор олгох ногдол ашгийн өглөг
Кт Холбогдох хөрөнгийн данс

Векселийн өглөгөөр ногдол ашиг зарласан өдөр:

Дт Хуримтлагдсан ашиг
Кт Хувьцаа эзэмшигчдэд төлөх векселийн өглөг

Векселийн өглөгийн ногдол ашгийг төлсөн өдөр:

Дт Хувьцаа эзэмшигчдэд төлөх векселийн өглөг
Дт Хүүгийн зардал

Кт Мөнгө

Татан буулгалтын ногдол ашгийг зарласан өдөр:

Дт Хуримтлагдсан ашиг

Дт Нэмж төлөгдсөн капитал

Кт Ногдол ашгийн өглөг

Эсвэл

Дт Нэмж төлөгдсөн капитал

Кт Ногдол ашгийн өглөг

Татан буулгалтын ногдол ашгийг олгосон өдөр:

Дт Ногдол ашгийн өглөг

Кт Мөнгө

Хувьцаагаар ногдол ашиг олгохоор зарласан өдөр-хувьцааны зах зээлийн үнээр:

Дт Хуримтлагдсан ашиг

Кт Энгийн хувьцаагаар хуваарилагдах ногдол ашиг

Кт Нэрлэсэн үнээс нэмж төлөгдсөн капитал

8. Урьдчилж орсон орлого

Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ үзүүлэхээс өмнө тэдгээрийн үнийг худалдан авагч эсхүл захиалагчаас урьдчилан хүлээн авсан тохиолдолд хүлээн авсан мөнгөний хэмжээгээр богино хугацаат өр үүсгэж “Урьдчилж орсон орлого” дансанд бүртгэнэ. Энэ дансыг бараа, үйлчилгээ үзүүлсэн буюу орлого хэрэгжсэн үед дебитлэж, холбогдох борлуулалтын орлогын дансыг кредитлэдэг.

Даатгалын компанийн хувьд давхар даатгалын комиссын орлого орж ирсэн үед нь урьдчилж орсон орлогоор хүлээн зөвшөөрч давхар даатгалын хураамжийн хүлээн зөвшөөрөлттэй уялдуулан тайлант үеийн орлогоор хүлээн зөвшөөрнө.

Давхар даатгалын комиссын орлого хүлээн авахаар тохирсон бол давхар даатгалын хураамжаас суутган

Дт Давхар даатгалын хураамжийн өглөг

Кт Урьдчилж орсон орлого- Давхар даатгалын комиссын орлого

Холбогдох давхар даатгалын шимтгэлийн зардлаар хүлээн зөвшөөрөлттэй уялдуулан давхар даатгалын комиссын орлогыг орлогоор хүлээн зөвшөөрсөн үед:

Дт Урьдчилж орсон орлого- Давхар даатгалын комиссын орлого

Кт Давхар даатгалын комиссын орлого

9. Нөөц (өр төлбөр)

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн үүрэг хариуцлагыг төлөх магадлалтай, төлбөрийн дүнг тооцоолох боломжтой болсон үед нь нөөц гэж хүлээн зөвшөөрнө. Нөөцийн бүртгэлд

НББОУС 37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө - г мөрдөнө.

Нөөц (өр төлбөр)-ийн тайлант хугацаанд хамаарах хэсгийг богино хугацаат өр төлбөрийн хэсэгт толилуулна.

Даатгалын нөөцүүдийн бүртгэл

Даатгалын компани нь нөөц санг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу тооцон байгуулна.

1. Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн бүртгэл/ОТХН/

Журмын дагуу тооцоологдсон тайлангийн өдрөөр байвал зохих орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн дансны үлдэгдлээс эхний үлдэгдлийг хассан зөрүү нь нэмэх тэмдэгтэй бол

Дт Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт, нийт дүнгээр (-)

Кт Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан

Журмын дагуу тооцоологдсон тайлангийн өдрөөр байвал зохих орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн дансны үлдэгдлээс эхний үлдэгдэлийг хассан зөрүү нь хасах тэмдэгтэй бол

Дт Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан

Кт Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт, нийт дүнгээр (+)

2. Нэхэмжилсэн хохирлын нөөцийн бүртгэл

Нэхэмжилсэн хохиролын нөөцийн үлдэгдлийг тайлан гаргаж буй өдрөөр даатгуулагчаас ирсэн боловч олгоогүй байгаа нэхэмжлэлийн дүнгээр тодорхойлно.

Нэхэмжилсэн хохирлын нөөцийн дансны эцсийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хассан зөрүү нь нэмэх тэмдэгтэй бол:

Дт Даатгалын нөөцийн өөрчлөлт, нийт дүнгээр (-)

Кт Нэхэмжилсэн хохирлын нөөц

Нэхэмжилсэн хохирлын нөөцийн дансны эцсийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хассан зөрүү нь хасах тэмдэгтэй бол

Дт Нэхэмжилсэн хохирлын нөөц

Кт Даатгалын нөөцийн өөрчлөлт, нийт дүнгээр (+)

3. Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөцийн бүртгэл

Энэ нөөцийг даатгалын тохиолдол нь тайлагналын өдөр буюу түүнээс өмнө бий болсон ба тайлант өдрөөс хойш нэхэмжилж болзошгүй нөхөн төлбөрийг барагдуулахад зориулан байгуулна. Уг нөөц санг өмнөх хугацааны даатгалын нөхөн төлбөрийн бодит мэдээлэлд үндэслэн актуар тооцооллоор тооцож байгуулна.

Дт Даатгалын нөөцийн өөрчлөлт, нийт дүнгээр

Кт Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц

4. Учирч болзошгүй хохирлын нөөцийн бүртгэл

Энэхүү нөөц сан нь тайлангийн хугацаанд даатгалын нөхөн төлбөрийн бодит түвшин нь тооцоолсон нөхөн төлбөрөөс давсан тохиолдолд тухайн хэсгийг нөхөн төлөхөд зориулсан нөөц сан юм.

Хэлбэр тус бүрийн хувьд балансын өдрөөрх хүчин төгөлдөр даатгалын гэрээнүүдээс үүсэх хүлээгдэж буй цэвэр мөнгөн гүйлгээ хасах дүнтэй ба уг дүн нь нөөц сангуудын нийлбэрээс (ОТХНС, НХНС, УБНХНС, УБХНС) их байгаа тохиолдолд дутуу хэсгийн хэмжээгээр энэхүү нөөцийг байгуулна.

Дт Даатгалын нөөцийн өөрчлөлт, нийт дүнгээр (-)

Кт Учирч болзошгүй хохирлын нөөц

4. Бусад богино хугацаат өр төлбөр

Бизнесийн үндсэн үйл ажиллагаанаас өөр чиглэлээр үүссэн өр, бизнесийн үйл ажиллагааны явцад үүссэн төрөл бүрийн суутгалууд, зардалд шингээж тооцсон төлөгдөөгүй өр, урт хугацаат өр төлбөрийн тайлант хугацаанд хамаарах хэсэг, худалдан авагчид болон ажиллагчдаас авсан буцаан төлөх мөнгөн барьцаа, холбоотой талаас авсан богино хугацаат зээл болон дээр тусгайлан толилуулснаас бусад богино хугацаат өрийг энэ хэсэгт толилуулна.

Дт Холбогдох данс

Кт Бусад богино хугацаат өр төлбөр

Өр төлбөр төлөгдсөн үед

Дт Бусад богино хугацаат өр төлбөр

Кт Мөнгө

5. Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр

СТОУС 5 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ба зогсоосон үйл ажиллагаа - д заасны борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөрийн дүнг толилуулна.

В.1.2. УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

1. Хамрах хүрээ

Урт хугацаат өр төлбөрт урт хугацаат зээл, нөөц (өр төлбөр), хойшлогдсон татварын өр, бусад урт хугацаат өр төлбөр хамаарна.

2. Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

Өр төлбөрийг төлөх ёстой дүнгээр үнэлнэ. Холбогдох хөрөнгө, зардал буюу алдагдлыг хүлээн зөвшөөрсөн үед өр төлбөрийг бүртгэдэг. Өр төлбөрийг арилжаагаар тогтоосон дүнгээр, ихэвчлэн төлсөн дүн, зарим тохиолдолд хөнгөлөлттэй дүнгээр хэмждэг. Өр

төлбөрийн дүнг илүү тодорхой хэмжиж чадахгүй тохиолдолд тодорхой шинж чанарын тооцооллоор хэмжиж болно.

1. Урт хугацаат зээл

Нэг жилээс дээш хугацаанд төлөгдөх дотоодын болон гадаадын эх үүсвэр, холбоотой талаас авсан зээлийн дүнг энэ хэсэгт толилуулна.

Зээл ,бусад эх үүсвэр авсан үед

Дт Мөнгөн хөрөнгө

Кт Урт хугацаат зээл/ бусад/

Тайлант хугацаанд хамрагдах хүүг тооцоолж

Дт Хүүгийн зардал /хөрөнгө /

Кт Зээлийн хүүгийн өр

Зээлийн төлөлт

Дт Урт хугацаат зээл

Кт Мөнгөн хөрөнгө

2. Нөөц (өр төлбөр)

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн үүрэг хариуцлагыг төлөх магадлалтай, төлбөрийн дүнг тооцоолох боломжтой болсон үед нь нөөц гэж хүлээн зөвшөөрнө. Нөөцийн бүртгэлд НББОУС 37 *Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө* - г мөрдөнө.

Даатгалын компанийн байгуулсан нөөц (өр төлбөр)-ийн урт хугацааны дүн хамаарна

3. Хойшлогдсон татварын өр

Хойшлогдсон татварын өр гэж татвар ногдох түр зөрүүтэй холбоотойгоор ирээдүйн тайлант үед төлөх орлогын албан татварын өрийн дүнг хэлнэ. Хойшлогдсон татварын өрийг НББОУС 12 Орлогын албан татвар - ын дагуу тооцож бүртгэлд тусгана.

Хойшлуулсан татварын зардал нь тайлант хугацааны эхнээс эцэс хүртэлх хойшлуулсан татварын өглөг дансны үлдэгдлээр тодорхойлогдоно.

1. Татвар ногдох түр зөрүү үүссэн үед:

Дт Татварын зардал

Кт Хойшлогдсон татварын өглөг

Кт Орлогын татварын өглөг

2. Хойшлогдсон татварын өглөгийг буцаах үед:

Дт Хойшлогдсон татварын өглөг

Кт Орлогын татварын өглөг

4. Бусад урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат бонд, өрийн бичиг болон бусад урт хугацаат өр төлбөрийн дүнг энэ хэсэгт толилуулна.

Бонд гэж шаардлагатай эх үүсвэрийг татан төвлөрүүлэх зорилгоор тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг эргүүлэн төлөх нөхцөлтэйгээр гаргасан өрийн бичгийг хэлнэ. Бонд нь нэрлэсэн үнээрээ худалдагдсан үед:

- Дт Мөнгөн хөрөнгө
- Кт Бондын өглөг

Бондын нэрлэсэн хүү нь зах зээлийн хүүгийн түвшингээс доогуур байгаа нөхцөлд уг бонд хөнгөлөлттэй худалдагдана. Өөрөөр хэлбэл, нэрлэсэн үнээс нь бага үнээр гаргалаа гэсэн үг.

Бондыг хөнгөлөлттэй гаргавал:

- Дт Мөнгөн хөрөнгө
- Дт Бондын хөнгөлөлт
- Кт Бондын өглөг

“Бондын хөнгөлөлт” данс нь Бондын өглөгийн дансны сөрөг тохируулах данс юм. Балансад бондыг тусгахдаа нэрлэсэн үнээс нь хөнгөлөлтийн дүнг хасч /урамшууллын дүнг нэмж/ өнөөгийн тооцсон өртөг буюу зах зээлийн үнээр харуулна

Бондын нэрлэсэн хүү нь зах зээлийн хүүгийн түвшнээс дээгүүр байгаа нөхцөлд уг бонд урамшуулалтай худалдагдана. Бондын урамшуулал нь Бондын өглөг дансны дүнг нэмэгдүүлнэ.

- Дт Мөнгөн хөрөнгө
- Кт Бондын өглөг
- Кт Бондын урамшуулал

Бондын урамшуулал нь санхүүжигчийн хүүгийн зардлыг тэр хэмжээгээр багасгадаг бол бондын хөнгөлөлт нь хүүгийн зардлыг нэмэгдүүлдэг. Бондын хөнгөлөлт, урамшуулал дансанд жил бүр хорогдуулга тооцох ба бондын төлбөрийн хугацаа дуусахад нэрлэсэн үнэтэйгээ тэнцүү болно.

Хорогдуулга тооцох үеийн жил бүрийн дансны бичилт нь:

- Дт Бондын хүүний зардал
- Кт Бондоорх өглөгийн хөнгөлөлт
- Кт Мөнгөн хөрөнгө

Урамшуулгын хорогдуулга

- Дт Бондын урамшуулал
- Дт Бондын хүүний зардал
- Кт Мөнгөн хөрөнгө

Бондын хугацаа дуусахад бондын үндсэн төлбөр, хөнгөлөлт, хүүг төлж дуусгасан байх ёстой ба үүнийг бондыг эргэлтээс гаргах гэнэ. Дансны бичилт нь:

- Дт Бондын өглөг
- Кт Мөнгөн хөрөнгө

Бондыг хугацаанаас нь өмнө эргэлтээс гаргавал /өөрөөр хэлбэл, буцааж худалдан авбал/ худалдан авах үеийг хүртэлх урамшуулал, хөнгөлөлт, бонд гаргалтын өртөг зэргийг тооцоолон ашиг, алдагдлын дансанд тусгана.

Дт Бондын өглөг

Дт Бондыг эргэлтээс гаргасны алдагдал

Кт Бондын хөнгөлөлт

Кт Мөнгөн хөрөнгө

Бондыг үнэт цаасанд хөрвүүлж эргэлтээс гаргах тохиолдол байдаг. Бондыг нэрлэсэн үнээс нь илүү үнээр хөрвүүлсэн бол:

Дт Бондын өглөг

Дт Бондын урамшуулал

Кт Энгийн хувьцаа

Кт Нэмж төлөгдсөн капитал

5. Урт хугацааны векселийн өглөгийн бүртгэл

Урт хугацааны вексельд төлөгдөх хугацаа, зарласан хүү зэрэг нь заагдсан байдгаараа бондтой төстэй. Вексель нь бондын нэг адил өнөөгийн үнэ цэнэтэй бөгөөд үүнийг ирээдүйн хүүнээс болон хөнгөлөлт, урамшууллын хасагдуулгагүй суурь дүнгээс үндэслэн тооцно.

Хүү авчирдаггүй векселийг зөвхөн мөнгөн төлбөрт зориулан гаргадаг бөгөөд түүний өнөөгийн үнэ цэнэ нь вексель гаргагчийн хүлээн авсан мөнгөн орлого болно.

Нэрлэсэн үнэ ба өнөөгийн үнэ хоёрын зөрүүг хөнгөлөлт, урамшуулал гэж үзэн хасагдуулга тооцож, хүүгийн зардлаар бүртгэнэ.

Дансны бичилт нь:

Дт Векселийн өглөгийн хөнгөлөлт

Дт Мөнгөн хөрөнгө

Кт Векселийн өглөг

Урамшуулалттай гаргасан векселийг бүртгэхдээ:

Дт Мөнгөн хөрөнгө

Кт Векселийн өглөг

Кт Векселийн өглөгийн урамшуулал

Өмч, хөрөнгө, бараа материал, үйлчилгээ зэрэг мөнгөн бус ажил гүйлгээнд холбогдох вексель гаргалтыг бүртгэхдээ:

Дт Өмч, хөрөнгө, бараа материал

Кт Векселийн өглөг

Энэ үед векселийн хөнгөлөлт, урамшуулал зэргийг тооцвол дансанд тусгаж хасагдуулга хийнэ.

Аж ахуйн нэгжийн өр төлбөрөө төлсний дараагаар үлдэх цэвэр хөрөнгийн хэмжээг эздийн өмч гэж үзнэ. Санхүүгийн байдлын тайланд эздийн өмчийг дараах байдлаар ангилна. Үүнд:

1. Өмч

Аж ахуйн нэгжийн төрлөөс хамаарч өмчийг хувьцаат капитал, гишүүдийн оруулсан хувь хөрөнгө, хоршоологчдын хувь нийлүүлсэн хөрөнгө гэж нэрлэнэ. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн хувьд өмчийг төрийн болон хувийн өмч гэж ангилж толилуулна.

Арилжаанд зөвшөөрөгдөн гарч буй хувьцаа нь тодорхой нэрлэсэн үнэтэй байна. Гаргасан хувьцааны борлогдсон хэсгийн нэрлэсэн үнийн дүнгээр нягтлан бодох бүртгэлд дараах бичилт хийнэ.

Дт Мөнгөн хөрөнгө

Кт Энгийн хувьцаа /Давуу эрхтэй хувьцаа/

Нэрлэсэн үнээс илүү үнээр борлогдсон хувьцааны үнийн зөрүүг :

Дт Мөнгөн хөрөнгө

Кт Нэмж төлөгдсөн капитал гэж бичнэ.

Нэрлэсэн үнээс доогуур үнээр борлогдсон хувьцааны үнийн хямдралтыг:

Дт Мөнгө

Дт Нэмж төлөгдсөн капитал

Кт Энгийн хувьцаа/Давуу эрхтэй хувьцаа гэж бичнэ .

Мөнгөнөөс бусад хэлбэрээр төлбөр хийгдсэн хувьцааг бүртгэлд тусгахдаа хувьцааны батлагдсан нэрлэсэн үнэ, зах зээлийн үнэ болон хөрөнгийн зах зээлийн үнийн аль алийг харгалзана. Хувьцааны нэрлэсэн үнээр /Энгийн хувьцаа/ нэрлэсэн үнээс хэлбэлзсэн хэмжээг /Нэмж төлөгдсөн капитал / дансанд дээрхийн адилаар бүртгэнэ.

Үнэт цаас гарган өмчийг бүрдүүлэхтэй холбоотойгоор дараах зардал гардаг.

- Хуульчийн хөлс
- Аудитын хөлс
- Үнэлгээчний хөлс
- Андеррайтерийн хөлс
- Сертификат ба бүртгэлийн мэдээг хэвлэх болон илгээх зардал
- Үнэт цаасны хороонд бүртгүүлэх зардал
- Бэлтгэхтэй холбогдсон бичиг хэргийн ба захиргааны зардал
- Хувьцаа гаргалтыг сурталчлах зардал

Хувьцаа гаргалтын анхны зардлыг тайлагнахдаа дараах хоёр аргыг хэрэглэнэ.

1. Хувьцаа гаргалтын зардлыг капиталд төлсөн дүнгээс хасагдах байдлаар авч үзнэ .

Дт Нэмж төлөгдсөн капитал

Кт Мөнгө эсвэл бараа материал

2. Хувьцаа гаргалтын зардлыг зохион байгуулалтын зардал байдлаар авч үзнэ.

Дт Биет бус хөрөнгө

Кт Мөнгө эсвэл бараа материал

2. Халаасны хувьцаа

Компаниуд гүйлгээнд гаргасан хувьцаагаа зах зээлээс эргүүлэн худалдан авсан халаасны хувьцааны дүнгээр өмчийн буюу хувьцаат капиталын дүнг бууруулна. Халаасны хувьцаа нь гаргасан хувьцааны тоонд орж тооцогдох боловч эргэлтэнд байгаа хувьцааны тоонд орохгүй. Аж ахуйн нэгж нь гүйлгээнд гаргасан хувьцаагаа зах зээлээс эргүүлэн худалдан авах, борлуулах, гаргах, хүчингүй болгох үед үүссэн олз (гарз)-ыг ашиг (алдагдал)-аар хүлээн зөвшөөрөхгүй.

Халаасны хувьцааг өртгийн арга, нэрлэсэн үнийн аргын аль нэгийг ашиглан бүртгэнэ.

А. ӨРТГИЙН АРГА

Энэ аргын дагуу худалдан авсан халаасны хувьцааг өртгөөр бүртгэх бөгөөд дахин гаргах үед үүнтэй адил өртгөөр кредитлэнэ. Халаасны хувьцааг худалдан авалтын өртгөөс илүү үнээр дахин гаргасан бол уг илүү дүнг Халаасны хувьцаанаас нэмж төлөгдсөн капитал гэсэн дансны кредитэд бүртгэнэ. Хэрэв худалдан авалтын өртгөөс бага үнээр дахин гаргавал Нэмж төлөгдсөн капитал дансанд бүртгэх ба уг дансны үлдэгдэл уг дүнг шингээхэд хүрэлцэхгүй бол хуримтлагдсан ашгийн бууралт болгон бүртгэнэ.

Худалдан авсан халаасны хувьцааг худалдан авсан үнэ буюу өртгөөр нь:

Дт Халаасны хувьцаа

Кт Мөнгө

Халаасны хувьцааг өртгөөс нь дээгүүр үнээр дахин гүйлгээнд гаргасан бол:

Дт Мөнгө

Кт Халаасны хувьцаа

Кт Халаасны хувьцаанаас нэмж төлөгдсөн капитал

Халаасны хувьцааг өртгөөс нь доогуур үнээр дахин гүйлгээнд гаргасан бол:

Эсвэл:

Дт Мөнгө

Дт Халаасны хувьцаанаас нэмж төлөгдсөн капитал

Кт Халаасны хувьцаа

Б.НЭРЛЭСЭН ҮНИЙН АРГА

Энэ аргын дагуу буцаан худалдан авсан халаасны хувьцааг нэрлэсэн үнээр бүртгэнэ. Анхны гаргалтын үнээс давсан худалдан авалтын өртгийн дүнгээр Онгийн хувьцааны нэмж

төлөгдсөн капитал дансыг дебетлэнэ. Харин анхны гаргалтын үнэ нь халаасны хувьцааг худалдан авсан үнээс илүү бол энэ зөрүүгээр Халаасны хувьцаанаас нэмж төлөгдсөн капитал дансыг кредитлэнэ.

Энгийн хувьцааг нэрлэсэн үнээс дээгүүр үнээр буцаан худалдан авсан бол:

- Дт Халаасны хувьцаа-нэрлэсэн үнээр
- Дт Нэрлэсэн үнээс нэмж төлөгдсөн капитал
- Кт Мөнгө

Энгийн хувьцааг нэрлэсэн үнээс доогуур үнээр буцаан худалдан авсан бол:

- Дт Халаасны хувьцаа-нэрлэсэн үнээр
- Кт Нэрлэсэн үнээс нэмж төлөгдсөн капитал
- Кт Мөнгө
- Кт Халаасны хувьцаанаас нэмж төлөгдсөн капитал

Халаасны хувьцааг эргэлтээс гаргах тохиолдолд энгийн болон халаасны хувьцаа дансыг нэгэн зэрэг бууруулна.

Нэмж төлөгдсөн капитал

Компанийн гаргасан энгийн хувьцаа болон давуу эрхтэй хувьцааны зах зээлийн үнэ нэрлэсэн үнээс нь илүү байвал зөрүүг нэмж төлөгдсөн капитал дансанд хуримтлуулан бүртгэнэ.

Хувьцааны нэрлэсэн үнэ зах зээлийн үнээс өндөр байгаа үед нэмж төлөгдсөн капитал данс нь сөрөг тохируулах данс болно.

Нэрлэсэн үнээс илүү үнээр борлогдсон хувьцааны үнийн зөрүүг :

- Дт Мөнгөн хөрөнгө
- Кт Нэмж төлөгдсөн капитал гэж бичнэ.

Нэрлэсэн үнээс доогуур үнээр борлогдсон хувьцааны үнийн хямдралтыг:

- Дт Мөнгө
- Дт Нэмж төлөгдсөн капитал
- Кт Энгийн хувьцаа/Давуу эрхтэй хувьцаа гэж бичнэ

3.Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

Аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны үнэ дахин үнэлгээний үр дүнд өссөн бол бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн өсөлтийн дүнг энэ дансанд хуримтлуулан бүртгэнэ. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансыг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү - өсөлт, үнэ цэнийн бууралтын гарзын буцаалтын дүнгээр нэмэгдүүлнэ.¹¹ Харин бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү - бууралт, үнэ цэнийн бууралтын гарз, хэрэгжсэн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнгээр энэ дансыг бууруулна.

Бүртгэл

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү – өсөлт болон үнэ цэнийн бууралтын гарзын буцаалт

Дт Үндсэн хөрөнгө

Кт Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

Дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү - бууралт, үнэ цэнийн бууралтын гарз, хэрэгжсэн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнгээр

Дт Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

Кт Үндсэн хөрөнгө

4. Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц

Аж ахуйн нэгжийн гадаад үйл ажиллагааг хөрвүүлснээс болон аж ахуйн нэгжийн бүртгэлийн валют толилуулгын валютаас ялгаатай байх үед санхүүгийн тайланг толилуулгын валют руу хөрвүүлснээс¹ үүссэн ханшийн зөрүүний хуримтлагдсан дүнг “гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц” гэж эздийн өмчийн хэсэгт толилуулна. Аж ахуйн нэгжийн гадаад үйл ажиллагааг болон санхүүгийн тайланг толилуулгын валют руу хэрхэн хөрвүүлэх, үүсэх ханшийн зөрүүг бүртгэхэд НББОУС 21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө - ийг мөрдөнө.

Гадаад валютын ажил гүйлгээний анхдагч хүлээн зөвшөөрөлт

1. Гадаад валютын ажил гүйлгээг уг ажил гүйлгээ гарсан өдрийн ханш буюу спот ханшийг ашиглан анх хүлээн зөвшөөрч ханшийн зөрүүг орлого буюу зардлаар хүлээн зөвшөөрнө.

Ашигтай бол:

Дт Хөрөнгө

Кт Мөнгөн хөрөнгө

Кт Валютын ханшны зөрүүгийн ашиг

Алдагдал хүлээвэл:

Дт Хөрөнгө

Дт Валютын ханшны зөрүүгийн алдагдал

Кт Мөнгөн хөрөнгө

2. Дараагийн хүлээн зөвшөөрөлт

Мөнгөн хөрөнгө буюу өр төлбөрийг хаалтын ханшаар

Дт Валютын мөнгөн хөрөнгө /Авлага/

Кт Валютын ханшны зөрүүгийн ашиг

Дт Ханшны зөрүүгийн алдагдал

Кт Өр төлбөр, мөнгөн хөрөнгө, авлага

5. Эздийн өмчийн бусад хэсэг

Энэ хэсэгт бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрч өмчийн хэсэгт хуримтлуулан бүртгэсэн бусад олз, гарзын дүнг толилуулна.

6. Хуримтлагдсан ашиг

Компанийн үүсэн байгуулагдсанаас хойшхи хугацаанд компанид хуримтлагдан үлдсэн ашиг, алдагдлын нийлбэрийг хуримтлагдсан ашиг дансанд бүртгэнэ.

Хуримтлагдсан ашиг нь анх оруулсан хөрөнгийг ашиглан бий болгосон нэмэлт эх үүсвэрийн хэмжээг илтгэнэ

Хуримтлагдсан ашгийн дансанд гарах ажил гүйлгээний дансны бичилт нь :

Цэвэр ашгийн хэмжээгээр :

Дт Тайлангийн үеийн ашиг

Кт Хуримтлагдсан ашиг

Алдагдлын хэмжээгээр :

Дт Хуримтлагдсан ашиг

Кт Тайлангийн үеийн алдагдал

Ногдол ашгийн хуваарилалтын хэмжээгээр:

Дт Хуримтлагдсан ашиг

Кт Ногдол ашгийн өглөг

Г. ОРЛОГО ЗАРЛАГА

Г.1.ОРЛОГО

1. Хамрах хүрээ

Орлого нь бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх буюу нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх, эсвэл аж ахуйн нэгж, байгууллагын байнгын ажиллагааг бүрдүүлэх бусад үйл ажиллагаанаас тухайн хугацаанд бий болсон хөрөнгийн дотогш урсгал, өр төлбөр барагдуулалт юм.

Тухайн хугацааны орлогыг ихэвчлэн зардлаас тусдаа тодорхойлдог.

Орлого ба олзыг агуулгаас нь хамааруулан дараах байдлаар ангилна:

1. Үндсэн үйл ажиллагааны

2. Үндсэн бус үйл ажиллагааны

2.Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

Орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжинэ. Орлогыг бүртгэхэд НББОУС 18-Орлого-ыг мөрдөнө.

3.Бүртгэл

1. Үндсэн үйл ажиллагааны орлого

Эрхэлж буй бизнесийн үндсэн үйл ажиллагаанаас бий болсон орлогыг үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлогод хамааруулдаг. Даатгалын компанийн хувьд даатгалын

хураамжийн орлого, давхар даатгалын комиссын орлого, буруутай этгээдээр төлүүлсэн хохирлын орлого хамаарна.

1.1.Хураамжийн орлого

Даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг даатгалын хураамжийн орлого гэнэ. Хураамжийн орлого орж ирсэн үед дараах бичилтийг хийнэ.

Дт Мөнгөн хөрөнгө

Кт Хураамжийн орлого

Даатгалын хураамжийг хэсэгчлэн төлж байгаа үед дараах бичилтийг хийнэ.

Дт Даатгалын хураамжийн авлага

Дт Мөнгөн хөрөнгө

Кт Хураамжийн орлого

Даатгалын гэрээний хугацаа дуусахаас өмнө даатгагчаас даатгуулагчид тухайн гэрээний үлдэх хугацаанд ногдуулан буцаан олгосон хураамжийн дүнгээр дараах бичилтийг хийнэ.

1.Хэрэв тухайн даатгалын гэрээ нь тухайн тайлант хугацаанд хийгдсэн гэрээ бол:

Дт Буцаасан хураамж

Кт Өглөг/ Бэлэн мөнгө

Хэрэв тухайн даатгалын гэрээ нь өмнөх тайлант хугацаанд хийгдсэн гэрээ бол:

Дт Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан

Кт Өглөг/ Бэлэн мөнгө

1.2.Давхар даатгалын хураамж

Даатгагч нь даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дотоод, гадаадын өөр даатгагчид дахин даатгаж төлөхөөр тооцсон дүнгээр :

Дт Давхар даатгалын хураамж

Кт Давхар даатгалын хураамжийн өглөг

Давхар даатгалын хураамжийг төлсөн үед

Дт Давхар даатгалын хураамжийн өглөг

Кт Мөнгөн хөрөнгө

1.3.Давхар даатгалын комиссийн орлого

Давхар даатгагчаас давхар даатгалын борлуулалтын шимтгэл хэлбэрээр даатгагчид буцаан төлсөн төлбөрийн тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрөгдөх хэсэг хамаарна.

Давхар даатгалын комиссын орлого орж ирсэн үед нь урьдчилж орсон орлогоор хүлээн зөвшөөрч давхар даатгалын хураамжийн хүлээн зөвшөөрөлттэй уялдуулан тайлант үеийн орлогоор хүлээн зөвшөөрнө.

Давхар даатгалын комиссын орлого хүлээн авахаар тохирсон бол давхар даатгалын хураамжаас суутган

Дт Давхар даатгалын хураамжийн өглөг

Кт Урьдчилж орсон орлого- Давхар даатгалын комиссын орлого
Холбогдох давхар даатгалын шимтгэлийн зардлаар хүлээн зөвшөөрөлттэй уялдуулан давхар даатгалын комиссын орлогыг орлогоор хүлээн зөвшөөрнө.

Дт Урьдчилж орсон орлого- Давхар даатгалын комиссын орлого

Кт Давхар даатгалын комиссын орлого

1.4.Буруутай этгээдээр төлүүлсэн орлого

Даатгуулагчид учирсан хохирлын нөхөн төлбөрийг буруутай этгээдээс төлүүлэх нь тодорхой бөгөөд эргэн төлөгдөх магадлал нь өндөр байгаа тохиолдолд тухайн дүнгээр орлого хүлээн зөвшөөрнө.

Дт Мөнгөн хөрөнгө/ хөрөнгө, авлага/

Кт Буруутай этгээдээр төлүүлсэн орлого

2.Үндсэн бус үйл ажиллагааны ашиг ба олз

Бусад орлого ба олз гэдэг нь аж ахуйн нэгж, байгууллагын байнгын бус буюу гэнэтийн ажил гүйлгээнээс түүнчлэн эздийн орлого буюу хөрөнгө оруулалтаас бусад тухайн тайлант хугацаанд уг аж ахуйн нэгж, байгууллагад нөлөөлөх бүх ажил гүйлгээ, үйл явдал нөхцөл байдлын үр дүнд өмчид (цэвэр хөрөнгөнд) гарсан өсөлт юм.

Түрээсийн төлбөр, нийгэм хангамжийн зориулалттай нэгжүүдээс орох орлого, гадаад валютын ханшийн зөрүүгийн ашиг, үндсэн хөрөнгө, материал борлуулсны, хүү, ногдол ашиг, үнэт цаас борлуулсны ашиг гэх мэт орлогууд энэ ангилалд хамаарагдана.

Аж ахуйн нэгж, байгууллагын хоёрдогч буюу туслах ажиллагааны үр дүн болох олсон орлого буюу олзыг ерөнхийдөө холбогдох зардлыг хассан цэвэр дүнгээр харуулна.

Гадаад валютын ханшийн хэлбэлзлийн бодит ашгийн хэмжээгээр:

Дт Гадаад валютын данс/Дансны авлага

Кт Валютын ханшийн зөрүүгийн бодит ашиг

Гадаад валютын ханшийн хэлбэлзлийн бодит бус ашгийн хэмжээгээр:

Дт Гадаад валютын данс/Дансны авлага

Кт Валютын ханшийн зөрүүгийн бодит бус ашиг

Үндсэн хөрөнгө борлуулсны ашиг:

Дт Мөнгө/Авлага

Кт Үндсэн хөрөнгө борлуулсны ашиг

Хүлээн авсан ногдол ашгийн дүнгээр:

Дт Мөнгө/Авлага

Кт Ногдол ашгийн орлого

Г.2. ЗАРДАЛ БА ГАРЗ

1. Хамрах хүрээ

Тайлангийн хугацааны туршид үйлчилгээ үзүүлэх, үндсэн үйл ажиллагааг байнга явуулахын тулд бусад үйл ажиллагааг гүйцэтгэснээр хөрөнгө буурах, өөр бусад байдлаар ашиглагдах эсвэл өр төлбөр үүсэх явдал юм.

Бусад зардал ба гарз гэдэг нь аж ахуйн нэгж, байгууллагын байнгын бус буюу гэнэтийн ажил гүйлгээнээс түүнчлэн эздийн зардал буюу өгсөн хуваарилалтаас бусад тухайн тайлант хугацаанд уг аж ахуйн нэгж, байгууллагад нөлөөлөх бүх ажил гүйлгээ, үйл явдал нөхцөл байдлын үр дүнд өмчид (цэвэр хөрөнгөнд) гарсан бууралт юм.

Зардлыг дараах байдлаар ангилж, Орлогын тайланд тусгана:

1. Даатгалын нөхөн төлбөр
2. Борлуулалт, маркетингийн зардал
3. Ерөнхий ба удирдлагын зардал
4. Үндсэн бус үйл ажиллагааны зардал ба гарз

Даатгалын нөхөн төлбөр гэдэг нь гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Үйл ажиллагааны зардал гэдэг нь тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээний өртөгт шууд хамаарагдахгүй боловч үйл ажиллагаатай холбогдон өдөр тутам гарч байдаг борлуулалт, маркетингийн зардал болон ерөнхий удирдлагын зардлын нийлбэрийг хэлнэ.

Борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын зардалд ажиллагчдын цалингийн, нийгмийн даатгал шимтгэлийн, албан татвар, төлбөр, хураамжийн, томилолтын, бичиг хэргийн, шуудан холбооны, мэргэжлийн үйлчилгээний, сургалтын, сонин сэтгүүл захиалгын, даатгалын, цахилгаан, ус, дулаан зэрэг ашиглалтын, засварын, элэгдэл хорогдлын, түрээсийн, харуул хамгааллын, цэвэрлэгээ үйлчилгээний, тээврийн, шатахууны, хүлээн авалтын, зар сурталчилгааны зардлууд хамрагдах бөгөөд борлуулалт маркетингийн болон ерөнхий ба удирдлагын гэж ангилан санхүүгийн байдлын тайланд харуулна.

Үндсэн бус үйл ажиллагааны зардал, гарз гэдэг нь компанийн хоёрдогч буюу туслах ажиллагааны үр дүн болон гарсан зардал буюу гарз юм. Эдгээрийг ихэвчлэн холбогдох орлогыг хассан цэвэр дүнгээр тайлагнана. Үйлдвэрлэлийн бус туслах нэгжүүдийн үйл ажиллагааны алдагдал, үндсэн хөрөнгө, материалыг ашиглалтаас хассаны болон борлуулалтын алдагдал, элдэв хүү, торгууль, гадаад валютын ханшийн зөрүүгийн алдагдал, үнэт цаасны арилжааны болон үнийн бууралтын алдагдал зэрэг алдагдлууд хамаарагдана.

2. Хэмжилт хүлээн зөвшөөрөлт

Зардлыг жэнхэнэ гарсан хэмжээгээр хэмжинэ.

3.Бүртгэл

А. Нөхөн төлбөр

Нөхөн төлбөр олгосон үед:

Дт Нөхөн төлбөр

Кт Мөнгөн хөрөнгө

Давхар даатгалын нөхөн төлбөр орж ирсэн болон авахаар тооцоолсон тохиолдолд:

Дт Мөнгөн хөрөнгө/Авлага/

Кт Давхар даатгалын нөхөн төлбөр

Б. Даатгалын гэрээний цэвэр зардал

Даатгалын төлөөлөгчийн шимтгэл, даатгалын зуучлагчийн төлбөрийн тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөгдөх хэсэг хамаарна.

Даатгалын төлөөлөгчийн шимтгэл, даатгалын зуучлагчийн төлбөрийг төлсөн үед урьдчилж төлсөн зардлаар хүлээн зөвшөөрч, холбогдох хураамжийг орлогоор хүлээн зөвшөөрсөн хувь хэмжээгээр зардлаар хүлээн зөвшөөрнө.

Даатгалын гэрээний төлбөрийг төлсөн үед:

Дт Урьдчилж төлсөн зардал- Даатгалын гэрээний зардал

Кт Мөнгө

Холбогдох хураамжийн орлогын орлогоор хүлээн зөвшөөрөлтэй уялдуулан даатгалын гэрээний зардлыг зардлаар хүлээн зөвшөөрсөн үед:

Дт Даатгалын гэрээний зардал

Кт Урьдчилж төлсөн зардал- Даатгалын гэрээний зардал

В. Ерөнхий удирдлага болон борлуулалт, маркетингийн ажиллагааны зардал

Ажиллагсдын тооцоолсон цалингийн зардлын хэмжээгээр:

Дт Цалингийн зардал

Кт Цалингийн өглөг

Элэгдлийн зардлын тооцсон хэмжээгээр:

Дт Элэгдлийн зардал

Кт Хуримтлагдсан элэгдэл

Хэрэглэсэн бичиг хэрэг, түлш шатахуун, хангамжийн бусад материалын хэмжээгээр:

Дт Бичиг хэргийн зардал

Дт Түлш шатахууны зардал

Дт Бусад хангамжийн материалын зардал

Кт Материал/Мөнгө/Дансны өглөг

Хэрэглэсэн цахилгаан, халаалт, уур ус буюу ашиглалтын зардлын ерөнхий үйл ажиллагаанд хуваарилагдан ногдох хэмжээгээр өглөг болгон тооцож, дараах бичилт хийнэ:

Дт Ашиглалтын зардал
Кт Дансны өглөг

Барилга байгууламжид хийгдсэн капиталчлагдаагүй зардлын дүнгээр:

Дт Засварын зардал
Кт Цалингийн өглөг
Кт Бараа материал
Кт Дансны өглөг
Кт Мөнгө

Хуулийн болон бусад мэргэжлийн байгууллагаар үйлчлүүлсний хөлс, гадны үйлчилгээний зардлын дүнгээр:

Дт Гадны үйлчилгээний зардал
Кт Дансны өглөг/Мөнгө

Албан томилолтын зардлын ерөнхий үйл ажиллагаанд ногдох дүнгээр:

Дт Албан томилолтын зардал
Кт Мөнгө
Кт Ажиллагсадтай хийх тооцооны данс

Эдгээр зардлын ангилал нь аливаа аж ахуйн нэгжийн хувьд нийтлэг ангилал юм. Үйл ажиллагааны онцлогоос хамааран өөр бусад зардлын ангилал байж болно. Зардлын ангиллын мөн чанар нь тухайн төрлийн зардал уг бизнесийн ажиллагаанд хир зэрэг ач холбогдолтойгоос шалтгаална. Үүнээс гадна зардлуудыг тодорхой нэгжүүдээр ангилан бүртгэж болно.

Үндсэн бус үйл ажиллагааны зардал ба гарзын бүртгэл

Аж ахуйн нэгж, байгууллагын хоёрдогч буюу туслах ажиллагааны үр дүн болох гарсан зардал буюу гарзыг ерөнхийдөө холбогдох орлогыг хассан цэвэр дүнгээр харуулна.

Гадаад валютын ханшийн хэлбэлзлийн бодит алдагдлын дүнгээр:

Дт Валютын ханшийн зөрүүгийн бодит алдагдал
Кт Гадаад валютын данс/Дансны авлага

Гадаад валютын ханшийн хэлбэлзлийн бодит бус алдагдлын дүнгээр:

Дт Валютын ханшийн зөрүүгийн бодит бус алдагдал
Кт Гадаад валютын данс/Дансны авлага

Үндсэн хөрөнгө борлуулсны алдагдал:

Дт Үндсэн хөрөнгө ашиглалтаас хассаны/борлуулсны алдагдал
Кт Үндсэн хөрөнгө

Г.3. ОРЛОГО, ЗАРЛАГЫН НЭГДСЭН ДАНСНЫ БҮРТГЭЛ

Тайлангийн хугацааны эцэст орлого, зарлагын дансдын үлдэгдлийг орлого, зарлагын нэгдсэн дансанд хааж, үр дүнг тооцон тайлант үеийн ашиг дансанд хаалтын бичилт хийнэ.

Орлогын дансдын хаалт:

Дт Орлогын дансад

Кт Орлого, зарлагын нэгдсэн данс

Зардлын дансдыг хааж:

Дт Орлого, зарлагын нэгдсэн данс

Кт Зардлын дансад

Орлого, зарлагын нэгдсэн дансны зөрүүгээр тайлангийн үеийн ашиг, алдагдлыг тодорхойлох бөгөөд:

Ашигтай бол:

Дт Орлого, зарлагын нэгдсэн данс

Кт Тайлант үеийн ашиг

Алдагдалтай бол:

Дт Тайлант үеийн алдагдал/ ашиг/

Кт Орлого, зарлагын нэгдсэн данс гэж бүртгэнэ.



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 374

Улаанбаатар хот

“Аргай бэст” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.4, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалт болон Хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 8.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Аргай бэст” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. “Аргай бэст” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авах, баримт хүлээлцэх ажлыг зохион байгуулж, арилжаа эрхлэх, төлбөр тооцоо хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын төлөөлөл бүхий комисс томилон ажиллуулахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/-т үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон компанийн хэлцлийн жагсаалтыг үндэслэн харилцагчийн үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаатай холбоотой баримтыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/, арилжаа болон санхүүгийн баримтыг “Монголын хөрөнгийн бирж” ХХК /Х.Алтай/-д өөрийн байгууллагын архивт хүлээн авахыг тус тус үүрэг болгосугай.

4. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсонтой холбогдуулан харилцагчийн арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн баримтыг “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 9.3-д заасны дагуу цэгцлэн архивын нэгж болгон арилжаа эрхлэх болон төлбөр тооцоо хадгаламжийн байгууллагын архивт хүлээлгэн өгөхийг “Аргай бэст” ХХК /Д.Ариунболд/-д үүрэг болгосугай.

5. Тус компанийн харилцагчдыг брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй бусад компанид шилжүүлэх асуудлыг холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэн, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийт, харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 375

Улаанбаатар хот

“Номин даатгал” ХХК-д дүрмийн сан
/хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээндээ
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Номин даатгал” ХХК-ийн дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээг тус компанийн 2011 оны хуримтлагдсан ашгаас нийт 500,000,000.0 /таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	А.Шагдарсүрэн	1,500,000,000.0	500,000,000.0	2,000,000,000.0	100.0%
	Нийт	1,500,000,000.0	500,000,000.0	2,000,000,000.0	100.0%

2. Дүрмийн сангийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2013 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Номин даатгал” ХХК /С.Ганчимэг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

002001



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 376

Улаанбаатар хот

┌ “Моннис даатгал” ХХК-д дүрмийн сан ┐
/хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээндээ
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:


1. “Моннис даатгал” ХХК-ийн дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээг хувь нийлүүлэгч “Моннис интернэшнл” ХХК-иас нийт 500,000,000.0 /таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	“Моннис интернэшнл” ХХК	1,500,000,000.0	500,000,000.0	2,000,000,000.0	100.0 %
	Нийт	1,500,000,000.0	500,000,000.0	2,000,000,000.0	100.0 %

2. Дүрмийн сангийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2013 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Моннис даатгал” ХХК /С.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

002000



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 377

Улаанбаатар хот

“Даатгалын салбарын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги” батлах тухай 117 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, зохицуулалтад хамаарах чиглэлээр “Даатгалын салбарын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. “Даатгалын салбарын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсан ажлуудыг Ажлын албаны жил бүрийн төлөвлөгөөнд тусгуулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн
377 дугаар тогтоолын хавсралт

УХА0410 5043239

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ДААТГАЛЫН ГАЗАР

“САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ”-Т ТУСГАГДСАН ЧИГЛЭЛЭЭР
ДААТГАЛЫН САЛБАРТ 2012-2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2012 он

ГАРЧИГ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
1.1. Хууль, эрх зүйн үндэслэл	
1.2. Практик үндэслэл	
1.3. Зорилго	
1.4. Ач холбогдол	
1.5. Даатгалын салбарын өнөөгийн байдал	
1.6. Даатгалын салбарын өнөөгийн байдалд хийсэн SWOT шинжилгээ, цаашдын хандлага	
2. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ЧИГЛЭЛ	8
2.1. Стратегийн эрхэм зорилго	
2.2. Даатгалын стратегийн зорилт	
2.2.1. Эрсдэлийн удирдлагад суурилсан хяналт тавих зураглал гаргах	
2.2.2. Санхүүгийн зохицуулах хорооны зарим эрх үүргийг шилжүүлэх боломжтой этгээдийг олж тогтоох	
3. СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	12
4. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ САНХҮҮЖИЛТ	13
5. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	13
6. ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ХҮРЭХ ҮР ДҮН	13
7. СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
1. Даатгалын салбарын зохицуулалт, хяналт шалгалтыг сайжруулахад чигэлсэн үйл ажиллагаа	14
2. Даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд чигэлсэн үйл ажиллагаа	17

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Хууль, эрх зүйн үндэслэл:

Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны 117 дугаар тогтоолын хавсралтаар “Санхүүгийн зохицуулах хорооны 2012-2016 оны үйл ажиллагааны стратеги”-ийг баталж, салбар тус бүрийн чиглэлээр 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, 2012 оны 3 дугаар улиралд багтаан тус Хорооны хуралдаанд танилцуулахыг Ажлын албанд даалгасан. Энэ дагуу Даатгалын газраас “Даатгалын салбарыг 2012-2016 онд хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулан Хорооны 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанд танилцуулж хэлэлцүүлсний үндсэн дээр бусад салбарыг 2012-2016 онд хөгжүүлэх төлөвлөгөөтэй нэгэн адил нэгдмэл загварын хэлбэрт тохируулан батлуулахаар болсон.

1.2. Практик үндэслэл:

Даатгалын салбарыг олон улсын жишиг стандартад нийцүүлэн хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, дотоодын даатгалын зах зээлийн хөгжлийн бодлого боловсруулах, даатгал хөгжсөн улс орнуудын загвар туршлагыг салбарт хэрэгжүүлэх, санхүү даатгалын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэд даатгуулагчдад учирж болзошгүй эрсдэлийг бууруулахад төрөөс авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах шаардлага урган гарч байна.

1.3. Зорилго:

Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор дунд хугацаанд даатгалын салбарт авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлох зорилготой.

1.4. Ач холбогдол:

Даатгалын салбарын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах нь дунд хугацаанд даатгалын зах зээлийн зохицуулалтыг сайжруулж, хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэсэн үйл ажиллагаагаа төлөвлөх, ажлын уялдаа холбоог хангах, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих боломжийг бүрдүүлэх


үндсэн дээр Санхүүгийн зохицуулах хорооны зорилгыг биелүүлэхэд чухал ач холбогдолтой болно.

1.5. Даатгалын салбарын өнөөгийн байдал

2011 онд даатгалын салбарт нийт 17 даатгалын компани, 177 даатгалын компаний салбар, 2029 даатгалын төлөөлөгч, 8 даатгалын зуучлагч, хохирол үнэлэгч 9, актуарч 13 тус тус үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд 2010 онтой харьцуулахад даатгалын компаний салбар 11-ээр нэмэгдэж, даатгалын төлөөлөгч 89-өөр хорогдсон байна. Даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

Даатгалын байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх онуудын мөн үетэй харьцуулахад 2010 онд 38 хувиар, 2011 онд 43,2 хувиар тус тус өсч, 2011 оны 4 дүгээр улиралд 81.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Даатгалын компаниудын хөрөнгийн хэмжээ




Даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2011 оны 4 дүгээр улиралд 48 тэрбум төгрөг болж 2010 оны мөн үеийнхээс 1,5 дахин нэмэгдсэн, даатгалын компаниудын 2011 оны цэвэр ашиг 10.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 3 дахин өссөн нь даатгалын байгууллагуудын санхүүгийн чадавхи бэхжиж, цаашид даатгалын салбарын санхүүгийн үзүүлэлтүүд сайжрах төлөвтэй байгааг харуулж байна.



Даатгалын салбарын хэмжээнд 2011 онд даатгалын компаниудын олсон нийт орлого ихээхэн өссөн дүнтэй гарсан нь нэг талаас даатгалын зах зээлийн хамралт нэмэгдэж тэлсэн, нөгөө талаас даатгалын үнэлгээ болон үнийн ерөнхий өсөлттэй холбоотой гэж үзэж болохоор байна.

Даатгалын нийт хураамжийн орлогын хэмжээг ДНБ-ний 2011 оны дүнтэй харьцуулахад өмнөх оны мөн үеийнхээс 0,06 пунктээр нэмэгдэж 0,44 хувь болсон байна.



2011 онд даатгалын нөхөн төлбөр 10.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 3.2 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Даатгалын нөхөн төлбөрийн дүн 2004 онд буурч байсан бол 2006 оноос хойш тогтмол өссөн үзүүлэлттэй байна.



Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 5 жилийн байдлаар зэрэгцүүлж үзэхэд тогтвортой өсч ирсэн. 2007 оны 4 дүгээр улирлын байдлаар даатгалын нөөц сангийн хэмжээ 17.6 тэрбум төгрөг байсан бол 2011 оны эцэст 36.1 тэрбум төгрөгт хүрч 5 жилийн өмнөх мөн үеийнхээс 18.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Даатгалын зуучлагч: Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий даатгалын зуучлагч 8 компани үйл ажиллагаа явуулж байна. 2011 онд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 314.0 сая төгрөг, үүнээс 89,1 хувь буюу 280.0 сая төгрөгийг даатгалын зуучлалын үйл ажиллагааны орлого эзэлж байна.

Даатгалын хохирол үнэлэгч: Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий 9 даатгалын хохирол үнэлэгч компани зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байна. 2011 онд даатгалын хохирол үнэлэгч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 154.4 сая төгрөг болсон байна. Үүнээс даатгалын хохирол үнэлэгчийн орлого нийт орлогын 17,5 хувь буюу 27.1 сая төгрөг болж, үлдсэн 82,5 хувийг бусад орлого эзэлж байна.

1.6. Даатгалын салбарын өнөөгийн байдалд хийсэн SWOT шинжилгээ, цаашдын хандлага

Даатгалын салбарын хөгжлийн динамик үзүүлэлтийг сүүлийн жилүүдийн байдлаар нэгтгэн авч үзэхэд даатгалын зах зээл эрчимтэй хөгжиж, тус салбарын нийт эдийн засагт эзлэх хувь хэмжээ, гүйцэтгэх үүрэг роль жилээс жилд өсөн нэмэгдэх хандлагатай болж байна.

Хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Даатгалын тухай хуулийн хүрээнд 2006 оноос хойш дангаараа болон холбогдох төрийн төв байгууллагуудтай хамтран баталсан нэр бүхий 43 журам, заавар хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнээс 13 нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын журам, зааврууд байна.

2012 оноос Жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдон даатгалын нөөц сангаас олгодог нөхөн төлбөрт автотээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч даатгалтай эсэхээс үл хамааран авто замын осолд өртсөн гуравдагч этгээд буюу эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон иргэд, байгууллагуудыг бүрэн хамруулах боломжтой боллоо. Орон нутаг дахь даатгалын байгууллагуудын салбарын үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх, салбаруудын биеэ даасан үйл ажиллагаа, орон нутгийн хөгжлийг хангахад орон нутгийн онцлогтой уялдсан даатгалын мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагааг хөхиүлэн дэмжих төрөөс баримтлах бодлогын тодорхойлоход Хороо эн тэргүүнд анхаарах нь зүйтэй байна.

Хорооны хяналт, зохицуулалтад хамаарах даатгалын салбар, цаашилбал нийт улс орны хэмжээнд арилжааны даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд төрийн санхүү мөнгөний бодлого болон үндсэн чиглэлд даатгалын тодорхой асуудлуудыг тусган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчдоор дамжуулан даатгалын хохирлын нөхөн төлбөрийг олгох, хохирол барагдуулах хугацааг богиносгох, даатгалын салбар дахь даатгалын баталгаат сангийн орчныг сайжруулах зэрэг асуудлаар төрийн бусад эрх бүхий байгууллагуудтай бодлогын түвшинд нягт хамтран ажиллах шаардлагатай байна.

Даатгалын салбарт хийсэн SWOT шинжилгээ

Давуу тал /Strengths/	Сул тал /Weaknesses/
<ul style="list-style-type: none"> - Даатгалын эрх зүйн орчин харьцангуй сайн бүрдсэн - Албан журмын даатгалын хууль батлагдсантай холбоотой эрэлтийн өсөлт 	<ul style="list-style-type: none"> - Боловсон хүчний чадавхи сул - Компанийн засаглал хангалтгүй - Зохицуулалтын журам, заавар хангалттай боловсронгуй болоогүй
Боломж /Opportunities/	Болзошгүй эрсдэлүүд /Threats/

- Банкны зуучлалын зохицуулалтыг сайжруулах, өргөжүүлэх
 - Үндэсний давхар даатгалын тогтолцоог бүрдүүлэх
 - Эрсдэл дээр суурилсан хяналтыг нэвтрүүлэх
 - Урт хугацааны даатгалын талаарх хэрэглэгчдийн ойлголтыг сайжруулах замаар даатгалын хамралтыг нэмэгдүүлэх

- Даатгалын байгууллагын төлбөрийн чадварын эрсдэл
 - Зах зээл дэх өрсөлдөх чадварын эрсдэл
 - Давхар даатгалын эрсдэл/хөрөнгө их хэмжээгээр гадагшлах, давхар даатгагч хариуцлага хүлээх чадваргүй байх эрсдэл/

ХОЁР. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ЧИГЛЭЛ

2.1. Стратегийн эрхэм зорилго

Санхүүгийн зохицуулах хороо “Эрхэм зорилго”-оо “Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүн туршлага, стандартад нийцсэн тогтвортой үйл ажиллагаа бүхий санхүүгийн салбарыг хөгжүүлэх” гэж томъёолсон бөгөөд харин “Стратегийн зорилго”-ыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

1. Монгол Улсын санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, тогтвортой хөгжүүлэх;
2. Санхүүгийн салбарт итгэх олон нийтийн итгэлийг бий болгох;
3. Харилцагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах (туслах), хадгаламж эзэмшигчдийн эрхийг хамгаалах (үндсэн);
4. Олон нийтийг сургах, санхүүгийн зах зээлийн тухай олон нийтийн ойлголтыг сайжруулах.

Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаанд баримтлах дараах 4 зарчмыг тодорхойлсон. Үүнд:

- Хараат бус байх;
- Итгэл хүлээсэн байх;
- Хүндэтгэл хүлээсэн байх;
- Ил тод байх.

Хорооны 2012-2016 оны стратеги төлөвлөгөөнд “Байгууллагын стратеги”-ийг Зохицуулах үйл ажиллагааны стратеги (1); Туслах үйл ажиллагааны стратеги (2) гэж ангилан авч үзсэн бөгөөд даатгалын салбар нь Зохицуулах үйл ажиллагааны стратегид хамаарахаар томъёологдсон.

2.2. Даатгалын стратегийн зорилт

Санхүүгийн зохицуулах хорооны 2012-2016 оны үйл ажиллагааны стратегийн баримт бичигт даатгалын салбарт дараах зорилтот ажлыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон.

Үүнд:

1. Эрсдэлийн удирдлагад суурилсан хяналт тавих зураглал гаргах;
2. Санхүүгийн зохицуулах хорооны зарим эрх үүргийг шилжүүлэх боломжтой этгээдийг олж тогтоох.

2.2.1. Эрсдэлийн удирдлагад суурилсан хяналт тавих зураглал гаргах

2005 онд Даатгалын хяналтын байгууллагын олон улсын холбоо (ДХОУБ)-ноос гаргасан журмын дагуу энэхүү үзэл баримтлалд өөрчлөлт хийж шинэ зарчмуудыг санал болгосон. Эдгээрийг дурдвал:

- Тааламжгүй буюу хүнд нөхцөл байдал тулгарсан үед даатгалын байгууллагын өөрийн бизнесийн багц, актив, зах зээлд эзэлж буй байр суурьт нь нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл болон богино, урт хугацаанд санхүүгийн байдалд нь нөлөөлөх хүчин зүйлсийг үнэлж дүгнэх динамик аргыг хяналт шалгалтанд ашиглах;
- Бизнесийн бүхий л төрлийн эрсдэлийг тухайн бизнесийн аль нэгэн төрөл хэлбэрийн түвшинд болон бизнесийн байгууллагынх нь (тухайлбал компаний эрсдэлийн удирдлага г.м.) түвшинд цогцоор нь авч үзэх;
- Статистик үзүүлэлтийн үнэн зөв байдал, тодорхой бус эрсдэлийн зардал, хувилбаруудыг шалгаж үзэх зэрэг эрсдэлийг тусгайлан болон ил тод хэмжих аргыг хэрэглэх;
- Үнэлгээ хийхдээ тухайн нэг компани болон зах зээлийг бүхэлд нь хамруулсан зах зээлийн жишиг үзүүлэлтийг ашиглах;
- Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, эрсдэлийн маржин зэргийг хамарсан хамгийн оновчтой тооцооллын аргууд болох нөхцөлт аргыг хэрэгжүүлэх.

Төлбөрийн чадвар I нь Европын холбоонд мөрдөгдөж буй төлбөрийн чадварын өнөөгийн горимыг шинэчилж засварлан хэрэглэх бол Төлбөрийн чадвар II нь илүү өргөн хүрээтэй ойлголт бөгөөд заавал байх өөрийн хөрөнгийн хамгийн доод хэмжээ болон эрсдэлийг удирдах шинэ аргыг авч үзэх юм.

Төлбөрийн чадварын заавал байх өөрийн хөрөнгийн хамгийн доод хэмжээ дараах зорилгыг агуулна. Үүнд:

- Даатгагч өөрийн үйлчлүүлэгчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйд хүргэх эрсдлийг бууруулах;
- Тухайн даатгалын компани үйлчлүүлэгчдийнхээ өмнө хүлээсэн үүргийг бүрэн хэмжээгээр биелүүлэх чадамжгүй болсноос үүдэн даатгуулагчдад учрах хохирлыг багасгах;
- Хяналтын байгууллага нь зохицуулалтын хүрээний байгууллагад эрт анхааруулга өгөх эрхтэй байх, ингэснээр өөрийн хөрөнгийн хэмжээ заавал байх хэмжээнээс буурсан тохиолдолд албадлагын арга хэмжээ авах;
- Даатгалын салбарын санхүүгийн тогтвортой байдлын талаарх олон нийтийн итгэлийг бий болгох.

Ихэнх тохиолдолд даатгалын байгууллагын БАЗЕЛ хэмээн нэрлэгддэг Төлбөрийн чадвар II нь банкны салбарт ашигладаг БАЗЕЛ II (Одоогийн БАЗЕЛ III)-той төстэй. Тухайлбал, санал болгож буй Төлбөрийн чадвар II нь 3 үндсэн тулгуур баганаас бүрдэнэ. Үүнд:

- Нэг дэх тулгуур багана тоон үзүүлэлтээс бүрдэнэ. Жишээ нь даатгалын компани дор хаяж хэдий хэмжээний өөрийн хөрөнгөтэй байх шаардлагатай болох гэх мэт;
- Хоёр дахь тулгуур багана даатгалын компанийн засаглал, эрсдэлийн удирдлагын болон даатгалын байгууллагын үр нөлөө бүхий хяналтын системтэй холбоотой мөрдвөл зохих шаардлага;
- Гурав дахь тулгуур багана шаардлагатай тодруулга болон ил тод байдлын асуудлыг хамаарна.

Төлбөрийн чадвар I-д тавигдах шаардлагыг хангахад чиглэгдсэн горимыг мөрдлөг болгож чадсан гэж үзсэн тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороо Төлбөрийн чадвар II-т шилжих хэрэгцээ шаардлагын зураглал гаргах хэрэгтэй болно.

ДХБОУХ-ноос гаргасан удирдамж, зааварчилгаа нь даатгалын байгууллагын төлбөрийн чадварын журам зааврыг боловсруулахад баримтлах гол гол зарчмыг тусгасан. Санал болгосон төлбөрийн чадварын горимоос дурдвал:

- Даатгалын байгууллага богино болон урт хугацаанд бусдын өмнө хүлээсэн үүргээ найдвартай биелүүлэх асуудалд анхаарал хандуулсан;
- Эрсдэлд мэдрэмжтэй байх, тухайн нэг байгууллага болон системийг бүхэлд нь хамарсан ямар эрсдэл учирч болзошгүй талаар тодорхой тусгах, үүн дээрээ үндэслэн мөрдвөл зохих горим журамд заасны дагуу санхүүгийн зохистой харьцааны шаардлагыг тавьж байх асуудлыг хөндсөн;
- Эрсдэлийн төрөл тус бүрт тухайн байгууллагын болон системийн түвшинд авч үзсэн оновчтой зохицуулалтын зохистой харьцааны үзүүлэлт шаардлагыг мөрдүүлэх талаар тодорхой тусгасан;
- Санхүүгийн зах зээлийн мэдээлэл болон даатгалын мэргэжлийн шинж чанартай эрсдэлийн талаарх гар дор бэлэн байгаа үзүүлэлттэй уялдаа бүхий үнэлгээний аргачлал боловсруулж мөрдөх шаардлагатайг харгалзан үзсэн;
- Мэргэжлийн буюу техникийн шинж чанартай заалтуудын тодорхойлолтыг агуулсан (мэргэжлийн шинж чанартай заалтууд нь зохистой, найдвартай, бодитой байх шаардлагатай бөгөөд эдгээрийг бусад орны даатгалын байгууллага, системийн үзүүлэлттэй харьцуулалт хийхэд ашиглах, мөн эрсдэлийн маржинг тодорхойлсон байна);
- Даатгалын багц ямар байгаагаас үүдэн хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардагдах зардлыг тооцох хамгийн бодит үнэлгээны аргыг хэрэглэхийг санал болгох, уг арга нь санхүүгийн зах зээлийн эрсдэлгүй хүүгийн түвшин, мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн талаар харгалзан үзсэн байх ёстой талаар дурдсан;
- Төлбөрийн чадварын хяналтын түвшингийн хүрээг тогтоож, хяналтын шат бүрт тохирсон хяналтын арга хэрэгслийг бий болгохыг зөвлөсөн;
- Стандартчлагдсан, илүү боловсронгуй цогц аргыг төлбөрийн чадварыг үнэлэхэд ашиглах, үүний дотор хэрвээ зүйтэй гэж үзвэл, өөрийн дотоод үйл ажиллагаанд хэрэглэх загвар бий болгохыг зөвшөөрсөн.

2.2.2. Хорооны зарим эрх үүргийг шилжүүлэх боломжтой этгээдийг олж тогтоох

Зах зээлийн тухайн сегментийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх мэдлийн цар хүрээг тодорхойлохын сацуу Санхүүгийн зохицуулах хороо тодорхой нөхцөлтэйгөөр даатгалын зах зээлийн ямар хяналтын чиг үүргийг чухам хэнд шилжүүлэх нь зүйтэй талаар шийдвэр гаргана.

Зах зээлд хяналт тавих гадны тоглогчдод боловсрол мэргэжил, мэргэшлийн түвшин, бие даасан байдал, асуудалд бодитойгоор хандах чадвар, үнэнч шударга ажиллах боломж чадавхи зэрэг тодорхой стандарт шаардлага тавигдана. Хэдийгээр Санхүүгийн зохицуулах хороо болон гадны тоглогчид санхүүгийн тайланг баталгаажуулах зэрэг төстэй үйл ажиллагаа явуулах боловч тэд тодорхой ашиг сонирхлын үүднээс тухайн үйл ажиллагааг явуулна. Хороо нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, харилцагч, үйлчлүүлэгч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг бол харин гадны тоглогчид хөндлөнгийн аудитор шиг тухайн компанийн хувь нийлүүлэгчдийн хувийн сонирхолд үйлчилдэг.

Санхүүгийн зохицуулах хороо нь гадны тоглогчид хангалттай хэмжээний чадавхитай, бие даасан байдлаа алдахгүй байх зэрэг нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээ авах шаардлагатай. Хороо болон гадны тоглогчийн чадавхи ямар түвшинд байгаагаас хамааруулан Хороо өөрийн хяналтын эрх мэдлээ шилжүүлэх үйл явцыг алгуур хийх нь зүйтэй юм.

ГУРАВ. СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Стратегийн зорилт 1: Эрсдэлийн удирдлагад суурилсан хяналт тавих зураглал гаргах

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 1.1. Эрсдэлийн удирдлагад суурилсан хяналтын судалгаа хийх;
- 1.2. Эрсдэлийн удирдлагад суурилсан хяналтын орчинг бүрдүүлэхтэй холбогдсон журам, зааврыг боловсронгуй болгох;
- 1.3. Эрсдэлийн удирдлагад суурилсан хяналтын чиглэлээр зөвлөх ажиллуулах;
- 1.4. Эрсдэлийн удирдлагад суурилсан хяналтын сургалт явуулах.

Стратегийн зорилт 2: Санхүүгийн зохицуулах хорооны зарим эрх үүргийг шилжүүлэх боломжтой этгээдийг олж тогтоох

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 2.1. Хорооны зарим эрх үүргийг шилжүүлэх боломжийг судлах;
- 2.2. Шилжүүлэх боломжтой этгээдийн чадавхийг судлах.

ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ САНХҮҮЖИЛТ

Төлөвлөгөөний санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;
2. Олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
3. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт;
4. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр.

ТАВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

1. Санхүүгийн салбар дахь даатгалын салбарын оролцооны өөрчлөлт, хувь;
2. Даатгалын салбар дахь нийт активын хэмжээний өөрчлөлт;
3. Даатгалын зах зээлд оролцогч аж ахуй нэгж, иргэдийн тооны өсөлт;
4. Даатгалын үйлчилгээ авч буй иргэдийн тооны өсөлт.

**ЗУРГАА. ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮНДЭСЛЭЛ, ХҮРЭХ ҮР ДҮН**

1	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Эрсдэлийн удирдлагад суурилсан хяналтын судалгаа хийх • Эрсдэлийн удирдлагад суурилсан хяналтын орчинг бүрдүүлэхтэй холбогдох журам зааврыг боловсронгуй болгох • Эрсдэлийн удирдлагад суурилсан хяналтын чиглэлээр зөвлөх ажиллуулах • Эрсдэлийн удирдлагад суурилсан хяналтын сургалт явуулах • Хорооны зарим эрх үүргийг шилжүүлэх боломжийг судлах • Шилжүүлэх боломжтой этгээдийн чадавхийг судлах
2	Үндэслэл	Хяналт шалгалтыг төлөвлөгөөний дагуу хийж байгаа нь даатгалын байгууллагын эрсдэлийн түвшинтэй уялдаа холбоогүй байдаг. Цаашид даатгалын зах зээлд үүсч

		болох аливаа эрсдэлд бэлэн байх, зах зээлийг тогтвортой байлгах, даатгалын байгууллагын төлбөрийн чадварын шаардлагыг шинэ өнцөгөөс харах зайлшгүй шаардлагатай байна
3	Хамрах хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээний үр дүнг хүртэгч	Монгол Улсын даатгалын байгууллагууд болон даатгуулагч, хэрэглэгчдийн эрх ашиг хангагдана
4	Хүрэх үр дүн	Эрсдэл дээр суурилсан хяналтын судалгаа бүрэн хийгдсэн байна. Холбогдох журмуудад нэмэлт өөрчлөлт орсон байна. Даатгалын зах зээлд оролцогчдын мэдлэг чадвар дээшилсэн байна
5	Үр нөлөө	Даатгалын байгууллагуудын үйл ажиллагаа өргөжих боломж бүрдэнэ. Даатгалын нийгэм дэх үр нөлөө нэмэгдэнэ
6	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны явц болон хүрэх үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт	Даатгалын хамралт нэмэгдсэн байна. Даатгуулагчдын даатгалын зах зээлд итгэх итгэл нэмэгдсэн байна
7	Хэрэгжүүлэх Засгийн газрын байгууллага	Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газар

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Даатгалын газрын зүгээс даатгалын салбарын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр нь дээр дурдсан Хорооны стратегийн зорилго болон уг баримт бичигт даатгалын салбарын хувьд тодорхойлсон зорилтуудад хэрхэн нийцэж байгаа, дотоод бүтцийн хувьд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд Хорооны газар, нэгжүүдийн оролцоо, хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүнг тооцох хугацааг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Холбоос	Хэрэгжүүлэх хугацаа				
		2012	2013	2014	2015	2016
1. Даатгалын салбарын зохицуулалт, хяналт шалгалтыг сайжруулахад чигэлсэн үйл ажиллагаа						
1.1. Зохицуулалтын хүрээний бус хувь хүн, хуулийн этгээдэд даатгалын чиглэлээр хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх, даатгалын ангиллыг өөрчлөх чиглэлээр Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судлах, санал боловсруулж	ТГ, ЭЗХ		Х			

холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх						
1.2.Амьдралын даатгалыг нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалтай уялдуулах, тэтгэврийн даатгалын чиглэлээр судалгаа шинжилгээ хийх	ЭЗХ		X	X		
1.3.Үндэсний давхар даатгалын компани байгуулах талаар судалгаа хийж, үндэслэл боловсруулах	ТГ			X	X	X
1.4.Даатгалын компанийн төлбөрийн чадварын өнөөгийн орчныг судлах	ТГ	X				
1.5.Төлбөрийн чадвар 1-ийн судалгаа хийх, танилцуулга гаргаж хэлэлцэх	ТГ	X				
1.6.Төлбөрийн чадвар 1-д нийцүүлэх чиглэлээр журам зааварт шаардлагатай өөрчлөлтийг оруулах	ТГ, ЭЗХ	X				
1.7.Төлбөрийн чадвар 2-ын судалгаа хийж хэлэлцэх		X				
1.8.Эрсдэлийн удирдлагад суурилсан хяналтын орчинд шилжихтэй холбогдох бэлтгэлийг хийх	ТГ, ЭЗХ		X			
<u>А. Судалгаа хийх, журам зааврыг сайжруулах чиглэлээр</u>						
1.8.1.Даатгалын, зах зээлийн, үйл ажиллагааны зэрэг эрсдэл тус бүрээр судалгаа хийж эрсдэлийг хянах зөвлөмжийн төсөл боловсруулах, олон улсын шинжээчийн зөвлөгөө авах	ТГ		X	X		
1.8.2.Хорооны ажилтнуудыг дээрх чиглэлээр сургах	ТГ		X	X	X	X
1.8.3.Даатгалын компаниудыг бэлтгэж эхлэх, сургалт явуулах, зөвлөмж, мэдээлэл хүргүүлэх	ТГ		X	X	X	X
1.8.4.Даатгалын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг судалсны үндсэн дээр холбогдох зааврыг батлуулах	ТГ	X	X	X	X	X
1.8.5.Даатгалын хөрөнгийн үнэлгээний стандартыг судлах	ТГ	X	X	X		
1.8.6.Өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зохицуулалт, хяналтын талаар судалгаа хийх	ТГ	X	X	X		
1.8.7.Амьдралын даатгалын нөөц сангийн	ТГ	X	X	X		

хүрэлцээ, зохицуулалт, хяналтын судалгаа хийх						
1.8.8. Даатгалын компанийн засаглал, дотоод хяналтын судалгаа хийх	ТГ	X	X	X		
1.8.9. VaR буюу хүлээж болзошгүй эрсдэлийн аргын судалгаа хийх	ТГ		X	X	X	
1.8.10. Даатгалын багц дүрмийг сайжруулах чиглэлээр судалгаа хийх, тухайлбал даатгалын хэлбэрийн жагсаалт, бүтээгдэхүүн, даатгалын нэмэлт санхүүгийн тайлангийн журмыг боловсронгуй болгох	ТГ	X	X	X	X	
1.8.11. Даатгалын төлөөлөгч, зуучлагч, мэргэжлийн оролцогчдын зохицуулалт, хяналтын судалгаа хийх, журам зааврыг боловсронгуй болгох	ТГ	X	X	X	X	
1.8.12. Давхар даатгалын зохицуулалт, хяналтыг боловсронгуй болгох	ТГ	X	X	X	X	
1.8.13. Гадаадын даатгагчид шууд даатгуулах үйл ажиллагааг журамлах, гадаадын хөрөнгө оруулалттай болон Монгол Улсын томоохон аж ахуйн нэгжүүдийг дотоодын даатгалд хамруулах, нөгөө талаас Монгол Улсын нутаг дэвсгэрт даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй гадаадын даатгалын компаниудын үйл ажиллагааг зогсоох хяналтыг сайжруулах	ТГ	X	X	X		
1.8.14. Арилжааны банкуудын даатгалын зуучлалын үйл ажиллагааны зохицуулалт, хяналтыг сайжруулах, тавигдах стандарт шаардлагыг судалж хэрэгжүүлэх	ТГ	X	X	X		
1.8.15. Даатгалын сангуудын чөлөөт хөрөнгийн үлдэгдлээс хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлэх	ТГ	X	X			
1.8.16. Даатгалын салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний зохицуулалтыг сайжруулах	ТГ	X	X	X		

1.8.17.Даатгалын олон улсын IFRS-4 зэрэг стандартуудыг судалж нэвтрүүлэх	ТГ	Х	Х	Х	Х	Х
<i>Б. Хяналт шалгалтыг сайжруулах чиглэлээр</i>						
1.8.18.Интернет даатгалын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтыг сайжруулах	ТГ		Х	Х		
1.8.19.Даатгалын зах зээлийн хөгжих гол нөхцөл болох даатгалын бүтээгдэхүүний хяналтыг сайжруулах	ТГ	Х	Х	Х	Х	Х
1.8.20.Албан журмын даатгалын хяналт, зохицуулалтыг боловсронгуй болгох	ТГ	Х	Х	Х	Х	Х
<i>В. Бусад чиглэлээр</i>						
1.8.21.Даатгалын мэргэжлийн боловсон хүчний чадавхийг сайжруулах чиглэлээр семинар, сургалтууд дотоодод зохион байгуулах, гадаадын сургалт семинарт оролцох	ТГ, ЭЗХ	Х	Х	Х	Х	Х
2. Даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд чигэлсэн үйл ажиллагаа						
2.1.Даатгалын компаниудын санд хуримтлагдсан даатгалын хураамжийн орлогоос хөрөнгө оруулалт хийх, хувьцаа худалдан авах зэрэг хөрөнгийн зах зээлд оролцох боломжийг судалж, хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх	ҮЦГ, ЭЗХ	Х	Х			
2.2.Даатгалын салбарын мэргэшсэн боловсон хүчний чадавхийг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлд нэвтрэх боломж, стратегийг тодорхойлох чадвартай болгох	ҮЦГ			Х	Х	Х
2.4.Албан журмын даатгалын тогтолцоог даатгалын зах зээлд нэвтрүүлэх чиглэлээр судалгаа хийж, төсөл боловсруулах	ЭЗХ	Х	Х			
2.5.Монголын компанийн засаглалын зарчмыг даатгалын компаниудад нэвтрүүлэх төлөвлөгөө боловсруулах	КЗХХА	Х				
2.6.Компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх	КЗХХА		Х			
2.7.УИХ, Засгийн газрын төсөл, хөтөлбөр, үндсэн чиглэлд даатгалын зах зээлийг	ТГ	Х	Х	Х	Х	Х

хөгжүүлэх чиглэлээр санал боловсруулж, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх						
2.8.Төсөл, хөтөлбөр, үндсэн чиглэлийн хэрэгжилтийг даатгалын салбарт хангуулах	ТГ	X	X	X	X	X
2.9.Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбогдсон журам, зааврын төслийг батлуулж мөрдүүлэх	ЭЗХ	X				
2.10.Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	ХАХ, ТГ	X	X	X	X	X
2.11.Даатгалын багч дүрэмд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах	ЭЗХ	X	X	X	X	X
2.12.Хорооны зохицуулалтын зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулах	ЭЗХ	X	X			
2.13.Хорооны зохицуулалтын зарим чиг үүргийг мэргэжлийн холбоонд шилжүүлэх	ТГ, ЭЗХ		X	X	X	X
2.14.Даатгалын салбарын санхүүгийн тайлангийн нэгтгэл гаргаж, дүн шинжилгээ хийх	МТХ	X	X	X	X	X
2.15.Даатгалын салбарын төлөв байдал, түүнийг сайжруулах арга замын талаар судалгаа хийх		X	X	X	X	X
2.16.Даатгалын компаниудын дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн нэмэгдүүлэх	ТГ, ЭЗХ	X	X			
2.17.Даатгалын газар дээрх болон зайны хяналт, шалгалтыг сайжруулах	ЭҮСШБГ	X	X	X	X	X
2.18.Орон сууцны зээлийн даатгалд тавих хяналтыг сайжруулах, зохицуулалтыг боловсронгуй болгох	ЭЗХ	X	X	X	X	X
2.19.Даатгалын актуарчийн тайланг боловсронгуй болгох талаар арга хэмжээ авах, зохицуулалтыг сайжруулах		X	X			
2.20.Даатгалын үйл ажиллагаа эрхлэх болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, сунгах, хүчингүй болгох	ТГ	X	X	X	X	X
2.22.Даатгалын актуарчийн эрх олгох, хүчингүй болгох	ТГ	X	X			
2.23.Даатгалын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийн бүртгэл хөтлөлтийг сайжруулах	ТГ	X	X	X	X	X
2.24.Даатгалын зах зээлийн статистик	МТХ	X	X	X	X	X

мэдээллийн нэгдсэн баазад баяжуулалт хийх						
2.25.Даатгалын байгууллагуудын хувийн хэргийг хөтөлж баяжуулалт хийх		X	X	X	X	X
2.26.Даатгагч, даатгуулагчдын хооронд гарсан маргааныг хууль тогтоомжийн дагуу хянаж шийдвэрлүүлэх	ЭЗХ	X	X	X	X	X
2.27.Иргэдийн санал гомдол, түүнийг шийдвэрлэсэн байдлын талаар судалгаа хийх	ТГ	X	X	X	X	X
2.28.Даатгалын зах зээлийн чиглэлээр олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах	Хорооны газар, хэлтсүүд	X	X	X	X	
2.29.Даатгалын мэдээллийн чиглэлээр салбарын цахим хуудсанд баяжуулалт тогтмол хийх	МТХ	X	X	X	X	X
2.30.Даатгалын салбарын эрх зүйн эмхтгэл, гарын авлага бэлтгэн хэвлүүлж, мэргэжлийн байгууллагууд болон олон нийтэд тараах	ТГ	X	X	X	X	X

-----ooOoo-----



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 378

Улаанбаатар хот

“Жолоочийн даатгалын сангийн шуурхай албаны
ажиллах журам”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Жолоочийн даатгалын тухай хуулийн 25.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:


1. “Жолоочийн даатгалын сангийн шуурхай албаны ажиллах журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү журмыг Жолоочийн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлийг дагаж мөрдсөн өдөр буюу 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Тогтоол батлагдсантай холбогдуулан “Жолоочийн даатгалын сангийн шуурхай албаны ажиллах журам” батлах тухай Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 395 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн
378 дугаар тогтоолын хавсралт



**ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ШУУРХАЙ
АЛБАНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Даатгалын тухай хуулийн 12¹.3.2-г заасан шуурхай алба /цаашид “шуурхай алба” гэх/-ны бүтэц, бүрэлдэхүүн, чиг үүрэг, шуурхай ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Шуурхай алба нь даатгагч, даатгуулагч, жолооч, хохирогч, байгууллага, иргэдээс жолоочийн даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг хүлээн авах, бүртгэх, дуудлагын ажилтанг томилох, даатгалын тохиолдлын газар дээрх үзлэг хийж тэмдэглэл үйлдэх, даатгалын тохиолдол болсныг баримтжуулах, даатгалын тохиолдлын улмаас хохирогчид нөхөн төлбөрийг үнэн зөв, шуурхай олгох боломжийг бүрдүүлж ажиллана.

Хоёр. Шуурхай албаны бүтэц, бүрэлдэхүүн

2.1. Шуурхай алба нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг хамруулж үйл ажиллагаагаа явуулна.

2.2. Шуурхай алба нь Албан журмын даатгагчдын холбооны Ажлын албаны бүтцэд байна.

2.3. Шуурхай алба нь дарга, дуудлагын ажилтан, оператор, орон нутгийн нэгж гэсэн бүрэлдэхүүнтэй байх бөгөөд түүний орон тоог Албан журмын даатгагчдын холбооноос тогтооно.

2.4. Шуурхай албаны дарга нь албаны байнгын, тасралтгүй, шуурхай үйл ажиллагааг удирдлагаар хангаж, жолоочийн даатгалын сантай холбож ажиллана.

2.5. Шуурхай алба нь дуудлага хүлээн авах байнгын ажиллагаатай тусгай дугаартай, даатгалын тохиолдлыг тодорхойлж, баримтжуулахад шаардлага хангасан техник, хэрэгсэлтэй байна.

2.6. Шуурхай алба нь операторын утасны нэгдсэн сүлжээтэй байх бөгөөд оператор нь даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг 24 цагийн туршид хүлээн авна.

2.7. Дуудлагын ажилтан нь нэр, хувийн дугаар, таних тэмдэг бүхий дүрэмт хувцастай, даатгалын тохиолдлын газар дээрх үзлэгийн тэмдэглэл баталгаажуулах тэмдэгтэй, даатгалын газарт очих зорилгоор тоногдсон тээврийн хэрэгсэл, техник хэрэгсэлтэй байна.

2.8. Албан журмын даатгагчдын холбоо нь шуурхай албаны ажилтнуудад тавигдах шалгуур, шаардлагыг тогтоож ажилд авна.

2.9. Албан журмын даатгагчдын холбоо нь шуурхай албаны ажилтнуудыг сургалтад хамруулж, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулна.

Гурав. Даатгалын тохиолдлын тухай мэдээлэл авах, бүртгэх

3.1. Даатгалын тохиолдлын дуудлагыг Шуурхай албаны оператор хүлээн авах бөгөөд орон нутгаас хандсан тохиолдолд тухайн орон нутгийн нэгжид дуудлагыг холбоно.

3.2. Оператор даатгалын тохиолдлын талаарх дуудлагыг энэ журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан маягтын дагуу бүртгэж авч, дараах зөвлөгөөг өгч ажиллана. Үүнд:

3.2.1. Аль нэг жолооч нь гэм буруутай нь тогтоогдоогүй бол замын цагдаад заавал мэдэгдэх;

3.2.2. Ослын газарт дуудлагын ажилтан очих боломжгүй, бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулаагүй, харин эд хөрөнгөд хохирол учирсан тохиолдолд жолооч харилцан тохиролцсон бол бүрдүүлэх материалыг тодорхой хэлж өгөх;

3.2.3. Ослын газарт замын цагдаа болон шуурхай алба очих боломжгүй тохиолдолд, даатгалын тохиолдол болсныг нотлох баримт бичиг бүрдүүлэх талаар зөвлөгөө өгөх (фото зураг, гэрчийн мэдүүлэг гэх мэт);

3.2.4. Даатгалгүй болон даатгалын хугацаа нь дууссан этгээд даатгалын тохиолдол гаргасан тохиолдол нөхөн төлбөрийг буцаан нэрэмжилэх талаар сануулах;

3.2.5. Замын цагдаа болон шуурхай алба нь даатгалын тохиолдлын газар дээрх үзлэг хийх шаардлагатай тохиолдолд автотээврийн хэрэгслийг хөдөлгөхгүй байх, ослын газрыг орхин явахгүй байхыг анхааруулах;

3.2.6. Бусад даатгалын тохиолдлыг нотлох баримт бүрдүүлэх, нөхөн төлбөрийн материал бүрдүүлэх талаар зөвлөгөө өгөх.

3.3. Оператор даатгалын тохиолдлын мэдээллийг хүлээн авсан даруйд даатгалын тохиолдол болсон газарт дуудлагын ажилтанг хуваарилж, шуурхай илгээнэ.

3.4. Оператор нь даатгагчдын шуурхай албаны утасны бүртгэлтэй байх ба жолооч даатгуулсан байвал холбогдох даатгагчийн шуурхай албатай холбож, энэ тухай даатгалын компанид мэдэгдэж, энэ талаар маягтад тэмдэглэнэ.

Дөрөв. Даатгалын тохиолдлын газар дээрх үзлэг

4.1. Дуудлагын ажилтан нь даатгалын тохиолдлын газарт түргэн хугацаанд очиж дараах үүргийг хэрэгжүүлнэ.

4.1.1. Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох даатгалын тохиолдол мөн эсэхийг тодорхойлох;

4.1.2. Ослын бодит байдлыг тодруулж, видео болон фото зургаар нөхцөл байдлыг олон талаас нь бодитоор харагдахуйц, зам тээврийн осолд өртөгсөдийн автотээврийн хэрэгслийн улсын дугаарыг оруулан баталгаажуулах;

4.1.3. Гэм буруутай этгээд нь тогтоогдоогүй тохиолдолд заавал замын цагдааг дуудах;

4.1.4. Энэхүү журмын 2 дугаар хавсралтын дагуу даатгалын тохиолдлын үеийн үзлэгийн тэмдэглэл үйлдэж, гарын үсгээр баталгаажуулсан байх;

4.1.5. Даатгалын тохиолдлын газраас бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд тодорхой бус тохиолдолд замын цагдаа дуудах, даатгалын тохиолдол болсныг гэрчлэх гэрчийн этгээдүүдийн мэдүүлэг авах;

4.1.6. Нөхөн төлбөрийн материалын бүрдүүлэлтийн талаар зөвлөмж өгөх

4.1.7. Бусад даатгалын тохиолдол болсныг нотлох баримт болон нөхөн төлбөр олгоход шаардагдах бусад нотлох баримтыг баримтжуулан цуглуулах.

4.2. Дуудлагын ажилтан нь даатгалын тохиолдлын газарт хийсэн үзлэгийн тэмдэглэл болон бусад нотлох баримтыг нийслэлд тухай бүр, орон нутгаас ажлын 3 хоногийн дотор Шуурхай албанд өгсөн байна.

Тав. Нөхөн төлбөр олгох баримтыг шилжүүлэх

5.1. Шуурхай албаны дарга нь дуудлага хүлээн авах маягтыг оператороос, даатгалын тохиолдлын газарт хийсэн үзлэгийн тэмдэглэлийг дуудлагын ажилтанаас авч, дуудлагын бүртгэлийн программтай тулгаж, баталгаажуулсан байна.

5.2. Шуурхай алба нь жолоочийн даатгалын сангаас олгох нөхөн төлбөрийн баримтыг Даатгалын сангийн хэлтэст тухай бүр жагсаалтаар хүлээлгэн өгнө.

5.3. Шуурхай албаны орон нутгийн нэгж нь жолоочийн даатгалын сангаас олгох нөхөн төлбөрийн баримтыг Шуурхай албанд ажлын 3 хоногийн дотор жагсаалтаар хүргүүлсэн байна.

5.4. Шуурхай алба нь Даатгагчаас олгох нөхөн төлбөрийн баримтыг ажлын 1 хоногийн дотор жагсаалтаар даатгагчид хүргүүлнэ.

Зургаа. Шуурхай албаны тайлан мэдээ, бүртгэл

6.1. Шуурхай албаны үйл ажиллагаатай холбоотой даатгалын тохиолдол, даатгалын тохиолдолын дуудлагын талаарх мэдээллийг Мэдээллийн сангийн хэлтэст өгч сангийн бүртгэл хөтөлнө.

6.2. Шуурхай алба нь даатгалын тохиолдлын талаарх мэдээллийг тухай бүр мэдээллийн санд бүртгэсэн байна.

Долоо. Хяналт, хариуцлага

7.1. Шуурхай албаны үйл ажиллагаатай холбоотой тайланг улирал бүр Хороонд танилцуулна.

7.2. Хороо нь энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

--ooOoo--

“Жолоочийн даатгалын сангийн шуурхай албаны ажиллах журам”-ын 1 дүгээр хавсралт

ШУУРХАЙ АЛБАНЫ ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫН ТАЛААРХ ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ

Дугаар:
(аймаг, хот, дүүрэг)

1	Даатгалын тохиолдол болсон огноо	Цаг, минут
2	Дуудлага хүлээн авсан огноо	Цаг, минут
3	Дуудлага өгсөн хүнийн овог, нэр	Холбоо барих утас
4	Даатгалын тохиолдолболсон газрын байршил	
5	Даатгалын тохиолдол болсон үеийн анхан шатны аман мэдүүлэг	
6	Даатгалын тохиолдол гаргасан автотээврийн хэрэгслийн марк, загвар	
7	Даатгалын тохиолдол гаргасан автотээврийн хэрэгслийн улсын дугаар	
8	Даатгалын тохиолдол гаргасан жолоочид нь жолоочийн даатгалд даатгуулсан эсэх	
	<input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> Тийм 1. (жолоочийн хариуцлагыг даатгасан даатгагч)
		2. (жолоочийн хариуцлагыг даатгасан даатгагч)
9	Даатгалын тохиолдол болсон газраас хөдөлсөн эсэх	
	<input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> Тийм
10	Даатгалын тохиолдол болсон газарт очих шуурхай албаны ажилтны нэр (баг)	

Тусгай тэмдэглэл:
.....
.....
.....

Дуудлага хүлээн авсан:
Шуурхай албаны оператор: (.....)
(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

Хянасан:
Шуурхай албаны дарга: (.....)
(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

“Жолоочийн даатгалын сангийн шуурхай албаны ажиллах журам”-ын 2 дугаар хавсралт

ШУУРХАЙ АЛБАНЫ ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫН ГАЗАР ДЭЭРХ ҮЗЛЭГИЙН ТЭМДЭГЛЭЛ

20 ... оны ...-р сарын ...-ны өдөр

(аймаг, хот, дүүрэг)

Шуурхай албаны дуудлагын ажилтан би

..... нарыг байлцуулж аймаг, хотын сум, баг, дүүрэг, хорооны нутаг гудамж, замд гарсан даатгалын тохиолдлын дуудлагыг оны-р сарын-ны өдрийн цаг минутад хүлээн авч, газар дээрх үзлэгийн оны-р сарын-ны өдрийн цаг минутад хийхэд уг осол хэлбэрээр (онхолдох, мөргөдөх гэх мэт) гарсан байна.

Зам тээврийн осолд өртсөн автотээврийн хэрэгслийн тоо:

Ослын улмаас гэтмсэн хүний тоо:

Ослын улмаас нас барсан хүний тоо:

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ТОДОРХОЙЛОЛТ

		А тал	В тал
Автотээврийн хэрэгслийн марк			
Автотээврийн хэрэгслийн улсын дугаар			
Автотээврийн өмчлөгч			
Жолоочийн овог, нэр			
Жолоочийн регистрийн дугаар			
Жолооны үнэмлэхийн дугаар			
Жолоочийн хаяг/утас			
Техникийн байдал			
Осол гарах үеийн	Хурд	Жолоочийн тодорхойлолт	
		Гэрчийн тодорхойлолт	
	Тээврийн хэрэгслийн зорчигчийн тоо		

Хохирогчийн эрүүл мэндийн байдлыг тодорхой бичих:.....

Автотээврийн хэрэгсэлд учирсан эвдрэлийг тодорхой бичих:.....

ЗАМ, ОРЧНЫ БАЙДАЛ
 (тохирохыг доогуур нь зурах)

Замын төрөл	Замын бартаа	Замын байдал	Замын хэсэг
Асфальт	Шулуун тэгш:	Хуурай	Уулзвар дээр:
Бетон	-уруу	Нойтон	-зохицуулагддаг
Сайжруулсан шороон	-өгсүүр	Мөстэй	-зохицуулагддаггүй
Хайрган	Налуу, шулуун:	Цастай	-явган хүний гарцтай
Хөрс	-уруу	Хальтиргаатай	Автобусны зогсоол бүхий
	-өгсүүр	Чийгтэй	Төмөр замын гарамтай
	Тахир, тэгш:	Шавартай	Гүүр, тунельд
	-налуу		Талбай
	-уруу		Суурингийн гаднах
	-өгсүүр		Суурингийн доторх
	Эвдрэлтэй		Хорооллын доторх
	Уул, жалга, гол		Нийтийн хэрэгцээний биш зам
Замын нөхцөл	Зорчих хэсэх	Цаг агаар	Үзэгдэх орчин

Нэг чигийн хөдөлгөөнтэй Эерэг хөдөлгөөнтэй Тусгаарлах зурвастай Тусгаарлах зурвасгүй Эгнээний тоо: 1 2 3 4 5 Явган хүний замтай Явган хүний замгүй Хашлагатай Хашлагагүй Хайстай Хайсгүй	гэрэлтүүлэгтэй гэрэлтүүлэггүй	тогтуун бүрхэг бороотой цастай аадар бороотой цасан шуургатай манантай салхитай	-чөлөөтэй -хязгаарлагдмал -хангалтгүй
---	----------------------------------	--	---


Дараах тохиолдлын аль нь болохыг тодорхойлох:

- Даатгалгүй этгээд даатгалын тохиолдол гаргасан
- Даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд даатгалын тохиолдол гаргасан
- Бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд тодорхой бус
- Даатгагч дампуурсан
- Бусад (.....)

Тусгай тэмдэглэл:

.....
.....
.....
.....

ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ЗУРАГЛАЛ:



Замын дүрслэл, автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний чиглэл, мөргөлдөх үеийн байрлалыг дүрслэн үзүүлнэ.

Газар дээрх үзлэгийг хийж дууссан: цаг минут.

Тэмдэглэл үйлдсэн:

Шуурхай албаны дуудлын ажилтан: (.....)

(Тэмдэг) (Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

Танилцсан: (.....)

(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

..... (.....)

(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)

..... (.....)

(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 379

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын албан тушаалд
томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.3 Компанийн тухай хуулийн 84.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, 34.1.4 Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 10.1, 10.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Тэнгэр капитал” ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд Ганибал овогтой Амартүвшинг томилохыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн дараах үүргийг чанд биелүүлж ажиллахыг “Тэнгэр капитал” ХХК /Г.Амартүвшин/-д үүрэг болгосугай:

1/ Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэх;

2/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэх;

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг мөрдөх.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН





МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 380

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын албан тушаалд
томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.3 Компанийн тухай хуулийн 84.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, 34.1.4 Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 10.1, 10.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Баянзүрх инвест” ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд Ким Нэ Хваныг томилохыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн хууль тогтоомжоор хүлээсэн дараах үүргийг чанд биелүүлж ажиллахыг “Баянзүрх инвест” ХХК /Ким Нэ Хван/-д үүрэг болгосугай:

1/ Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэх;

2/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлэх;

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг мөрдөх.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001000



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 381

Улаанбаатар хот

“Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 12¹.7, Жолоочийн даатгалын тухай хуулийн 21.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 337 дугаар тогтоолоор батлагдсан “Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-ын 2 дахь зүйлд дараах агуулга бүхий 2.5 дахь хэсгийг, 4.2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 4.2.4, 4.2.5, 4.2.6, 4.2.7, 4.2.8, 4.2.9, 4.2.10 дахь заалтыг, 4 дэх зүйлд дараах агуулгатай 4.8, 4.9, 4.10, 4.11, 4.12, 4.13, 4.14 дэх хэсгийг тус тус нэмсүгэй:

1/ “2.5. Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.3–г заасан буцаан нэхэмжилсэн нөхөн төлбөрийг Жолоочийн даатгалын санд төвлөрүүлнэ.”

2/ “4.2.4. Хохирогч болон буруутай этгээдийн өргөдөл;

4.2.5. Иргэний болон жолооны үнэмлэхний хуулбар, тээврийн хэрэгслийн гэрчилгээний хуулбар;

4.2.6. Даатгалын тохиолдол болсныг нотолсон баримт бичиг;

4.2.7. Нөхөн төлбөрийн хэмжээг хуульд заасан эрх бүхий этгээд, эсхүл даатгалын хохирол үнэлэгчийн дүгнэлт, тодорхойлолт;

4.2.8. Нөхөн төлбөр олгохтой холбоотой бусад шаардлагатай баримт бичиг;

4.2.9. Хохирогчид олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх эрхийг Жолоочийн даатгалын санд шилжүүлэх гэрээг хохирогчтой байгуулж, нотариатаар баталгаажуулсан байна;

4.2.10. Гэм буруутай этгээдтэй нөхөн төлбөрийг буцаан барагдуулах талаар гэрээ байгуулж, нотариатаар баталгаажуулсан байна;”.

3/ “4.8. Энэхүү журмын 4.2.9-д заасан гэрээнд хохирогч өөрөө буруутай болох нь тогтоогдвол авсан нөхөн төлбөрийг үл маргах журмаар буцаан Жолоочийн даатгалын санд шилжүүлэхийг тусгана.

4.9. Энэхүү журмын 4.2.9-д заасан гэрээнд хохирогч нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх үйл явцад Жолоочийн даатгалын сантай хамтран ажиллахаар талаар тусгасан байна.

4.10. Жолоочийн даатгалын сан нь хохирлын үнэлгээг дахин хянан үзэж, хохирогч болон буруутай этгээдээс нэмэлт мэдээлэл шаардана.

4.11. Даатгалын хохирол үнэлэгчийн тогтоосон хохирлын үнэлгээг буруутай этгээд, хохирогч, жолоочийн даатгалын сангийн аль нэг тал нь хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд өөр даатгалын хохирол үнэлгээний байгууллагаар өөрийн зардлаар дахин нэг удаа хийлгэж болно. Дахин хийлгэсэн үнэлгээ, анхны үнэлгээний дүн зөрүүтэй байвал аль бага үнэлгээний дүнг үндэслэн нөхөн төлбөрийг олгоно.

4.12. Жолоочийн даатгалын сан нь хохирогчид нөхөн төлбөр төлөх үндэслэлгүй гэж үзвэл албан бичгээр хариу мэдэгдэнэ.

4.13. Даатгагч нь даатгалын гэрээний мэдээгээ жолоочийн даатгалын мэдээллийн санд ирүүлээгүйгээс жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгосон тохиолдолд тухайн даатгагчаас нөхөн төлбөрийг буцаан нэхэмжилнэ.

4.14. Жолоочийн даатгалын сан нь Жолоочийн даатгалын тухай хуулийн 20.2-д заасны дагуу олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан төлүүлэх талаар хууль, хяналтын байгууллагад хандах, нөхөн төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллана.”.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 337 дугаар төгтоолоор батлагдсан “Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс

байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-ын 4.4 дэх заалтыг дор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

1/ “4.4. Холбоо нь Жолоочийн даатгалын тухай хуулийн 23.1.2, 23.1.3, 23.1.4-т заасан зориулалт тус бүрийн зарцуулах хөрөнгийн төсвийн төслийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд ирүүлж хянуулсны дараа Холбоо нь төсвийн төслийг хэлэлцэж 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор батална.”

3. Журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 382

Улаанбаатар хот

“Эрсдэлийн шийдэл” ХХК-д даатгалын зуучлагчийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5.1.2, 11.1, 11.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Эрсдэлийн шийдэл” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, даатгагч болон даатгуулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн ажиллахыг “Эрсдэлийн шийдэл” ХХК /Б.Анхбаяр/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д. БАЯРСАЙХАН



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 383

Улаанбаатар хот

“Ди Си Эф Си” ХХК-ийн брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.4, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 8.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ди Си Эф Си” ХХК-ийн үнэт цаасны зах зээл дээр брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. Үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөх, татан буулгах асуудлаа Улсын бүртгэлийн ерөнхий газарт тавьж шийдвэрлүүлэн Хороонд эргэж хариу мэдэгдэхийг “Ди Си Эф Си” ХХК-ийн удирдлагуудад үүрэг болгосугай.
3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авах, холбогдох баримтуудыг хүлээлцэх ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг дээрх компаниудын эрх бүхий төлөөллийг оролцуулан гүйцэтгэж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 384

Улаанбаатар хот

“Суурь секьюритиес” ХХК-ийн брокер, дилерийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.4, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 8.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Суурь секьюритиес” ХХК-ийн үнэт цаасны зах зээл дээр брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
2. Үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөх, татан буулгах асуудлаа Улсын бүртгэлийн ерөнхий газарт тавьж шийдвэрлүүлэн Хороонд эргэж хариу мэдэгдэхийг “Суурь секьюритиес” ХХК-ийн удирдлагуудад үүрэг болгосугай.
3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авах, холбогдох баримтуудыг хүлээлцэх ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг дээрх компаниудын эрх бүхий төлөөллийг оролцуулан гүйцэтгэж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.



ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 385

Улаанбаатар хот

Г Т

**“Шад трейд” ХК-ийн үнэт цаасны бүртгэлд
өөрчлөлт оруулах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 23.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.1.2, 34.1.1, “Шад трейд” ХК-ийн 2012 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Шад трейд” ХК-ийн оноосон нэрийг “Хот девелопмент” ХК болгон үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/-т, хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. “Шад трейд” ХК-ийн үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулахтай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг гүйцэтгэх захирал /Б.Пүрэвбаатар/-д үүрэг болгосугай:

1/ Энэхүү тогтоолын 1-т заасан оноосон нэрийн өөрчлөлтийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, энэ тухай Хороонд мэдэгдэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа чанд баримтлаж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж ажиллах.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.



ДАРГА

Д. БАЯРСАЙХАН



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 386

Улаанбаатар хот

“Хасбанк” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5.1.2, 11.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хасбанк” ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, даатгагч болон даатгуулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн ажиллахыг “Хасбанк” ХХК /Д.Бат-Очир/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х. Бум-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 387

Улаанбаатар хот

“Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д дор дурдсан агуулгатай 2.23¹, 2.24¹, 2.27¹, 2.28¹, 2.29¹ дэх хэсгийг тус тус нэмсүгэй:

1/ “2.23¹. Өргөдөл гаргагч нь энэ журмын 2.17-д заасан Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий банк, түүний хараат болон охин компани бол энэ журмын 2.17-2.2.26¹-д заасан шаардлагыг хангахаас гадна дараах нэмэлт шаардлагыг хангана:

2.23¹.1. Банк нь даатгалын зуучлалын үйл ажиллагааг хариуцах тусгайлсан нэгжтэй байх бөгөөд энэхүү нэгжийг тухайн банкны Төлөөлөн удирдах зөвлөл эсхүл гүйцэтгэх захирлын шийдвэрээр байгуулсан байх;

2.23¹.2. Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа явуулах нэгжийн удирдах албан тушаалтан болон ажилтнууд нь холбогдох мэргэжлийн холбоод эсхүл хамтран ажиллах даатгагчаас зохион байгуулсан даатгалын сургалтад хамрагдаж, Хороо болон Хорооны орон нутгийн төлөөлөгчийн зохион байгуулсан даатгалын зуучлалын шалгалтад тэнцсэн байх;” /Энэхүү заалтыг 2013 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө./

2/ ”2.24¹. Өргөдөл гаргагч нь банк бол энэ журмын 2.24 дэх хэсэгт зааснаас гадна дараах баримт бичгийг ирүүлнэ:

2.24¹.1. Хоёроос доошгүй даатгалын компанитай байгуулах хамтран ажиллах гэрээний төсөл. Хамтран ажиллах гэрээний төсөлд дараах зүйлийг тусгана:

2.24¹.1.1. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу даатгалын хураамжийн орлогыг даатгагчийн дансанд шуурхай шилжүүлэх ажиллагааны зохицуулалт;

2.24¹.1.2. хамтран ажиллах даатгагч бүрийн нэр дээр данс нээх талаарх зохицуулалт;

2.24¹.1.3. даатгалын хураамж төлөгдсөнөөр даатгалын гэрээ байгуулагдсанд тооцож, даатгалын тохиолдол гарахад даатгалын хураамжийн орлого даатгагчийн дансанд шилжсэн эсэхээс үл хамааран даатгагч даатгуулагчид нөхөн төлбөр олгох талаарх зохицуулалт;

2.24¹.2. даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой дотоод журмын төсөл. /тус журмын төсөлд даатгалын зуучлалын үйл ажиллагааг эрхлэх дотоод бүтэц, чиг үүрэг, хариуцлага, тайлагнал, төлбөр тооцооны асуудлыг зохицуулахаар тусгасан байна./ “,

3/ “2.27¹. Даатгалын зуучлалын үйл ажиллагааг банк болон банкны салбараар дамжуулан хийх бөгөөд банк нь Хорооноос авсан салбарын зөвшөөрөлгүйгээр аймаг, орон нутагт даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

4/ “2.28¹. Даатгалын зуучлалын үйл ажиллагааг хариуцсан удирдах албан тушаалтан нь Хороонд даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой тайлан мэдээг гаргаж өгөх, даатгалын зуучлалын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах чиг үүрэгтэй байна.”,

5/ “2.29¹. Даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхэлж буй банк нь орон нутагт тусдаа данстай байхыг хориглоно.”.

2. “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 2.17 дахь хэсгийн “...байх.” гэсний дараа “эсхүл түүний хараат болон охин компани” гэж, мөн журмын 2.25¹ дахь хэсгийн “банк” гэсний дараа “түүний хараат болон охин компани” гэж, мөн журмын 3.8¹ дэх хэсгийн “...хийж,” гэсний дараа “даатгагчийн хувьд...” гэж, мөн журмын 3.8² дахь заалтын

“Салбар...” гэсний өмнө “Даатгалын компанийн” гэж, мөн хэсгийн “...хангамжтай...” гэсний дараа “байх нөхцөлийг бүрдүүлсэн...” гэж, мөн журмын 3.9.5 дахь заалтын “...хангамж;” гэсний дараа “Даатгалын компанийн салбар нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд дараах баримт бичгийг нэмж ирүүлнэ:” мөн журмын 3.20 дах хэсгийн “... дагуу” гэсний дараа “энэ журмын 3.21, 3.22-т заасан баримт бичгийн хамт” гэж, мөн журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн “Даатгалын хэлбэр” гэсний дараа “, бүтээгдэхүүн” гэж.

3. “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 2.18 дахь заалтыг дор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

1/ “2.18. Даатгалын зуучлагч хуулийн этгээдийн дүрмийн санг зээлийн хөрөнгөөр бүрдүүлэхийг хориглох бөгөөд дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийн доод хэмжээ нь 20.0 сая төгрөг, давхар даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд 50.0 сая төгрөг байна.”.

4. “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”- 2.21 дэх заалтын “Даатгалын тухай хуулийн 6.1-д заасан ангиллын дагуу урт хугацааны даатгал, эсхүл ердийн даатгалын зуучлалын аль нэгийг эрхлэх.” гэснийг хассугай.

5. Энэхүү тогтоолын 3 дахь заалтаар тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээг 2012 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор нэмэгдүүлж, дүрмийн санг бүрдүүлсэн тухай холбогдох материалаа 2013 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг даатгалын зуучлагч компаниудад мэдэгдэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын албанд үүрэг болгосугай.

6. Нэмэлт, өөрчлөлтийг журамд оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 388

Улаанбаатар хот

Үндэсний хөрөнгө оруулалтын банкинд харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4, Банкны тухай хуулийн 6.2.7 дахь заалт, Монголбанкны хүсэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны анхдагч зах зээлд Засгийн газрын үнэт цаасыг худалдан авах зорилгоор Үндэсний хөрөнгө оруулалтын банкинд харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл олгосонтой холбогдуулан хууль тогтоомжоор хүлээсэн дараахь үүргийг чанд биелүүлж ажиллахыг Үндэсний хөрөнгө оруулалтын банк /Б.Баярсайхан/-д үүрэг болгосугай:


1/ Хөрөнгө оруулагчид, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх;

2/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх;

3/ Хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг мөрдөх.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасгай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 389

Улаанбаатар хот

“Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 232 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 6.2, 6.3¹ дахь заалтыг дор дурдсан агуулгатайгаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ “6.2. Даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн хувьд учирч болзошгүй хохирлын нөөц санг дараах аргачлалаар улирал тутамд байгуулна. Үүнд:

$$\left(\frac{OTX - \text{аас олгосон нөхөн төлбөр} + \text{байгуулсан УБХНС}}{OTX} \right) * 100\% < X \text{ үед}$$

$$УБХНС = \left[X - \left(\frac{OTX - \text{аас олгосон нөхөн төлбөр} + \text{байгуулсан УБХНС}}{OTX} \right) * 100\% \right] \times OTX$$

Энд,

“ОТХ” – орлогод тооцсон хураамж;

“УБХНС”- учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан;

“УБХНС” –учирч болзошгүй хохирлын нөөц сан;

“Х” – Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлал”-ын 3.1.1-д заасан “Даатгалын цэвэр хураамж”-ийн хувь.

2/ “6.3¹. Даатгалын цэвэр хураамжийн хувийг жил бүрийн 1 дүгээр сард багтаан даатгалын бүтээгдэхүүн тус бүрээр тооцож Хороонд ирүүлнэ. Хороо даатгалын цэвэр хураамжийн хувийг тооцож ирүүлснээс хойш 30 хоногийн дотор багтаан хянаж, хариу хүргүүлнэ. Албан журмын даатгалын хувьд цэвэр хураамжийн хувийг Хороо жил бүр тогтооно.” гэж.

2. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын цэвэр хураамжийн хувийг 2012 онд 60 хувиар тогтоосугай.

3. Даатгалын цэвэр хураамжийн хувийг 2013 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Хороогоор хянуулж, 2012 оны жилийн эцэст байгуулах учирч болзошгүй хохирлын нөөцийн санг энэхүү тогтоолын 1 дэх заалтын 1 дэх хэсэгт заасан аргачлалын дагуу байгуулахыг Даатгалын компаниудад үүрэг болгосугай.

4. Журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х. Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 390

Улаанбаатар хот

“Хаан даатгал” ХХК-д дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн
хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хаан даатгал” ХХК-ийн дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээг тус компанийн хувь нийлүүлэгч Г.Энхбилэгээс 200,000,000.0 /хоёр зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлэх, А.Мэндбаяр, Ч.Чимидсүрэн нарт тус бүр 100,000,000.0 /нэг зуун сая/ төгрөгийн үнэ бүхий хувьцааг Ж.Баярсайханаас, Г.Энхбилэгт 300,000,000.0 /гурван зуун сая/ төгрөгийн үнэ бүхий хувьцааг Ж.Баярсайхан, Б.Түвшин нараас бэлэглэлийн гэрээгээр тус тус шилжүүлж, хувь нийлүүлэгчдийн бүтцэд дараахь байдлаар өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь	
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан		Эцсийн үлдэгдэл
1	Ж.Баярсайхан	1,700,000,000.0		-450,000,000.0	1,250,000,000.0	56,81%
2	Г.Энхбилэг	250,000,000.0	500,000,000.0		750,000,000.0	34,09%
3	Б.Түвшин	50,000,000.0		-50,000,000.0	0,0	0,0%
4	А.Мэндбаяр	0.0	100,000,000.0		100,000,000.0	4,55%
5	Ч.Чимидсүрэн	0.0	100,000,000.0		100,000,000.0	4,55%
	Дүн	2,000,000,000.0	700,000,000.0	-500,000,000.0	2,200,000,000.0	100.0%

2. Дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээ болон хувь нийлүүлэгчдийн бүтцэд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд

001365

тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2013 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Хаан даатгал” ХХК /Ж.Баярсайхан/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.



ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 391

Улаанбаатар хот

“Ганзам даатгал” ХХК-д дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ганзам даатгал” ХХК-ийн дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээг тус компанийн хувь нийлүүлэгч “Улаанбаатар Төмөр Зам” Хувь нийлүүлсэн нийгэмлэгээс 500,000,000.0 /таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараахь байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	“Улаанбаатар Төмөр Зам” ХНН	1,500,000,000.0	500,000,000.0	2,000,000,000.0	100%
	Дүн	1,500,000,000.0	500,000,000.0	2,000,000,000.0	100%

2. Дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2013 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Ганзам даатгал” ХХК /Д.Махвал/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 392

Улаанбаатар хот

“Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн журам”
батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 12^{1.7} дахь хэсгийн заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Батлагдсан журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны
2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн
392 дугаар тогтоолын хавсралт

**ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН
МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЖУРАМ**

УХААД410 5043238

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Даатгалын тухай хуулийн 12¹.3.1, Жолоочийн даатгалын тухай хуулийн 24.1-д заасан жолоочийн даатгалын мэдээллийн санг үүсгэх, жолоочийн даатгалын мэдээллийг төвлөрүүлэн цуглуулах, хадгалах, харилцан солилцох, даатгагч, даатгуулагч, даатгалын тохиолдлын хохирогч, төрийн байгууллагуудыг шаардлагатай мэдээллээр хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү журам нь Жолоочийн даатгалын тухай хууль тогтоомжийн хүрээнд мөрдөгдөнө.

ХОЁР. Журамд хэрэглэгдэх нэр томъёоны тайлбар

- 2.1 Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дараах утгаар ойлгоно:
- 2.1.1 “Төрийн холбогдох байгууллага” гэж Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх), Зам, тээврийн яам, Хууль зүйн яам, Сангийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Замын цагдаагийн газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар Гадаадын иргэн харьяатын алба зэрэг төрийн байгууллагыг;
- 2.1.2 “мэдээллийн сангийн программ хангамж” (цаашид “программ хангамж” гэх) гэж мэдээллийн сангийн үйл ажиллагааны зориулалтаар боловсруулсан албан ёсны программ хангамжийг;
- 2.1.3 “мэдээллийн сангийн хэрэглэгч” (цаашид “хэрэглэгч” гэх) гэж мэдээллийн сангийн программ хангамжид холбогдон ажиллах эрх олгогдсон Албан журмын даатгагчдын холбоо (цаашид “Холбоо” гэх), даатгагч, даатгуулагч, төрийн холбогдох байгууллагыг;
- 2.1.4 “стандарт” гэж мэдээллийн сан нь даатгагч болон төрийн холбогдох байгууллагуудын мэдээллийн сантай холбогдож цахим хэлбэрээр харилцан солилцох мэдээллийг бүтцийг.
- 2.2 Энэхүү журамд тодорхойлоогүй нэр томъёог Монгол Улсын хуульд тодорхойлсноор ойлгоно.

ГУРАВ. Жолоочийн даатгалын мэдээллийн төрөл

- 3.1 Хувь хүний мэдээлэлд дараах мэдээллийг хамруулна:

- 3.1.1 Иргэний харъяалал, овог, нэр, регистрийн дугаар, нас, хүйс, оршин суугаа газрын хаяг, холбоо барих утас, факс, и-мэйл хаяг;
- 3.1.2 Жолооны эрхийн үнэмлэхийн дугаар, ангилал, тээврийн хэрэгсэл жолоодох туршлага, мэргэшсэн жолоочийн эрхийн үнэмлэхийн дугаар болон бусад шаардлагатай мэдээлэл.
- 3.2 Хуулийн этгээдийн мэдээлэлд дараах мэдээллийг хамруулна:
 - 3.2.1 Хуулийн этгээдийн оноосон нэр, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, байршил, албан утас, факс, и-мэйл хаяг болон бусад шаардлагатай мэдээлэл.
- 3.3 Тээврийн хэрэгслийн мэдээлэлд дараах мэдээллийг хамруулна:
 - 3.3.1 Тээврийн хэрэгслийн ангилал, гэрчилгээний дугаар, улсын дугаар, арлын дугаар;
 - 3.3.2 Тээврийн хэрэгслийн үйлдвэр, марк, модель, зориулалт, үйлдвэрлэсэн он, өнгө, суудлын тоо, хөдөлгүүрийн багтаамж, даацын хэмжээ болон бусад шаардлагатай мэдээлэл.
- 3.4 Зам тээврийн осол, зөрчлийн мэдээлэлд дараах мэдээллийг хамруулна:
 - 3.4.1 Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн зам тээврийн осол, зөрчил болсон газар нутгийн байршил, огноо, ослын шалтгаан, зам тээврийн осол гаргагч, хохирогчийн мэдээлэл болон бусад шаардлагатай мэдээлэл.
- 3.5 Даатгалын гэрээний мэдээлэлд дараах мэдээллийг хамруулна:
 - 3.5.1 Даатгалын гэрээний дугаар, гэрээний хугацаа, итгэлцүүрийн утга, даатгалын хураамжийн дүн, даатгуулагчийн бүлэг болон бусад шаардлагатай мэдээлэл.
- 3.6 Даатгалын тохиолдол, нөхөн төлбөрийн мэдээлэлд дараах мэдээллийг хамруулна:
 - 3.6.1 Холбоо болон даатгагчид бүртгэгдсэн даатгалын тохиолдол болсон газар нутгийн байршил, огноо, даатгалын тохиолдлын утга, даатгалын тохиолдол гаргагч, хохиролд орсон зүйл, хохирогчийн нэхэмжилсэн болон олгогдсон нөхөн төлбөрийн дүн болон бусад шаардлагатай мэдээлэл.

ДӨРӨВ. Мэдээллийн эх сурвалж

- 4.1 Мэдээллийн санд төвлөрүүлэн нэгтгэсэн мэдээллийн үнэн зөв эсэхийг дараах этгээд магадлана:
 - 4.1.1 Жолоочийн даатгалд даатгуулагч хувь хүн болон хуулийн этгээдтэй байгуулсан даатгалын гэрээ, даатгалын тохиолдол, нөхөн төлбөрийн мэдээлэл болон бусад холбогдох мэдээллийг даатгагч;
 - 4.1.2 Шуурхай албанд бүртгэгдсэн даатгалын тохиолдол, даатгалын сангаас олгосон нөхөн төлбөр, мэдээллийн сангаас олгосон лавлагаа, мэдээлэл болон бусад холбогдох мэдээллийг Холбоо;

- 4.1.3 Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгсэл болон түүний өмчлөгч, мэргэшсэн жолоочийн эрхийн мэдээллийг Зам тээврийн яам;
- 4.1.4 Зам тээврийн осол, зөрчлийн бүртгэл, Жолоочийн даатгалын хууль тогтоомж зөрчигчдийн мэдээлэл, жолооны эрхийн мэдээллийг Цагдаагийн ерөнхий газар, Замын цагдаагийн газар;
- 4.1.5 Дамжин өнгөрч байгаа болон түр хугацаагаар орж ирсэн автотээврийн хэрэгсэл, түүний өмчлөгч, жолоочийн мэдээллийг Хил хамгаалах ерөнхий газар (хилийн боомт);
- 4.1.6 Импортоор орж ирсэн болон экспортоор гарсан тээврийн хэрэгслийн мэдээллийг Гаалийн ерөнхий газар;
- 4.1.7 Иргэний болон хуулийн этгээдийн талаарх мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газар;
- 4.1.8 Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг мэдээллийг Татварын ерөнхий газар.

ТАВ. Мэдээллийн сан бүрдүүлэх

- 5.1 Холбоо нь даатгагч болон төрийн холбогдох байгууллагаас жолоочийн даатгалын мэдээллийг хүлээн авах, харилцан мэдээлэл солилцох үйл ажиллагааг хамтран ажиллах гэрээний хүрээнд хийж гүйцэтгэнэ.
- 5.2 Даатгагчаас жолоочийн даатгалын мэдээлэл хүлээн авах маягт, стандартыг Хороогоор хянуулсны үндсэн дээр Холбоо батална.
- 5.3 Холбоо болон даатгагч жолоочийн даатгалын мэдээллийг дор дурдсан хугацаанд мэдээллийн санд хүргүүлнэ:
 - 5.3.1 Даатгагч хувь хүн, хуулийн этгээд болон мэргэшсэн, С, D ангиллын жолоочтой байгуулсан жолоочийн даатгалын гэрээний мэдээллийг тухайн сарын 10, 20, 30-ны өдөр энэхүү журмын 5.2-т заасан маягт, стандартын дагуу боловсруулан цахим хэлбэрээр;
 - 5.3.2 Даатгагч хохирогчид олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг тухайн өдөрт нь энэхүү журмын 5.2-т заасан маягт, стандартын дагуу боловсруулан цахим хэлбэрээр;
 - 5.3.3 Даатгагч цуцлагдсан болон нэмэлт, өөрчлөлт орсон жолоочийн даатгалын гэрээний мэдээллийг тухайн өөрчлөлт орсон өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан энэхүү журмын 5.2-т заасан маягт, стандартын дагуу боловсруулан цахим хэлбэрээр;

- 5.3.4 Даатгагч 1 сар хүртэлх хугацаатайгаар байгуулагдсан жолоочийн даатгалын гэрээний мэдээллийг гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 5 хоногт багтаан энэхүү журмын 5.2-т заасан маягт, стандартын дагуу боловсруулан цахим хэлбэрээр;
- 5.3.5 Даатгагч даатгуулагчийн нөхөн төлбөр авсан тооноос хамааруулан даатгалын хураамжийн хэмжээг өсгөж хийсэн гэрээг энэхүү журмын 5.2-т заасан маягт, стандартын дагуу боловсруулан тухайн өдөрт нь цахим хэлбэрээр;
- 5.3.6 Даатгагчийн жолоочийн даатгалын үйл ажиллагаанд ашиглагдаж буй программ хангамж нь мэдээллийн сантай холбогдсон тохиолдолд жолоочийн даатгалын мэдээллийг тухайн өдөрт нь энэхүү журмын 5.2-т заасан маягт, стандартын дагуу боловсруулан цахим хэлбэрээр;
- 5.3.7 Холбоо шуурхай албанд бүртгэгдсэн даатгалын тохиолдол, даатгалын сангаас хохирогчид олгогдсон болон буцаан нэхэмжилсэн нөхөн төлбөрийн мэдээллийг энэхүү журмын 5.2-т заасан маягт, стандартын дагуу боловсруулан цахим хэлбэрээр тухай бүр.
- 5.4 Төрийн холбогдох байгууллагууд энэхүү журмын 5.1-д заасан гэрээнд тусгасан мэдээллийг цахим хэлбэрээр тухай бүр мэдээллийн санд нийлүүлнэ.
- 5.5 Холбоо даатгагч болон төрийн холбогдох байгууллагуудтай жолоочийн даатгалын мэдээллийг программ хангамжийн тусламжтайгаар харилцан солилцож болно.
- 5.6 Мэдээллийн сан дахь жолоочийн даатгалын гэрээний мэдээлэл нь өөрчлөн шинэчлэгдэх үед шинээр орж буй өөрчлөлт нь хураамжийн дүнд нөлөөлөхүйц байвал өөрчлөлтийн өмнөх мэдээлэл нь түүх болж хадгалагдана.

ЗУРГАА. Мэдээллийн сангийн үйл ажиллагаа

- 6.1 Холбоо нь мэдээллийн сангийн дараах үйл ажиллагааг эрхэлнэ:
- 6.1.1 Жолоочийн даатгалын мэдээллийг энэхүү журмын 4 дүгээр зүйлд заасан этгээдээс төвлөрүүлэн нэгтгэж мэдээллийн санг үүсгэх, ашиглах;
- 6.1.2 Жолоочийн даатгалын гэрээ, даатгалын тохиолдол, нөхөн төлбөрийн мэдээлэлд хяналт тавих замаар Жолоочийн даатгалын тухай хуулийн үнэн, зөв, бодитой хэрэгжилтийг хангах;
- 6.1.3 Даатгуулагчийн жолоочийн даатгалын гэрээн дэх бүлэг, нөхөн төлбөр авсан тоо, худал мэдүүлсэн тоог бүртгэх;
- 6.1.4 Мэдээллийн сангийн мэдээллийг даатгагч болон төрийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах гэрээний дагуу харилцан солилцох, харьцуулан шалгах, шинэчлэх;
- 6.1.5 Мэдээллийн сангаас лавлагаа, мэдээлэл өгөх;

- 6.1.5.1 Холбоо мэдээллийн сангаас лавлагаа хүсэгчид Жолоочийн даатгалын тухай хуулийн 24.4, 24.5, 24.6-д заасны дагуу лавлагаа, мэдээллийг олгоно.
- 6.1.5.2 Даатгуулагчийн сүүлийн 3 жил хүртэлх жолоочийн даатгалын түүх, мэдээллийг лавлагаанд тусгаж болно.
- 6.1.5.3 Даатгагч, даатгуулагч болон төрийн холбогдох байгууллага нь мэдээллийн санд алдаатай мэдээлэл нийлүүлснээс учирсан аливаа хохирлыг мэдээллийн сангаас лавлагаа, мэдээлэл олгогдсон эсэхээс үл хамааран Холбоо хариуцахгүй.
- 6.1.6 Мэдээллийн сангийн мэдээллийг боловсруулж тайлан судалгаа, бусад бүтээгдэхүүн болгон гаргах.
- 6.2 Холбоо нь энэхүү журмын 6.1-д заасан мэдээллийн сангийн үйл ажиллагааг эрхлэхдээ программ хангамж, техник, тоног төхөөрөмж ашиглана.
- 6.3 Мэдээллийн санд ашиглагдах программ хангамж, техник, тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай, тасралтгүй ажиллагааг Холбоо хариуцна.
- 6.4 Мэдээллийн сангийн программ хангамжид нэвтрэх, ажиллах эрх бүхий хэрэглэгчийн бүртгэлийг Холбоо хөтөлж, үйл ажиллагаанд нь хяналт тавина.
- 6.5 Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:
- 6.5.1 Холбооны ажилтан, албан хаагч, эрх бүхий албан тушаалтан мэдээллийн сан дахь жолоочийн даатгалын мэдээллийг хууль, журамд зааснаас бусад зорилгоор ашиглах, тараах, задруулах;
- 6.5.2 Холбоо, даатгагч, даатгуулагч, төрийн холбогдох байгууллага нь мэдээллийн санд жолоочийн даатгалын мэдээллийг санаатайгаар алдаатай нийлүүлэх, солилцох, мэдээлэх;
- 6.5.3 Мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар буруу, ташаа зар сурталчилгаа явуулах, мэдээлэл өгөх;
- 6.5.4 Мэдээллийн сангийн мэдээллийг Холбооны зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, ашиглах, Монгол Улсаас авч гарах, гадаад улсад шилжүүлэх.
- 6.6 Мэдээллийн сангийн мэдээллийг хадгалах, хамгаалах, аюулгүй байдлыг хангах:
- 6.6.1 Жолоочийн даатгалын мэдээллийг мэдээллийн санд хүлээн авсан өдрөөс хойш 10 жилийн хугацаанд хадгална;
- 6.6.2 Холбоо мэдээллийн санд хадгалагдаж буй мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж баталгаажуулна;
- 6.6.3 Мэдээллийн сангийн нууцлал, хамгаалалтыг хангаагүйн улмаас учирсан хохирлыг Холбоо хариуцна;
- 6.6.4 Мэдээллийн сангийн программ хангамжид нэвтрэх эрх бүхий ажилтны буруутай үйл ажиллагаанаас мэдээллийн сангаас мэдээлэл алдагдах, программ хангамжийг гэмтээх, мэдээллийн сангийн аюулгүй байдалд хохирол учруулсан тохиолдолд

учруулсан хохирлыг тухайн ажилтан болон түүний харьяалагдах байгууллага нь бүрэн хариуцна;

- 6.6.5 Холбооны эрх бүхий ажилтан мэдээллийн сангийн цахим өгөгдлийн санг долоо хоног бүр, шаардлагатай тохиолдолд тухай бүр нөөцлөн, архивлаж холбогдох бүртгэл хөтөлнө.

ДОЛОО. Хамтран ажиллах гэрээний нөхцөл

- 7.1 Холбоо нь даатгагч болон холбогдох төрийн байгууллагуудтай байгуулах мэдээлэл нийлүүлэх, харилцан солилцох, хамтран ажиллах гэрээнд дараах нөхцлийг заавал тусгана:
- 7.1.1 Гэрээ байгуулж байгаа талуудын нэр, хаяг, регистр, холбоо барих утас;
 - 7.1.2 Гэрээний хугацаа, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээ цуцлах, дуусгавар болгох, хүчингүй болгох нөхцлүүд;
 - 7.1.3 Харилцан солилцох мэдээлэл, түүний бүтэц;
 - 7.1.4 Мэдээлэл нийлүүлэх, ашиглах хугацаа;
 - 7.1.5 Мэдээллийн нууцлалыг хадгалах, эрх олгогдоогүй этгээдэд задруулахгүй байх, үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг хэрхэн барагдуулах, хүлээх хариуцлагын талаар;
 - 7.1.6 Гэрээний талуудын эрх, үүрэг;
 - 7.1.7 Гомдол гаргах, маргаан шийдвэрлэх талаар.

НАЙМ. Холбооны эрх, үүрэг

- 8.1 Холбоо дараах эрхтэй:
- 8.1.1 Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн үйл ажиллагаа эрхлэх;
 - 8.1.2 Даатгагч, холбогдох төрийн байгууллагын нийлүүлж байгаа мэдээллийг хянан үзсэний үндсэн дээр мэдээллийн санд оруулах, бүрэн бус, эргэлзээтэй, тодорхойгүй мэдээллийг нягтлан шалгаж, шаардлага хангаагүй мэдээг хүлээн авахаас татгалзах, энэхүү журмын 5.3, 5.4-т заасан хугацаанд мэдээллээ нийлүүлэх, алдаатай мэдээллийг дахин ирүүлэхийг шаардах;
 - 8.1.3 Даатгагч нь жолоочийн даатгалын мэдээллийг удаа дараа хоцроосон тохиолдолд шаардлагатай арга хэмжээг хууль, журмын дагуу авах саналыг Хороонд хүргүүлэх, сангаас лавлагаа, мэдээлэл авах эрхийг хязгаарлах;
 - 8.1.4 Хамтран ажиллах гэрээ байгуулсан этгээд нь мэдээллийн сангийн мэдээллийг хэрхэн ашиглаж байгаа талаар тайлбар авах, хяналт тавих.
- 8.2 Холбоо дараах үүрэгтэй:

- 8.2.1 Жолоочийн даатгалын мэдээллийн санг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэх, хөтлөх, хамгаалах, мэдээлэх, холбогдох хууль, журмын дагуу өөрчлөлт шинэчлэлтийг хийх, боловсруулах;
- 8.2.2 Мэдээллийн сангийн хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, нууцлалыг хангахтай холбогдсон шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 8.2.3 Мэдээллийн сангаас тайлан, мэдээ гаргах, судалгаа, дүн шинжилгээ хийх, ашиглах, холбогдох байгууллагуудад хүргүүлэх;
- 8.2.4 Хамтран ажиллах гэрээ байгуулсан даатгагчид мэдээллийн сангийн программ хангамжид нэвтрэх эрх олгох, хэрэглэгчээр бүртгэх, эрхийн зохицуулалтыг хэрэгжүүлэх;
- 8.2.5 Даатгагч болон төрийн холбогдох байгууллагатай хамтран ажиллах гэрээний дагуу харилцан солилцсон мэдээллийн бүртгэлийг хөтлөх, баталгаажуулах;
- 8.2.6 Мэдээллийн сангаас лавлагаа, мэдээлэл олгох, бүртгэл хөтлөх;
- 8.2.7 Даатгагч болон даатгалын сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг холбогдох журмын дагуу цагдаагийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлэх;
- 8.2.8 Жолоочийн даатгалд хамрагдаагүй тээврийн хэрэгсэл, өмчлөгчийг илрүүлэн гаргах;
- 8.2.9 Даатгагч, даатгуулагч, төрийн байгууллагын нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулахгүй байх;
- 8.2.10 Мэдээллийн сангийн үйл ажиллагатай холбогдсон хууль, хяналтын байгууллагаас гаргасан шаардлага, зохицуулалтыг хэрэгжүүлэх;
- 8.2.11 Холбооны ажилтан нь энэхүү журмаар хориглосон мэдээллийг мэдээллийн санд нийлүүлсэн, даатгуулагчийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулсан бол гэм буруутай ажилтанд Холбооны дотоод журмын дагуу хариуцлага хүлээлгэх.

ЕС. Даатгагчийн эрх, үүрэг

- 9.1 Даатгагч нь дараах эрхтэй:
 - 9.1.1 Мэдээллийн санд нийлүүлсэн мэдээлэл нь өөрчлөгдөх, худал, алдаатай нэмэлт мэдээлэл оруулахгүй байхад хяналт тавих;
 - 9.1.2 Өөрийн нийлүүлсэн мэдээллийн эх сурвалжид эргэлзээтэй байдал үүссэний улмаас уг мэдээллийг тодруулах, нягтлан шалгах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд даатгуулагч болон холбогдох байгууллагуудад хүсэлт гаргаж, шийдвэрлүүлэх;
 - 9.1.3 Жолоочийн даатгалын үйл ажиллагаандаа ашиглах лавлагаа, мэдээллийг мэдээллийн сангаас үнэ төлбөргүй авах.

9.2 Даатгагч нь дараах үүрэгтэй:

- 9.2.1 Холбоотой байгуулсан хамтран ажиллах гэрээнд заасан үүргээ биелүүлэх;
- 9.2.2 Жолоочийн даатгалын мэдээллийг энэхүү журмын 5.3.1-5.3.6-д заасан хугацаанд мэдээллийн санд нийлүүлэх;
- 9.2.3 Жолоочийн даатгалын мэдээллийн үнэн зөв эсэхийг нягтлан шалгасны үндсэн дээр мэдээллийн санд нийлүүлэх;
- 9.2.4 Мэдээллийн санд нийлүүлсэн мэдээлэл алдаатай болон бүрэн гүйцэд биш шалтгаанаар мэдээллийн сангаас буцаагдсан тохиолдолд ажлын 3 хоногийн дотор дахин засварлаж нийлүүлэх;
- 9.2.5 Мэдээллийн санд нийлүүлсэн жолоочийн даатгалын гэрээний нийт хураамжийн дүн, хохирогчид олгогдсон нөхөн төлбөрийн нийт дүн нь өөрт бүртгэгдсэн дүнтэй тохирч байгаа эсэхэд хяналт тавих;
- 9.2.6 Мэдээллийн санд мэдээлэл тогтмол нийлүүлэх үйл ажиллагааг хариуцсан мэдээллийн сангийн бүртгэлийн ажилтанг томилох, тухайн ажилтны мэдээллийг Холбоонд хүргүүлж, хэрэглэгчээр бүртгүүлэх, программ хангамжид нэвтрэх, ажиллах эрх авах, нууцын баталгаа гаргах;
- 9.2.7 Даатгагчийн мэдээллийн сангийн бүртгэлийн ажилтан өөрчлөгдөх тухай бүр шинэ ажилтныг томилон тухайн ажилтны холбогдох мэдээллийг ажлын 3 өдөрт багтаан Холбоонд хүргүүлэх;
- 9.2.8 Мэдээллийн сангаас олгогдож буй даатгуулагчийн талаарх лавлагаа, мэдээллийг бусдад задруулахгүй байх.

АРАВ. Даатгуулагчийн эрх, үүрэг

10.1 Даатгуулагч дараах эрхтэй:

- 10.1.1 Мэдээллийн сангаас олгогдох лавлагаа, мэдээлэл нь үнэн зөв, бодитой, эх сурвалжид нийцсэн мэдээлэл агуулсан байхыг шаардах;
- 10.1.2 Мэдээллийн сан дахь даатгуулагчийн мэдээлэл нь алдаатай бол нэн даруй засварлах, шинэчлэхийг Холбооноос шаардах.

10.2 Даатгуулагч дараах үүрэгтэй:

- 10.2.1 Даатгуулагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь мэдээллийн сангийн лавлагаанд тусгагдсан мэдээллийн нууцыг хадгалах, гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх;
- 10.2.2 Мэдээллийн сангийн лавлагаанд тусгагдсан мэдээлэл алдаатай болохыг мэдсэн бол энэ талаар даатгагч болон Холбоонд нэн даруй мэдэгдэн өөрчлөлт оруулах.

АРВАН НЭГ. Төрийн холбогдох байгууллагын эрх, үүрэг

11.1 Төрийн холбогдох байгууллага дараах эрхтэй:

- 11.1.1 Хамтран ажиллах гэрээ байгуулсны үндсэн дээр харилцан мэдээлэл солилцохыг Холбооноос шаардах;
- 11.1.2 Жолоочийн даатгалын мэдээллийг хамтран ажиллах гэрээнд заасан нөхцлийн дагуу боловсруулж ирүүлэхийг Холбооноос шаардах.
- 11.2 Төрийн холбогдох байгууллага дараах үүрэгтэй:
 - 11.2.1 Жолоочийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад журмаар хүлээсэн үүргээ биелүүлэх;
 - 11.2.2 Хамтран ажиллах гэрээнд заасан нөхцлийн дагуу үнэн зөв бодитой мэдээллийг тухай бүр мэдээллийн санд нийлүүлэх, харилцан солилцох, гэрээний үүргээ биелүүлэх;
 - 11.2.3 Даатгуулагчийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулахгүй байх.

АРВАН ХОЁР. Хяналт, хариуцлага

- 12.1 Холбоо энэхүү журмын биелэлтэд хяналт тавина.
- 12.2 Энэхүү журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд Хорооноос холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 12.3 Энэ журмаар мэдээллийн санд мэдээлэл ирүүлэх үүрэг хүлээсэн этгээд заасан мэдээллийг тогтоосон хугацаанд, зохих маягт, стандартын дагуу үнэн зөвөөр, бүрэн нийлүүлээгүй нь тогтоогдвол мэдээллийн сангаас мэдээлэл авах эрхийг хязгаарлах хүртэл арга хэмжээг Холбоо авч болно.

--ooOoo--



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 393

Улаанбаатар хот

“Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох заавар”
батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 12^{1.7} дахь хэсгийн заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох заавар”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү зааврыг Жолоочийн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлийг дагаж мөрдөж эхэлсэн өдөр буюу 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Батлагдсан зааврын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН САНГААС НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ ЗААВАР

УХА0410 5043239

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү зааврын зорилго нь Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох, буруутай этгээдээс нөхөн төлбөрийг буцаан нэхэмжлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү заавар нь Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, Иргэний хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 337 тогтоолоор батлагдсан “Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам” болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мөрдөгдөнө.

1.3. Албан журмын даатгагчдын холбоо нь энэхүү зааврыг хэрэгжүүлж ажиллана.

Хоёр. Даатгалын тохиолдол болсныг тогтоох

2.1. Даатгалын тохиолдлыг Замын цагдаагийн акт, тодорхойлолтыг үндэслэн тогтооно.

2.2. Дараах тохиолдолд Шуурхай албаны даатгалын тохиолдлын газар дээрх үзлэгийн тэмдэглэлийг үндэслэн даатгалын тохиолдол болсныг нотолно. Үүнд:

2.2.1. Даатгалгүй болон даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн бол;

2.2.2. Дампуурсан даатгагчийн даатгуулагч этгээд нь гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн бол;

2.2.3. Хохирол учруулсан этгээд тодорхой бус тохиолдолд Замын цагдаагийн тодорхойлолт, даатгалын тохиолдол болсныг гэрчлэх гэрчийн этгээдийн мэдүүлгээр.

2.3. Шуурхай албаны даатгалын тохиолдлын газар дээрх үзлэгийн үеэр буруутай этгээд нь тогтоогдоогүй тохиолдолд Замын цагдын актыг үндэслэнэ.

2.4. Замын цагдаа болон шуурхай алба даатгалын тохиолдолын газарт очоогүй болон очих боломжгүй бол Шуурхай алба болон цагдаагийн байгууллагад мэдэгдсэн дуудлага, тодорхойлолтыг үндэслэн дараах тохиолдолд даатгалын тохиолдол болсныг нотолж болно. Үүнд:

2.4.1. Даатгалгүй болон даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн бол;

2.4.2. Дампуурсан даатгагчийн даатгуулагч нь гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн бол;

2.4.3. Хохирол учруулсан этгээд тодорхой бус тохиолдолд Замын цагдаагийн тодорхойлолт, даатгалын тохиолдол болсныг гэрчлэх гэрчийн этгээдүүдийн мэдүүлгээр (бичгээр).

2.5. Зам тээврийн ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учраагүй, харин эд хөрөнгөд хохирол учруулсан бол жолооч нар харилцан тохиролцсон бол Хууль зүй, дотоод хэргийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2012 оны А/20/21 дүгээр тушаалаар батлагдсан “Даатгалын тохиолдлын тодорхойлолтын маягт”-аар даатгалын тохиолдол болсныг нотолно.

2.6. Хөдөө орон нутагт даатгалын тохиолдол үүссэн тохиолдолд шуурхай алба дуудах боломжгүй бол тухайн орон нутгийн аль нэг даатгалын компанийн салбар болон төлөөлөгч, сумын хэсгийн төлөөлөгч, сумын засаг захиргааны байгууллагад мэдэгдэж тодорхойлолт гаргуулж, ослын байдлыг фото зургаар баталгаажуулж, гэрчийн мэдүүлэг, тодорхойлолт бүрдүүлсэн байна.

2.7. Шуурхай алба нь даатгалын тохиолдолын газарт очих боломжгүй үед дуудлагын оператор нь даатгалын тохиолдол болсныг нотлох баримтыг бүрдүүлэх талаар зааварчилгаа, зөвлөгөө өгч ажиллана.

Гурав. Нөхөн төлбөрийн материалыг хүлээн авах, бүрдүүлэх, хянах

3.1. Нөхөн төлбөрийн материал хүлээн авах, бүрдүүлэх, хянах, нөхөн төлбөр олгох үйл ажиллагааг Даатгалын сангийн хэлтэс хэрэгжүүлнэ.

3.2. Даатгалын сангийн хэлтэс нь Шуурхай албанаас өгсөн “Жолоочийн даатгалын сангийн шуурхай албаны ажиллах журам” –ын даатгалын тохиолдлын талаарх дуудлага хүлээн авах маягт, даатгалын тохиолдлын газар зээрх үзлэгийн тэмдэглэлийг хүлээн авч программын дуудлагын бүртгэлтэй тулгаж баталгаажуулна.

3.3. Даатгалын сангийн хэлтэс нь хохирогч болон буруутай этгээдээс ирүүлсэн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2012 оны А/20/21 дүгээр тушаалаар батлагдсан “Даатгалын тохиолдлын тодорхойлолтын маягт” болон Замын цагдаагийн акт, тодорхойлолтыг хүлээн авч программын дуудлагын бүртгэлтэй тулгаж баталгаажуулна.

3.4. Даатгалын сангийн хэлтэс нь даатгалгүй болон даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээдийн тодорхойлолтыг Мэдээллийн сангийн хэлтэсээс гаргуулна. Даатгагч дампуурсан талаарх тодорхойлолтыг Хорооноос авна.

3.5. Даатгалын сангийн хэлтэс нь нөхөн төлбөрийн материалын бүрдэлийг хариуцах бөгөөд хохирогч, буруутай этгээдтэй холбогдон шаардлагатай материалыг шуурхай бүрдүүлэх талаар ажиллана.

3.6. Хохирогч болон буруутай этгээдээс дараахь материалыг бүрдүүлсэн байна.

3.6.1. Хохирогч болон буруутай этгээдийн өргөдөл (Хохирогч нь байгууллага бол нөхөн төлбөр хүссэн албан бичиг);

3.6.2. Хохирогч болон буруутай этгээдийн иргэний үнэмлэх (Байгууллага бол улсын бүртгэлийн гэрчилгээ);

3.6.3. Даатгалын тохиолдолыг нотлох баримт бичиг;

3.6.4. Хохирлын хэмжээг тогтоосон эрх бүхий этгээдийн дүгнэлт, тодорхойлолт;

3.6.5. Хохирсон эд зүйлийн өмчлөлийг нотлох баримт бичиг;

3.6.6. Даатгалын тохиолдолыг нотлох видео болон фото зураг (Видео болон фото зураг нь нөхцөл байдлыг олон талаас нь бодитоор харагдахуйц, ослын орчны байдлыг бүхлээр болон зам тээврийн осолд өртөгсдийн автотээврийн хэрэгслийн улсын дугаар зэргийг оруулсан байна);

3.6.7. Даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас эрсдсэн бол шүүх эмнэлэгийн дүгнэлт, нас барсны гэрчилгээ, хохирогчийг тодорхойлох нотариатаар баталгаажуулсан баримт бичиг;

3.6.8. Даатгалын тохиолдлын улмаас хүний эрүүл мэнд хохирсон бол холбогдох мэргэжлийн байгууллага, эрх бүхий албан тушаалтны хохирлын хэмжээг тогтоосон акт, дүгнэлт, эм тариа протез худалдан авсан баримт, цалингийн тодорхойлолт, нийгмийн даатгалын дэвтэрийн хуулбар, нийгмийн даатгалаас өвчтөй байх хугацаанд авсан тэтгэмжтэй холбоотой баримт, групп тогтоосон болон тахир дутуугийн зэрэглэл тогтоолгосон тохиолдолд дэвтрийн хуулбар, эмнэлгийн магадлах комиссын шийдвэрийн хуулбар, эмнэлгийн магадлагаа, эмнэлгийн хуудас, амбулатор, эмчилгээ, оношлогоог тодорхой заасан өвчтөний картын хуулбар гэх мэт;

3.6.9. Даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд болон дампуурсан даатгагчийн даатгуулагчийн гэрээ;

3.6.10. Бусад шаардлагатай баримт бичиг.

3.7. Даатгалын сангийн хэлтэс нь шаардлагатай тохиолдолд нөхөн төлбөрийн материалын эх хувийг үзэх, бусад холбогдох байгууллагуудаас дүгнэлт тодорхойлолтыг гаргуулж авсан байна.

3.8. Хохирогчид нөхөн төлбөрийг түргэн шуурхай, саадгүй хугацаанд нь олгож үйлчлэх бөгөөд даатгалын тохиолдолыг нотлох, хохирлын хэмжээг бодиттой тогтоох баримт бичгийг бүрдүүлэхийг хохирогч, буруутай этгээдээс шаардана.

Дөрөв. Нөхөн төлбөр олгох

4.1. Даатгалын сангийн хэлтэс нь нөхөн төлбөрийн материал бүрэн бүрдэж, нөхөн төлбөр олгох үндэслэлтэй гэж үзвэл, нөхөн төлбөр олгох саналаа Захиргаа хуулийн хэлтэст хүргүүлнэ.

4.2. Захиргаа хуулийн хэлтэс нь хохирогч, буруутай этгээдтэй гэрээ байгуулах, нөхөн төлбөр буцаан нэхэмжилэх, нөхөн төлбөрийн барагдуулах үйл ажиллагаанд хяналт тавина.

4.3. Захиргаа хуулийн хэлтэс нь нөхөн төлбөрийн материалыг хянан үзэж, нөхөн төлбөр олгох үндэслэлтэй гэж үзвэл дараах гэрээг байгуулна. Үүнд:

4.3.1. Хохирогчтой энэхүү зааврын 1 дүгээр хавсралтын дагуу “Төлбөр нэхэмжлэх эрхийг шилжүүлэн авах гэрээ”-г байгуулна.

4.3.2. Буруутай этгээдтэй энэхүү зааврын 2 дугаар хавсралтын дагуу “Олгосон нөхөн төлбөр буцаан нэхэмжлэх гэрээ” болон 3 дугаар хавсралтын дагуу “Барьцааны гэрээ”-г байгуулна.

4.4. Захиргаа хуулийн хэлтэс нь энэхүү зааврын 4.3.2-д заасан буруутай этгээдтэй төлбөр буцаан нэхэмжлэх хугацаа, барьцааны зүйл зэргийг тохиролцож, тусгасан гэрээний төсөл болон нөхөн төлбөр олгох саналаа Гүйцэтгэх захиралд танилцуулна.

4.5. Гүйцэтгэх захирал гэрээний төсөл болон нөхөн төлбөр олгох саналыг хянаж үзээд, үндэслэлтэй гэж үзвэл нөхөн төлбөр олгохыг зөвшөөрч гарын үсэг зурна. Гарын үсэг зурснаар энэхүү зааврын 4.3-д заасан гэрээг байгуулж, нөхөн төлбөр олгох тушаал гарна.

4.6. Хохирогчид нөхөн төлбөрийг гүйцэтгэх захирлын тушаалын дагуу холбогдох данснаас олгоно.

4.7. Жолоочийн даатгалын сан нь нөхөн төлбөр олгох үндэслэлгүй гэж үзвэл холбогдох этгээдэд албан бичгээр хариуг өгөх ба үндэслэлийг тодорхой дурьдсан байна.

4.8. Орон нутгийн салбарт нөхөн төлбөр шийдвэрлэх хөрөнгийн дээд хэмжээг Удирдах зөвлөлөөс батлах бөгөөд уг хэмжээнээс давсан тохиолдолд нөхөн төлбөрийн материалыг Даатгалын сангийн хэлтэст ирүүлнэ.

4.9. Даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас хохирсон болон хохирогч хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тохиолдолд нөхөн төлбөрийг Жолоочийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасан жолоочийн даатгалын үнэлгээний дээд хэмжээгээр тооцож, мөн хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу олгоно.

4.10. Даатгалын тохиолдлын улмаас хохирогч хөдөлмөрийн чадвараа хагас алдсан тохиолдолд нөхөн төлбөрийг Жолоочийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасан жолоочийн даатгалын үнэлгээний хэмжээнд багтаан баримтаар нотлогдсон бодит зардлын дүнгээр, мөн хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу олгоно.

4.11. Даатгалын тохиолдлын улмаас эд хөрөнгөд хохирол учирсан тохиолдолд нөхөн төлбөрийг даатгалын хохирол үнэлэгчийн дүгнэлт, тодорхойлолтыг үндэслэн Жолоочийн даатгалын тухай хуулийн 9.1-д заасан жолоочийн даатгалын үнэлгээний хэмжээнд багтаан, мөн хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу олгоно.

Тав. Нөхөн төлбөр буцаан нэхэмжилэх

5.1. Даатгалын сангийн хэлтэс нь буруутай этгээдээс буцаан нэхэмжилэх гэрээний дагуу төлбөрийг хугацаанд нь төлж байгаад хяналт тавих ба буруутай этгээд үүргээ биелүүлэхгүй тохиолдолд Захиргааны хуулийн хэлтэст мэдэгдэнэ. Захиргаа хуулийн хэлтэс нь холбогдох баримт бичгийг бүрдүүлж, хууль хяналтын байгууллагад хандаж нөхөн төлбөр барагдуулах арга хэмжээ авч ажиллана.

5.2. Буруутай этгээд энэхүү зааврын 4.3.2-т заасан гэрээг байгуулаагүй тохиолдолд тухай бүр нь холбогдох баримт бичгийг бүрдүүлж, хяналтын байгууллагад хандана.

Зургаа. Нөхөн төлбөрийн мэдээллийн сан

6.1. Мэдээллийн сангийн хэлтэс нь даатгалын тохиолдол, даатгалын тохиолдолын дуудлага, хохирогч, буруутай этгээдийн мэдээлэл, хохирлын хэмжээ, олгосон нөхөн төлбөр, буцаан төлөлт, болон нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа түүнд хяналт тавихад холбоотой нөхөн төлбөрийн мэдээллийн сангийн бүртгэл хөтөлнө.

Долоо. Хяналт, хариуцлага

7.1. Олгосон нөхөн төлбөр болон буцаан нэхэмжилсэн төлбөрийн төлөлтийн тайланг улирал бүр Хороо болон Холбооны удирдах зөвлөлд танилцуулна.

7.2. Хороо нь энэхүү зааврын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oO---

Төлбөр нэхэмжлэх эрхийг шилжүүлэн авах гэрээ

20..... онысарынөдөр

Нэг талаас Албан журмын даатгагчдын холбоо /эрх шилжүүлэн авагч гэнэ/-ыг төлөөлж хэлтэст..... ажилтай овогтой, нөгөө талаас,овогтой /цаашид эрх шилжүүлэгч гэнэ/ нар харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хуулийн 123 дугаар зүйл, 444.5, 444.6-дахь заалтыг үндэслэн “Жолоочийн даатгалын тухай” хуулийн 18-р зүйлд заасан даатгалын тохиолдол үүсэхэд Албан журмдын даатгагчдын холбоо эрх шилжүүлэгчид учирсан хохирлыг барагдуулах, эрх шилжүүлэгч нь буруутай этгээдээс хохирол нэхэмжлэх эрхээ Албан журмын даатгагчдын холбоонд шилжүүлэхээр харилцан тохироцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний зорилго

Энэхүү гэрээний зорилго нь “Жолоочийн даатгалын тухай” хуулийн 18-р зүйлд заасан даатгалын тохиолдолын улмаас хохирогчид үүссэн хохирлыг Жолоочийн даатгалын сангаас барагдуулах, хохирогч нь өөрт учирсан хохирлыг нэхэмжлэх эрхээ Албан журмын даатгагчдын холбоонд шилжүүлэхтэй холбоотой эрх зүйн харилцааг харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Эрх шилжүүлэн авагчийн эрх үүрэг

2.1. Даатгалын тохиолдлын улмаас үүссэн хохиролын хэмжээг үнэн зөв тогтооход шаардлагатай мэдээллийг хохирогчоос гаргуулан авах эрхтэй.

2.2. Жолоочийн даатгалын тухай хуулийн 16.1-д заасан хугацаанд хохирол үнэлэгчийг томилно.

2.3. Жолоочийн даатгалын тухай хуулийн 16.1-д заасны дагуу үнэлгээний зардлыг төлнө.

2.4. Жолоочийн даатгалын хуулийн 19.2, 19.3-д заасан хугацаанд нөхөн төлбөрийг барагдуулна.

2.5. Хохирол төлөх үнэлгээний тооцооллыг хуулийн хүрээнд бүрэн хийж дууссны дараа нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх эрх шилжүүлэх гэрээ байгуулна.

Гурав. Эрх шилжүүлэгчийн эрх үүрэг.

3.1. Хохирогч өөрт учирсан хохирлыг нотлох бүх мэдээллийг үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй.

3.2. Даатгалын сангаас хохирлын үнэлгээний тооцоолол бүрэн хийгдэж, нөхөн төлбөр олгох нь тодорхой болсон нөхцөлд , буруутай этгээдээс хохирлыг буцаан нэхэмжлэх эрхээ шилжүүлэх гэрээ хийнэ.

3.2. Нөхөн төлбөрийг олгосны дараа эрх бүхий байгууллагуудын шийдвэрээр жолооч гэм буруугүй нь тогтоогдвол жолоочийн сангаас авсан нөхөн төлбөрийг үл маргах журмаар буцаан шилжүүлнэ.

3.3. Нөхөн төлбөр авсан хохирогч нь Жолоочийн даатгалын санд буруутай этгээдээс нөхөн төлбөрийг эргэн төлүүлэх явцад өөрөөс шалтгаалах ажилд идэвхитэй оролцож, хамтран ажиллана.

Дөрөв. Хүлээх хариуцлага.

4.1. Маргаантай асуудал гарвал талууд зөвшилцөлийг баримтлах бөгөөд эс чадвал Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шүүхээр шийдвэрлүүлнэ.

Тав. Гэрээний хүчинтэй болох үйлчлэх хугацаа

5.1. Энэхүү гэрээнд 2 тал гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчинтэйд тооцно.

Гэрээг байгуулсан:

Эрх шилжүүлэн авагчийг төлөөлж:

Эрх шилжүүлэгчийг төлөөлж:

.....ХЭЛТЭСТ

.....ОВОГТОЙ.....

ажилтай:.....

РД:.....

овогтой.....

ИҮ:.....

Хаяг.....

Хаяг:

Утас:

Утас:

Гарынүсэг.....

Гарынүсэг.....

Олгосон нөхөн төлбөрийн буцаан нэхэмжлэх гэрээ

Дугаар.....

20... оны...сарын...өдөр

.....хот,аймаг

..... овогтой..... нь 20... оны ... сарын өдөр
иргэн овогтой д
 улмаас төгрөгийн хохирол учруулсан нь
-аар нотлогдсон бөгөөд уг хохирлыг Албан журмын даатгагчдын
 холбооноос хохирогчид нөхөн төлж Даатгалын хуулийн 8.7-д заасны дагуу буруутай этгээдээс
 нэхэмжлэх эрхийг Албан журмын даатгагчдын холбоо шилжүүлж авсан болно. Нэг талаас Албан
 журмын даатгагчдын холбоо, нөгөө талаасовогтой.....
 нар..... төгрөгийн хохирлыг доорхи хугацаанд даатгалын санд буцааж төлөхөөр
 харилцан тохиролцож хэлцэл байгуулав.

Д/д	Огноо	Барагдуулах дүн	Тайлбар
1			
2			
3			
4			
5			
6			

Тамга

Албан журмын даатгагчдын холбооны албан тушаалтан

Энэхүү төлбөр төлөх үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар өөрийн өмчлөлийн

 нэр бүхий хөрөнгийг барьцаалан, барьцаанд тавьсан хөрөнгийг эзэмших эрхийн гэрчилгээг
 Албан журмын даатгагчдын холбоонд шилжүүлж, дээр дурдсан төлбөрийг хугацаанд нь буцаан
 төлөх үүргийг биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд барьцаалагдсан эд
 хөрөнгийг Албан журмын даатгагчдын холбоонд үл маргах журмаар шилжүүлэхийг хүлээн
 өвшөөрч байна.

.....овогтой.....
 Хаяг:.....
 Регистрийн дугаар.....
 Гарын үсэг...../...../

БАРЬЦААНЫ ГЭРЭЭ

№

.....

.....

/он, сар, өдөр/

/үйлдсэн газар/

Иргэний хуулийн 156-160 дугаар зүйлийг үндэслэн нэг талаас Албан журмын даатгагчдын холбоо /цаашид барьцаалагч гэнэ/, нөгөө талаас-д оршин суух -ийн /цаашид барьцаалуулагч гэнэ нар харилцан тохиролцож доорх нөхцөлтэйгээр энэхүү гэрээг байгуулав.

1. Барьцаалагч , болон барьцаалуулагч нарын хооронд 20... оны дугаар сарын-ны өдөр байгуулсан төгрөгийн нөхөн төлбөр буцаан нэхэмжлэх гэрээний барьцаанд төгрөгийн үнэ бүхий /хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийн нэр, үнэ/
.....

/мөнгөний үнэ, тоо, үсгээр/

Хөрөнгийг барьцаалахыг зөвшөөрч байна.

2. Барьцааны хөрөнгийн талаарх мэдээлэл:

Нэр:

Оршин суугаа хаяг:

Улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээний дугаар

Өөр юу барьцаалж байгаа:

Чанар /сайн, дунд, мууалин болох/

Үнэлгээ: Харилцан тохиролцсон үнэ

3. Барьцааны хөрөнгө хэнд хадгалагдах: /барьцаалагч, барьцаалуулагч/

4. Барьцаалагч барьцааны хөрөнгийг ашиглаж болох эсэх

5. Барьцаалуулагч дээр дурдсан төлөх ёстой нөхөн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Иргэний хуулийн 453.1 дэх хэсэгт заасны дагуу хугацаа хэтэрсний хүү, гэрээгээр харилцан тохирсон бол нэмэгдүүлсэн хүү төлөх үүрэгтэй.

6. Барьцаалуулагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд барьцааны зүйлийг үл маргах журмаар барьцаалагчид шилжүүлэх ба барьцааны зүйлийг Иргэний хуулийн 453.2 дахь хэсгийн заалтын дагуу гэрээний хугацаа дууссан өдрөөс эхлэн барьцаалагч захиран зарцуулах эрхтэй.

7. Бусад нөхцөл:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:



БАРЬЦААЛАГЧ:

БАРЬЦААЛУУЛАГЧ:

Энэхүү гэрээ 2 талын гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж үүргийн гүйцэтгэл бүрэн хангагдсан нөхцөлд, эсхүл 20... оны сарын –ны өдөр дуусгавар болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:



ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ:

БАТАЛГАА ГАРГАГЧ:





МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 394

Улаанбаатар хот

┌ “Монре даатгал” ХХК-д дүрмийн сан ┐
/хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээндээ
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монре даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг тус компанийн хувь нийлүүлэгч болох иргэн Р.Туяацэцэгийн нийт 500,000,000 /Таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
	Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
У.Сийлэн	832,540,000.0	-	832,540,000.0	41.6%
Р.Туяацэцэг	467,460,000.0	500,000,000.0	967,460,000.0	48.4%
П.Ганзориг	200,000,000.0	-	200,000,000.0	10.0%
Нийт	1,500,000,000.0	500,000,000.0	2,000,000,000.0	100.0%

2. Дүрмийн сангийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2012 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Монре даатгал” ХХК /П.Ганзориг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001301



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 395

Улаанбаатар хот

“Соёмбо даатгал” ХХК-д дүрмийн сан
/хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээндээ
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Соёмбо даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг тус компанийн 2011 оны хуримтлагдсан ашиг 156,000,000 /Нэг зуун тавин зургаан сая/ төгрөг, 2012 оны тайлангаар хүлээгдэж буй ашиг 344,000,000 /Гурван зуун дөчин дөрвөн сая/ төгрөг, нийт 500,000,000 /Таван зуун сая/ төгрөгөөр тус тус нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	Ч.Сайнзаяа	548 456 000.0	177 100 000.0	725 556 000.0	35.42%
2	Ц.Баттулга	500 000 000.0	161 450 000.0	661 450 000.0	32.29%
3	Ч.Батцогт	500 000 000.0	161 450 000.0	661 450 000.0	32.29%
	Нийт	1 548 456 000.0	500 000 000.0	2 048 456 000.0	100.0%

2. Дүрмийн сангийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2012 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Соёмбо даатгал” ХХК /Б.Мөнхтуяа/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

002005



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 396

Улаанбаатар хот

“Улаанбаатар хотын даатгал” ХХК-д дүрмийн сан
/хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээндээ
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг тус компанийн хувь нийлүүлэгч Ц.Чинбатын 375,000,000 /Гурван зуун далан таван сая/ төгрөг, хувь нийлүүлэгч М.Энхболдын 125,000,000 /Нэг зуун хорин таван сая/ төгрөг, нийт 500,000,000 /Таван зуун сая/ төгрөгөөр тус тус нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	Ц.Чинбат	1 085 000 000.0	375 000 000.0	1 460 000 000.0	73.0%
2	М.Энхболд	375 000 000.0	125 000 000.0	500 000 000.0	25.0%
3	“Улаанбаатар сан” ХХК	40 000 000.0	-	40 000 000.0	2.0%
	Нийт	1 500 000 000.0	500 000 000.0	2 000 000 000.0	100.0%

2. Дүрмийн сангийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2012 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Улаанбаатар хотын даатгал” ХХК /М.Энхболд/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 397

Улаанбаатар хот

“Мандал женерал даатгал” ХХК-д дүрмийн сан
/хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээндээ
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Мандал женерал даатгал” ХХК-ийн дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээг тус компанийн нийт 1,000,000,000.0 /нэг тэрбум/ төгрөгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1	Монголия Гровт Групп Лимитэд	5,240,000,000.0	1,000,000,000.0	6,240,000,000.0	100.0%
	Нийт	5,240,000,000.0	1,000,000,000.0	6,240,000,000.0	100.0%

2. Дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг

2013 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Мандал генерал даатгал” ХХК /М.Давааням/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 398

Улаанбаатар хот

“Дархан гурил тэжээл” ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдээс
гаргасан саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Компанийн тухай хуулийн 57.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11.2, 34.1.8, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-ын 2.1 дэх хэсгийн заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Дархан гурил тэжээл” ХК-ийн нийт гаргасан 614,603 ширхэг хувьцааны 64.82 хувь буюу 398,386 ширхэг хувьцааг эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээд болох С.Намсрайжав, Д.Балдан-Очир, Б.Түвшинтөр, Б.Түвшинжаргал, Г.Баярт нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 35.18 хувь буюу 216,217 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 1,032 /нэг мянга гучин хоёр/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2012 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоног байхаар тогтоосугай.

2. “Дархан гурил тэжээл” ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдээс бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах санал гаргах ажиллагаатай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг төлөөлж буй этгээд /С.Намсрайжав /-д үүрэг болгосугай:

1/ Компанийн тухай хуулийн 57.3-т заасны дагуу хувьцааг худалдан авах саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, худалдан авах саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт багтаан худалдан авах саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг мөрдөж ажиллах.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН